



USAID
FROM THE AMERICAN PEOPLE



ГРЕГУАР ДЮБУА

ХАВСРАЛТ 4: АЗИД БИОЛОГИЙН ТӨРӨЛ БОЛОН ТҮҮНИЙ АМЬДРАХ НУТАГ ДЭВСГЭРТ ШУГАМАН ДЭД БҮТЦИЙН НӨЛӨӨЛӨЛ

МЭДЭГДЭЛ: Энэхүү нийтлэлд илэрхийлсэн зохиогчийн үзэл бодол нь оролцогч талуудын өгсөн бэлэн мэдээлэлд тулгуурласан бөгөөд АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг эсвэл Америкийн Нэгдсэн Улсын засгийн газрын үзэл бодлыг тусгасан байх шаардлагагүй юм. Энэ тайлангийн англи хувилбар нь албан ёсны хувилбар болно. Уг тайлангийн орчуулгын хувилбарыг хүсэлтийн дагуу өгнө.

ГАРЧИГ

ТОВЧЛОЛ	I
УДИРТГАЛ	2
АРГА БАРИЛУУД	4
ҮР ДҮНГ ТАЛААРХ ДҮГНЭЛТ	7
ШУГАМАН ДЭД БҮТЦИЙН ТӨРӨЛ ТУС БҮРЭЭР ҮР ДҮНГ ХАРУУЛАВ: АВТО ЗАМ	II
ЗЭРЛЭГ АН АМЬТАНД АВТО ЗАМЫН НӨЛӨӨЛӨЛ	II
E1: АВТО ЗАМЫН ШУУД НӨЛӨӨЛӨЛ	II
E2: ЗАМЫН ШУУД БУС НӨЛӨӨЛӨЛ	13
E3: АВТО ЗАМЫН ПОПУЛЯЦЫН ТӨВШНИЙ ШУУД БА ШУУД БУС НӨЛӨӨЛӨЛ	15
АВТО ЗАМЫН ЗҮГЭЭС ЗЭРЛЭГ АН АМЬТАНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙГ БАГАСГАХ	19
M1: АМЬТНЫ ЗАН ТӨЛӨВИЙГ ӨӨРЧИЛСНӨӨР АВТО ЗАМЫН НӨЛӨӨЛЛИЙГ ХӨНГӨВЧЛӨХ АРГА ХЭМЖЭЭ	19
M2: ХҮНИЙ ЗАН ТӨЛӨВИЙГ ӨӨРЧЛӨХ ЗАМААР АВТО ЗАМЫН НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ	20
M3: АМЬТДЫГ ЗАМААС ТУСГААРЛАДАГ ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ	21
ДҮГНЭЛТ: АВТО ЗАМУУД	23
ҮР ДҮНГ ШУГАМАН ДЭД БҮТЦИЙН ХЭЛБЭРЭЭР ХАРУУЛАВ: ТӨМӨР ЗАМ	24
ТӨМӨР ЗАМЫН АН АМЬТДАД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ	24
E1: ТӨМӨР ЗАМЫН ШУУД НӨЛӨӨ	24
E2: ТӨМӨР ЗАМЫН ШУУД БУС НӨЛӨӨ	25
E3: ПОПУЛЯЦЫН ТӨВШНИЙ ТӨМӨР ЗАМЫН ШУУД БА ШУУД БУС НӨЛӨӨЛӨЛ	26
ЗЭРЛЭГ АМЬТДАД ҮЗҮҮЛЭХ ТӨМӨР ЗАМЫН НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ	29
M1: АМЬТНЫ ЗАН ТӨЛӨВИЙГ ӨӨРЧЛӨХ ЗАМААР ТӨМӨР ЗАМЫН НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ	29
M2: ХҮНИЙ ЗАН ТӨЛӨВИЙГ ӨӨРЧЛӨХ ЗАМААР ТӨМӨР ЗАМЫН ОСОЛ ЭНДЭГДЛИЙГ БУУРУУЛАХ	30
M3: АМЬТНЫГ ТӨМӨР ЗАМААС ТУСГААРЛАХ ТӨМӨР ЗАМЫН НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ	31
ДҮГНЭЛТ: ТӨМӨР ЗАМ	32
ҮР ДҮНГ ХЭЛБЭРЭЭР: ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ШУГАМ	33
ЦАХИЛГААНЫ ШУГАМЫН АН АМЬТДАД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ	33
E1: ЦАХИЛГААНЫ ШУГАМЫН ШУУД НӨЛӨӨ	33
E2: ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ШУГАМЫН ШУУД БУС НӨЛӨӨ	35
E3: ПОПУЛЯЦЫН ТӨВШНИЙ ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ШУГАМЫН ШУУД БА ШУУД БУС НӨЛӨӨЛӨЛ	35
ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ШУГАМЫН ЗҮГЭЭС АН АМЬТДАД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ	36
M1: АМЬТНЫ ДАДАЛ, ЗАН ТӨЛӨВИЙГ ӨӨРЧЛӨХ ЗАМААР ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ШУГАМЫН НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ	36
M2: ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ШУГАМААС АМЬТДЫГ ТУСГААРЛАХ ЗОРИЛГОТой ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ШУГАМЫН НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ	36
ДҮГНЭЛТ: ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ШУГАМ	37

АНХААРАЛ ТАТСАН ТӨРӨЛ ЗҮЙЛ БА ТАКСОНОМИЙН АНГИЛАЛ ЗҮЙ	39
АЗИЙН ЗААН	39
ФЭЛИДҮҮД	42
ПРИМАТ БУЮУ САРМАГЧИНУУД	44
ТУУРАЙТНУУД	47
ХЭВЛИЙГЭЭР ЯВАГЧ ХОЁР НУТАГТНУУД	49
ХОЁР НУТАГТАН	50
ҮНДСЭН ОЛОЛТУУД	53
АВТО ЗАМ	53
ТӨМӨР ЗАМ	54
ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ШУГАМ	55
ЗӨВЛӨМЖҮҮД	56
АЗИ ДАХЬ ШУГАМАН ДЭД БҮТЦИЙН НӨЛӨӨЛЛИЙН ТАЛААРХ ИРЭЭДҮЙН СУДАЛГААНЫ ЗӨВЛӨМЖ	56
АЗИ ДАХЬ ШУГАМАН ДЭД БҮТЦИЙН НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ САНАЛ БОЛГОЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭ	59
ТАЛАРХАЛ	61
ИШЛЭЛ МАТЕРИАЛУУД	62
ХАВСРАЛТУУД	79
ХАВСРАЛТ А: АЗИД АМЬТАН-ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН МӨРГӨЛДӨӨНД ТЭМДЭГЛЭГДСЭН, БАРИМТЖУУЛСАН ЗҮЙЛИЙН ЖАГСААЛТ	79
ХАВСРАЛТ В: ЗЭРЛЭГ АМЬТАНД АВТО ЗАМЫН ШУУД БУС НӨЛӨӨНИЙ СУДАЛГААНЫ ТОЙМ АЗИЙН ХЭМЖЭЭНД ХАРЬЦАНГУЙ БАГА БАЙДАГ	139
ХАВСРАЛТ С: ЗЭРЛЭГ АН АМЬТАНД АВТО ЗАМЫН НӨЛӨӨЛӨХ ШУУД БА ШУУД БУС НӨЛӨӨГ ТОМ ХЭМЖЭЭНД СУДЛАХ ТОЙМ НЬ АЗИЙН ТОО ТОЛГОЙТОЙ ХОЛБООТОЙ БАЙДАГ	143
ХАВСРАЛТ D: ЗЭРЛЭГ АМЬТНЫ ГАРЦЫН ЗОРИУЛАЛТААР ТУСГАЙЛАН БАРИАГҮЙ ЗЭРЛЭГ АМЬТДЫН ГҮҮР, ЗЭРЛЭГ АМЬТДЫН ГАРЦ, БҮТЦИЙГ АШИГЛАН АВТО ЗАМЫГ ГАТАЛДАГ ТӨРӨЛ ЗҮЙЛҮҮДИЙН БАРИМТЫН ЖАГСААЛТ	149
ХАВСРАЛТ E: АЗИД ГАЛТ ТЭРГЭНД ЦОХИУЛСАН БАРИМТТАЙ ТӨРӨЛ ЗҮЙЛҮҮДИЙН ЖАГСААЛТ	153
ХАВСРАЛТ F: ЗЭРЛЭГ АМЬТАНД ТӨМӨР ЗАМЫН ШУУД БУС НӨЛӨӨНИЙ СУДАЛГААНЫ ТОЙМ АЗИЙН ХЭМЖЭЭНД ХАРЬЦАНГУЙ БАГА БАЙДАГ	154
ХАВСРАЛТ G: ЗЭРЛЭГ АН АМЬТАНД ТӨМӨР ЗАМЫН НӨЛӨӨЛӨХ ШУУД БА ШУУД БУС НӨЛӨӨГ ТОМ ХЭМЖЭЭНД СУДЛАХ ТОЙМ НЬ АЗИЙН ТОО ТОЛГОЙТОЙ ХОЛБООТОЙ БАЙДАГ	156
ХАВСРАЛТ H: ЗЭРЛЭГ АМЬТНЫ ГАРЦЫН ЗОРИУЛАЛТААР ТУСГАЙЛАН БАРИАГҮЙ ЗЭРЛЭГ АМЬТДЫН ГҮҮР, ЗЭРЛЭГ АМЬТДЫН ГАРЦ, БҮТЦИЙГ АШИГЛАН ТӨМӨР ЗАМЫГ ГАТАЛДАГ ТӨРӨЛ ЗҮЙЛҮҮДИЙН БАРИМТЫН ЖАГСААЛТ	158
ХАВСРАЛТ I: АВТО ЗАМЫН ТАЛААР АШИГЛАСАН МАТЕРИАЛ	160
ХАВСРАЛТ J: ТӨМӨР ЗАМЫН ТАЛААРХ НОМ ЗҮЙ	177
ХАВСРАЛТ K: ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ШУГАМЫН ТАЛААР НОМ ЗҮЙ	181

ЗУРГУУД

Зураг1. 2000-2020 оны хооронд авто зам, төмөр зам, цахилгаан дамжуулах шугамын талаар Азийн судалгаануудын тоо.....	7
Зураг2. 2000-2020 оны хооронд Азид авто зам, төмөр зам, цахилгаан дамжуулах шугамын чиглэлээр бичигдсэн шинжлэх ухааны баримт материалуудын тооны түр хугацааны чиг хандлага.	8
Зураг3. 2000-2020 оны хооронд Азийн орнуудад (a) авто зам (b) төмөр зам (c) цахилгаан дамжуулах шугамын чиглэлээр бичигдсэн шинжлэх ухааны судалгаануудын тоо. Долоон оронд шугаман дэд бүтцийн төрлийн гурван чиглэлээр судалгаа байхгүй байсан учраас зурагт оруулаагүй.....	8
Зураг4. Азид 2000-2020 оны хооронд шугаман дэд бүтцийн гурван үндсэн төрөлтэй (A) холбоотой судалгаануудын тоо, шугаман дэд бүтцэд нөлөөллийн арга хэмжээний гурван үндсэн төрөлтэй холбоотой судалгааны тоо (B), сээр нуруугүйтэн, хоёр нутагтан, мөлхөгчид, шувуу, хөхтөн амьтдын талаар хийсэн судалгааны тоо (C).....	10
Зураг5. Зэрлэг ан амьтан ба галт тэрэгний мөргөлдөөнийг технологийн үндсэн дээр бууруулах үндсэн ойлголтын механизм.	30

ТОВЧЛОЛ

ASEAN	Зүүн Өмнөд Азийн бүс нутгийн хамтын ажиллагааны нийгэмлэг
AVC	Амьтан тээврийн хэрэгсэлд мөргүүлэх
BACI	Хяналтын нөлөөллийн өмнө болон дараа
BRI	БҮС БА ЗАМ САНААЧИЛГА
GIS	Газар зүйн мэдээллийн систем
IUCN	Байгаль хамгаалах олон улсын холбоо
LI	Шугаман дэд бүтэц
USAID	АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг
USD	АНУ-ын доллар
WFLI	Зэрлэг Амьтанд Ээлтэй Шугаман Дэд Бүтэц
WoS	Шинжлэх ухааны веб сайт

УДИРТГАЛ

Биологийн төрөл зүйлийн мөхөл тааварлашгүй хэмжээгээр эрчимжиж байна(McCallum, 2015). Ойролцоогоор дэлхийн хуурай газрын 50-70 нь хүний үйл ажиллагааны нөлөөгөөр(Ceballos et al., 2015), өөрчлөгдсөн, дэлхий дахинд биологийн төрөл зүйл болон эко системийн үйл ажиллагаа өөрчлөгдөж байна(Mace & Baillie, 2007). Биологийн төрөл зүйлийн мөхлийн үндсэн шалтгаан бол хуурай газрын ашиглалт, өөрчлөлт, байгалийн бохирдол, цаг уурын өөрчлөлт, дэд бүтцийн хөгжил (Butchart et al., 2010; Sala, 2000) юм.

Хүний нийгмийн сайн сайхны төлөө зайлшгүй шаардлагад суурилсан шугаман дэд бүтцийн хөгжил нь экологийн болон байгаль орчны доройтлын гол түлхэц хүчин зүйл болж байна. Нийгэм эдийн засгийн болон байгаль орчны харилцан нөлөөлөл нь халуун орны бүс нутагт эрчимтэй байдаг(Goosem, 2007; Laurance et al., 2009). Азид USAID нь авто зам, төмөр зам, цахилгаан дамжуулах шугам зэрэг шугаман дэд бүтцийн гурван салбарын хөгжлийн явцад биологийн төрөл зүйлийг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхийн тулд улс орнуудын чадавхыг тодорхойлох, үнэлэх, сайжруулахыг эрмэлзэж байна.

Ази бол биологийн төрөл зүйлийн маш чухал нөөц, амьдралын олон хэв маяг зэрэгцэн оршсон өлгийн нутаг юм (Peh, 2010). Тус тив бол дэлхийн нэн чухал 25 биологийн төрөл зүйлийн өлгий нутаг юм. тухайлбал Энэтхэгийн баруун хэсгийн Гаат, Шри Ланкийн арал, Хятадын баруун өмнөд хэсэг, хэд хэдэн нутгийн дамнан орших Гималайн хормой зэрэг болно(Myers et al., 2000). Ази бол биологийн нарийн нийлмэл, биологи ба газар талаасаа маш олон хэв маягийг хадгалсан учраас төрөл биологийн төрөл зүйл, байгалийн бүлгэмээр өвөрмөц, баян газар орон юм(Hughes, 2017).

Ази тив нь уулсаас эхлээд халуун орон хүртэл өөр хоорондоо онцгой ялгаатай экологийн 18 бүс нутгуудаас бүрддэг(IPBES, 2018). Хүний үйл ажиллагааны өргөжин тэлэх нөлөөлөл бол экологийн олон бүс нутагт зэрлэг ан амьтан, биологийн төрөл зүйлд хор хохирол учруулаад зогсохгүй хуваагдсан, тухайн амьтан, төрөл зүйл гадаад нөлөөлөлд автсан нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөхөд хүргэдэг(Tucker et al., 2018; Venter et al., 2016). Халуун орны ойн олон давхаргатай иж бүрэн бүтцийн дотор амьдарч байгаа экологийн төрөлжилтийн улмаас халуун орны систем нь хүний үйл ажиллагаа, нөлөөлөлд маш эмзэг байдаг ба хүний үйл ажиллагааны нөлөөллийн улмаас биологийн төрөл зүйлүүд ойгоос дайжих, үргэхэд хүрдэг(Laurance et al., 2009).

Азийн бүс нутаг бол нийгэм, эдийн засаг, улс орны тогтвортой хөгжилд чухал үүрэгтэй эрчим хүч, ус, ой зэрэг нөөцөөр баялаг. Одоогоор эдгээр эко систем болон байгалийн нөөцөд өргөжин тэлж байгаа шугаман дэд бүтэц, зохицуулалтгүйгээр байгалийн нөөц баялгийг ухах зэргээс аюулд өртөж, үүний улмаас байгаль орчин их хэмжээгээр доройтох, цаашлаад тухайн нөөцөд тулгуурлан амьдардаг амьжиргаа, амин зуулга аюулд орж байна.

Ази бол олон улсын хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр шинэ дэд бүтцийг барьж байгуулахад маш их хэмжээний хөрөнгө оруулалт хийж эхэлж байна(Callaghan & Hubbard, 2016). Азийн Хөгжлийн Банкны тооцоогоор Азийн бүс нутгийн хөгжлийн хурдыг хадгалах, ядуурлыг бууруулах, цаг уурын өөрчлөлтөд арга хэмжээ авах зэрэгт 2030 он хүртэл нэг жилд дэд бүтцийн салбарын хөрөнгө оруулалтад 1,7 их наяд ам доллар шаардлагатай(Asian Development Bank, 2017). Эрчим хүч (56 хувь), тээвэр бол (32 хувь) хөрөнгө оруулалт шаардлагатай гол хоёр салбар юм. АНУ-ын Эрчим Хүчний Мэдээллийн Газрын Төсөлд зааснаар дэлхийн эрчим хүчний зарцуулалт 2018-аас 2050

оны хооронд бараг 50 хувиар өснө гэжээ(U.S. Energy Information Administration, 2020). Азийн өөр нэг асуудал бол Хятадын Бүс ба Зам Санаачилга (BRI)-ын тооцоноор 5 триллион ам долларын өртгөөр дэлхийн 65 орон хуурай газар болон далайгаар холбогдоно(Cai, 2017). BRI-ийн хэрэгжүүлж байгаа биологийн төрөл зүйлд байгаль орчны үр дагавар, нөлөөллийг сааруулахад ажил юм(Ascensão et al., 2018; Hughes et al., 2020; Lechner et al., 2018).

Шууд хорогдлын нөлөөллөөс гадна шугаман дэд бүтцийн систем нь зэрлэг ан амьтан болон түүний нутаг дэвсгэрт олон шууд бус нөлөөлөл үзүүлдэг. Тухайлбал хүний үйл ажиллагаанаас үүссэн дарамт (ан агнуур, хөгжил, уул уурхайн нөлөөлөл), нутаг дэвсгэрээсээ дайжих, хуваагдах, нутаг дэвсгэрээ алдах, амьтны тохиолдоц өөрчлөгдөх, зан төлөв өөрчлөгдөх гэх мэт(Biasotto & Kindel, 2018; Fearnside & de Alencastro Graça, 2006; Wilkie et al., 2000). Тэргүүн шугамын бусад үйл ажиллагааг эрчимжүүлэг, хүний суурьшлыг нэмэгдүүлэх зэрэг тээврийн дэд бүтцийн хөгжил бол халуун орны цөлжилт, ойгүйжилтын гол шалтгаан гэж тодорхойлогддог(Geist & Lambin, 2002; Laurance et al., 2015). Төлөвлөгөөт болон ирээдүйн хөгжилд шинжлэх ухаанд суурилсан стратегийг мэдээлэхэд Азид шугаман дэд бүтцийн зүгээс зэрлэг ан амьтанд үзүүлэх ерөнхий нөлөөллийн талаарх ойлголт болон Азид шугаман дэд бүтцийн хашир хянамгай төлөвлөгөө шаардлагатай.

Хөгжиж байгаа орнууд болон температурын өөрчлөлтөд өртсөн бүс нутгуудаас шугаман дэд бүтцийн зүгээс зэрлэг ан амьтанд үзүүлэх нөлөөллийн хяналт шалгалтыг хийсээр байна(Kociolek et al., 2011; Taylor & Goldingay, 2010; Trombulak & Frissel, 2000). Цаашилбал, замын нөлөөлөл нь бусад экосистемийн төрлүүдээс халуун орны бүс нутагт чанарын болон тоон хувьд ялгаатай байдаг(Laurance et al., 2009; Pinto et al., 2020). Иймээс эдгээр нөлөөллийг ойлгох эсвэл эдгээр нөлөөлөл байхгүй байх нь Азид илүү тохиромжтой дэд бүтцийн шугаман төлөвлөлт, бууруулах арга хэмжээг удирдахад тусална. Бид Ази дахь зэрлэг ан амьтдын бүлгүүдэд шугаман дэд бүтцийн нөлөөллийн талаарх одоо байгаа судалгааг хянаж, нөлөөллийг бууруулах арга хэмжээг тодорхойлсон болно. Бид өөрсдийн олж авсан мэдлэг, дүгнэлтээ бидний мэдлэгийн бааз, суурийг сайжруулах зөвлөмж, мэдлэгийг онцлох үндсэн дүгнэлтүүдтэй уялдуулдаг. Бид өөрсдийн олж авсан мэдлэг, дүгнэлтээ бидний мэдлэгийн бааз, суурийг сайжруулах зөвлөмж, мэдлэгийг онцлох үндсэн дүгнэлтүүдтэй уялдуулдаг. Ази тивийн баялаг биологийн олон янз байдалд шугаман дэд бүтцийн нөлөөг нэгтгэн, нэгтгэх анхны оролдлого нь тэдний нөлөөг бууруулах шинжлэх ухааны үндэслэлтэй шийдлийг ахиулах зорилготой юм.

АРГА БАРИЛУУД

Төслийн хамрах хүрээг дагаж мөрдөхийн тулд “Ази” гэсэн судалгааны хүрээлэлд дараах 28 орныг хамруулсан. Үүнд: Афганистан, Бангладеш, Бруней, Бутан, Камбож, Хятад, Энэтхэг, Индонез, Япон, Казахстан, Киргизстан, Лаос, Малайз, Монгол, Мьянмар, Балба, Хойд Солонгос, Пакистан, Филиппин, Сингапур, Шри Ланка, Өмнөд Солонгос, Тажикстан, Тайланд, Зүүн Тимор, Туркменистан, Узбекистан, Вьетнам. Холбогдох салбарын баримт бичгүүдийг системтэй хайх, хянаж үзэх ажлыг шинжлэх ухааны тэргүүлэх хайлт, аналитик мэдээллийн сан болох Clarivate Шинжлэх ухааны аналитикийн веб™ (WoS) дээр хийсэн(Li et al., 2018). Бид энэхүү мэдээллийн баазыг дэвшилтэт, хяналттай хайлт хийх чадвартай өргөн хүрээний найдвартай эх сурвалж гэж үзэн сонгосон(Mikki, 2009). Мэдээллийн санг 2020 оны аравдугаар сарын 14, 15 -ны өдрүүдэд дараах томьёоны тэгшитгэлээр ашигласан болно(Collinson et al., 2019).

"Бүс" ба "Таксономи" ба "Нөлөөлөл" ба "Шугаман дэд бүтцийн горим". "Бүс" гэдэг нь Азид, "Таксономи" гэдэг нь зэрлэг ан амьтан, биологийн олон янз байдал, тодорхой ангилал зүйн бүлэгт, "Нөлөөлөл" гэдэг нь зэрлэг ан амьтдад тодорхой нөлөө үзүүлэхийг хэлнэ. амьдрах орчин, түүнийг бууруулах зөвлөмжийг хэлнэ(Huijser et al., 2008). Энэ тэгшитгэлийн эхний хэсгийг (тогтмол хэвээр байсан) гурван "шугаман дэд бүтцийн горим" (авто зам, төмөр зам, цахилгаан шугам;) түс бүрээр нэгтгэсэн болно(Хүснэгт I). Хайлтад “Сэдэв” гэсэн талбарыг ашигласан бөгөөд энэ нь гарчиг, абстракт, зохиогч, түлхүүр үг мөн “түлхүүрийн үгийн нэмэлт” зэргээр тодорхой хайлт хийдэг (WoS хайлтын онцлог нь тухайн судалгааны хүрээнд гарчигт байнга гарч ирдэг, гэхдээ судалгааны гарчигт өөрөө байхгүй үг, хэлц үгийг ашигладаг). Бид зөвхөн англи хэл дээрх нийтлэлийг хайсан (бусад хэл дээрх нийтлэлүүд эсвэл англи хэлний хураангуйг мөн мэдээллийн хоёрдогч эх сурвалж болгон оруулсан болно). Бид 2000 оны нэгдүгээр сарын 1-ээс 2020 оны аравдугаар сарын 15-ны хооронд хэвлэгдсэн нийтлэлүүдээр хязгаарлагдлаа.

Хүснэгт I: Уран зохиолын тоймыг хайх томьёолсон илэрхийлэл

ХҮСНЭГТ I: WEB OF SCIENCE МЭДЭЭЛЛИЙН САН ДАХЬ ШИНЖЛЭХ УХААНЫ НИЙТЛЭЛҮҮДИЙГ ХАЙХАД АШИГЛАДАГ ТОМЬЁОНЫ ИЛЭРХИЙЛЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ А, В

ХАЙЛТЫН СЭДЭВ	НЭГ ХЭВИЙН ТЭГШИТГЭЛИЙН ТҮЛХҮҮР ҮГС
Бүс нутаг	Сэдэв = (Ази* эсвэл Узбекистан эсвэл Казахстан эсвэл Тажикстан эсвэл Киргизстан эсвэл Туркменистан эсвэл Хятад эсвэл Япон эсвэл Өмнөд Солонгос эсвэл Хойд Солонгос эсвэл Монгол эсвэл Индонез эсвэл Филиппин эсвэл Вьетнам эсвэл Тайланд эсвэл Мьянмар эсвэл Малайз эсвэл Лаос эсвэл Сингапур эсвэл Тимор* эсвэл Бруней. ЭСВЭЛ Энэтхэг, Пакистан, Бангладеш, Афганистан, Непал, Шри Ланка эсвэл Бутан)
Таксономи	Сэдэв = (Зэрлэг ан амьтад эсвэл сээр нуруутан амьтад эсвэл хоёр нутагтан амьтад эсвэл шувуу эсвэл шувуу* эсвэл хөхтөн амьтад эсвэл мөлхөгч амьтад эсвэл махчин амьтан эсвэл ан амьтан эсвэл сарьсан багваахай эсвэл биологийн олон янз байдал)
Нөлөөлөл	Сэдэв= (Mitigat* OR Electrocute* OR Barrier OR Roadkill OR Road-kill OR Collision OR "Wildlife vehicle collision" OR "WVC" OR Fragmentation OR "Road Effect" OR Mortality OR Strike OR Carcass OR Crash)
Шугаман дэд бүтцийн горим 1: Авто зам	Сэдэв = ("Шугаман дэд бүтэц" ЭСВЭЛ Тээвэр* Эсвэл Зам* Эсвэл хурдны зам, Авто зам, Тээврийн хэрэгсэл, хөдөлгөөн)
Шугаман дэд бүтцийн горим 2: Төмөр зам	Сэдэв = ("Шугаман дэд бүтэц" ЭСВЭЛ Төмөр зам* ЭСВЭЛ Галт тэрэг)

ХАЙЛТЫН СЭДЭВ

НЭГ ХЭВИЙН ТЭГШИТГЭЛИЙН ТҮЛХҮҮР ҮГС

Шугаман дэд бүтцийн горим 3:
Цахилгаан дамжуулах шугам

Сэдэв = ("Шугаман дэд бүтэц" Эсвэл "Цахилгаан шугам*" Эсвэл Цахилгаан шугам*
Эсвэл Цахилгаан шугам* Эсвэл "Дамжуулах шугам*" Эсвэл "Өндөр хүчдэлийн
шугам*" Эсвэл "Дамжуулах систем*")

^А Од (*) нь үндсэн үгийн бүх боломжит төгсгөлийг хайх замаар хайлтын үр дүнг нэмэгдүүлэхийн тулд орлуулах тэмдэгт хайлтын техник болгон ашигладаг.

^В Ишлэл (" ") нь хайлтын үр дүнг баталгаажуулах, хавсаргасан зүйлийг тодорхой хэллэг хэлбэрээр авах хайлтын арга юм.

Дээрх гурван хайлт бүрийг хийсний дараа бид Ази дахь ан амьтан, амьдрах орчин, шугаман дэд бүтэцтэй холбоогүй нийтлэлүүдийг илрүүлэхийн тулд WoS(Biasotto & Kindel, 2018) дээрх "үр дүнг шинжлэх" функцийг ашигласан. Дараах судалгааны чиглэлээр бичсэн баримт бичгүүдийг хассан болно: Хоол тэжээлийн хоолны дэглэм, Боловсрол, Боловсролын судалгаа, Хөгшрөлтийн, Насжилтын эмгэг судлал, Зүрх судасны тогтолцооны зүрх судасны өвчин, Хавдар судлал, Биохими, Молекул биологи, Мэдрэл судлал, Мэдрэл судлал, Мал эмнэлгийн шинжлэх ухаан, Эрүүл мэндийн шинжлэх ухааны үйлчилгээ, Эмгэг судлал, Хүүхдийн эмч, Ерөнхий Дотоод анагаах ухаан, Түршилтын анагаах ухаан, Дархлаа судлал, Хүүхдийн өвчин, Цаг уурын шинжлэх ухаан. Үлдсэн судалгааг татаж авсны дараа бид тус бүрийг нь бүрэн эхээр нь уншиж, сайн тогтоосон шалгуур үзүүлэлтүүдийг ашиглан мэдээллийн санг шүүж мэдээлэл авлаа. Тодруулбал, зэрлэг ан амьтдын хувьд шугаман дэд бүтцэд огт хамааралгүй судалгааг бид хассан болно (жишээлбэл, зөвхөн замын дизайны талаарх техникийн инженерийн судалгаа). Бид зөвхөн дамжуулалт хийхэд шугаман дэд бүтэцтэй холбоотой судалгаануудыг ялгасан (жишээ нь судалгааны хэлэлцүүлэгт цөөн өгүүлбэр нь байгаль хамгааллын бусад асуудалд чиглэгдсэн байсан). Ландшафтын бүтэц, хэмжүүрийг тухайн ландшафтын зэрлэг ан амьтадтай шууд холбоогүй бол зөвхөн загварчлахад чиглэсэн судалгааг бид хассан. Бүрэн текстийг олж авах боломжгүй байсан судалгааг бид хассан боловч тодорхой, хамааралтай байсан бол энэхүү тоймд тэдний абстрактын талаарх тодорхой дүгнэлтүүдийг оруулсан болно. Бид ангилах зорилгоор хянан үзэх, санал бодлоо илэрхийлэх баримт бичгүүдийг оруулаагүй болно (доор харуулсан), гэхдээ хэрэв хамааралтай бол тухайн баримт бичигт өгсөн лавлагааг оруулсан болно.

Ялгах үйл явцын дараа зэрлэг ан амьтдыг хамгаалах хүрээнд шугаман дэд бүтцэд хамаарах олон тооны судалгаанууд бидэнд үлдсэн. Дараа нь бид эдгээр судалгаа тус бүрийг судалгааны чиглэлийг нэгтгэн харуулсан хоёр ангилал, зургаан дэд ангилалд хуваасан (тухайн судалгааг нэгээс олон ангилал эсвэл дэд ангилалд хувааж болно). Бид эхлээд судалгаа тус бүрийг хоёр том ангиллын аль нэгэнд хуваарилсан: нөлөөлөл (Зэрлэг ан амьтдад шугаман дэд бүтцийн нөлөөллийг тайлбарлах, хөгжүүлэх, хэрэгжүүлэх, үнэлэхэд чиглэсэн судалгаа) ба бууруулах (тайлбарлах, хөгжүүлэх, хэрэгжүүлэх, эсвэл үнэлэхэд чиглэсэн судалгаа) шугаман дэд бүтцийн нөлөөллийг бууруулах арга хэмжээ. Нөлөөллийн талаарх судалгааг дараа нь гурван дэд бүлэгт ангилав: E1 (шууд нөлөөлөл), E2 (шууд бус нөлөөлөл) ба E3 (том хэмжээний шууд ба шууд бус нөлөөлөл), Беннетт (2017)-ээс өөрчилсөн ангилалд багтсан болно. Шугаман дэд бүтцээс зэрлэг ан амьтдын гэмтэл, хорогдоход хүргэх нөлөөллийн талаарх харьцангуй жижиг хэмжээний судалгаануудыг (жишээлбэл, нэг төмөр замын шугам эсвэл тухайн бүс нутгийн цөөн хэдэн тусгай зам) E1 ангилалд оруулсан болно. Эдгээрт тээврийн хэрэгсэлд мөргүүлэх, цахилгаан тасалдах,

мөн хорогдлын тоо хэмжээ, эдгээр хорогдолд нөлөөлж байгаа хувьсагч хүчин зүйлсийн талаарх судалгаанууд багтсан. Жижиг хэмжээнд шугаман дэд бүтцийн шууд бус нөлөөллийн талаарх судалгааг E2 ангилалд оруулсан болно. Тухайн судалгаануудад шугаман дэд бүтэцтэй ойролцоо амьдрах орчны алдагдал, хуваагдал, доройтол, хулгайн ан хийх зэрэг хүний үйл ажиллагаа, хөнгөвчлөх үйл ажиллагаа, шугаман дэд бүтцийн үүрэг, орон нутгийн амьдрах орчны ашиглалтын өөрчлөлт, амьдрах нутаг дэвсгэрийн доторх нүүдэл, шилжилт, дэд бүтцийн нөлөөлөл зэрэг орно. E3 судалгаанд орон зайн том хэмжээний (төрөл зүйлтэй харьцуулахад) шууд ба шууд бус нөлөөлөл, хүн ам, олон нийтийн төвшинд дэд бүтцийн нөлөөлөлтэй холбоотой судалгаа, шугаман дэд бүтцийн сүлжээ зэрэг багтана. E3 судалгаанд амьтдын тоо толгойн нөөц эсвэл том хэмжээний тархалтын өөрчлөлт, шугаман дэд бүтцийн хүн ам зүйн нөлөөлөлд хамаарах параметруудийг судлах, хүн амын төвшний холболтын тоон үзүүлэлт, генийн өөрчлөлтийн үнэлгээ, гадаад байдалтай холбоотой хувьсагчдын дүн шинжилгээ зэргийг багтаасан болно. Жишээлбэл, тодорхой хурдны зам дээрх барын (*Panthera tigris*) үхлийг баримтжуулсан(Srivastava et al., 2017a) судалгааг E1 ангилалд багтаасан бол баруудад үзүүлэх замын нөлөөллийн талаарх өргөн хүрээний (Carter et al., 2020)үнэлгээг E3 ангилалд оруулсан болно. Үүний нэгэн адил хурдны замтай зэрэгцэн оршдог том хөхтөн амьтдын илрүүлэлтийн төвшинг судалсан судалгааг E2 ангилалд оруулсанGubbi et al., (2012) бол ийм хөхтөн амьтдын томоохон бүс нутгаар тархахад замын сүлжээний нөлөөллийг судалсан судалгааг E3 ангилалд оруулсанBrodie et al., (2015) болно.


Хөнгөвчлөх арга хэмжээний талаарх судалгааг мөн дараах гурван дэд ангилалд хуваажээHuijser et al. (2008): M1 (амьтдын зан байдлыг өөрчлөхийг зорьж буй бууруулах арга хэмжээ), M2 (хүний зан төлөвийг өөрчлөхийг эрмэлздэг бууруулах арга хэмжээ), M3 (зэрлэг ан амьтдыг шугаман дэд бүтцээс физик байдлаар тусгаарлах арга хэмжээ). M1 судалгаанд амьтны үргээлэг, бодит шууд хөөж үргээх, цугларах тоо, давтамжийг бууруулах арга хэмжээ, өөр зам, чиглэлийг бий болгох зэрэг арга хэмжээ багтсан болно. M2 судалгаанд хурдны хязгаарлалт, замыг хаах, үзэгдэх орчинг сайжруулах зэрэг арга хэмжээг багтаасан болно. M3 судалгаанд гүүрэн гарц, нүхэн гарц гэх мэт гарцын байгууламжийг хамруулсан болно. Шугаман дэд бүтцийн нөлөөнд чиглэсэн хэд хэдэн судалгаануудад нөлөөллийг бууруулах зөвлөмжийг өгсөн боловч бид эдгээр судалгааг чухал ач холбогдолтой гэж үзэж, логикийн хувьд судалгааны үр дүнд үндэслэн ийм төрлийн судалгааг бууруулах дэд ангилалд оруулсан болно. Жишээлбэл,Thinley et al., (2020) цахилгаан тасалдах, golden langur (*Traphypithecus geei*) амьтан зам дээр дайруулах тохиолдлуудыг бүртгэж, авто зам болон цахилгаан дамжуулах шугамын E1 ангилалд эдгээр судалгааг хамруулсан. Гэхдээ хурдны хязгаарыг бууруулах санал болгосон нөлөөлөл нь судалгааны эмпирик мэдээллээс гарахаас илүүтэйгээр ерөнхий шинжтэй бид үүнийг хөнгөвчлөх арга хэмжээний дэд ангилалд оруулаагүй.

Зэрлэг ан амьтанд ээлтэй шугаман дэд бүтцийн салбар (WFLI) нь хавсарга шинжлэх ухаанд хамаарах учраас бид мэргэжилтнүүдийн хянан шалгасан шинжлэх ухааны баримт материалуудад ашигтай чухал судалгаанууд хэвлэгдэхгүй гэж үзсэн. Иймээс тайлан, төр засгийн газрын тайлан, төрийн бус байгууллагуудын тайлан, мэдээллийн сүвгүүдын мэдээлэл зэргээс нэмэлт мэдээллийг хайсан. Үүнээс гадна бусад хэлнүүдэд бичигдсэн судалгаануудын (ихэвчлэн Хятад, Япон, Солонгос хэл) Англи абстрактүүд бүхий WoS-эд хайлт хийсэн. Бид тэдгээр судалгаануудыг машины орчуулгаар оруулж, тэдгээрийн ерөнхий утгыг ойлгохыг хичээсэн. Сайн орчуулагдсан, орчуулгын чанар сайтай судалгаануудын хувьд тэдгээрийг хянан шалгасан. Эцэст нь Энэтхэгийн замд дайруулсан амьтдын талаарх судалгаануудыг цуглуулж, холбогдох мэдээллийг ялган авсан ч бусад орнууд болон бусад шугаман дэд бүтцийн төрлүүдэд харьцуулах мэдээллийг цуглуулаагүй учраас эдгээр ялгасан мэдээллийг нэгтгэсэн статистикт оруулаагүй.


ҮР ДҮНГ ТАЛААРХ ДҮГНЭЛТ

Бид Азийн шугаман дэд бүтэц, зэрлэг ан амьтны талаарх англи хэл дээр бичигдсэн 289 судалгааг олж бүрдүүлсэн, эдгээрээс 56 хувь нь авто замд, 17 хувь нь төмөр зам, 27 хувь нь цахилгаан дамжуулах шугамтай холбоотой байлаа (Зураг1). Мөн нэмэлтээр 203 баримт бичгийг олж цуглуулж, холбоотой бол текстэд ашигласан ч доорх статистикт хамруулаагүй, эдгээр судалгаануудын 54 судалгаа нь өөр хэлнүүд дээр бичигдсэн, 68 нь албан бус материалууд, 81 судалгаа нь Энэтхэгт зам дээр дайруулсан амьтны тухай мэдээлэл байлаа. Авто замын экологийн судалгаанууд эрчимтэй хийгдэж, нэмэгдэж байгаа боловч мэргэжилтнүүдийн хянан шалгасан судалгаанаас харахад 2000-аас 2020 оны хооронд шугаман дэд бүтцийн гурван төрөлд өсөх хандлагатай (Зураг2). Авто замын талаар хамгийн их судалгаатай орнуудад Энэтхэг (33 хувь), Хятад (22 хувь), Малайз (7 хувьтай байлааЗураг3). Энэтхэг улс нь төмөр замын баримт, материал судалгаа хамгийн ихтэй буюу (39 хувь), Хятад (20 хувь), Монгол (16 хувьтай) байлаа. Цахилгаан дамжуулах шугамын талаар хамгийн их судалгааны материал бүхий орнуудад Энэтхэг (31 хувь), Хятад (18 хувь), Монгол (15 хувьтай) байлаа.


Number of Peer-Reviewed Papers by Mode



Зураг1. 2000-2020 оны хооронд авто зам, төмөр зам, цахилгаан дамжуулах шугамын талаар Азийн судалгаануудын тоо.




Зураг2. 2000-2020 оны хооронд Азид авто зам, төмөр зам, цахилгаан дамжуулах шугамын чиглэлээр бичигдсэн шинжлэх ухааны баримт материалуудын тооны түр хугацааны чиг хандлага.



Зураг3. 2000-2020 оны хооронд Азийн орнуудад (а) авто зам (б) төмөр зам (с) цахилгаан дамжуулах шугамын чиглэлээр бичигдсэн шинжлэх ухааны судалгаануудын тоо. Долоон оронд шугаман дэд бүтцийн төрлийн гурван чиглэлээр судалгаа байхгүй байсан учраас зурагт оруулаагүй.

Авто замын хувьд 142 судалгаа нь (Зураг4а) шугаман дэд бүтцийн нөлөөллийг судалсан бол (Зураг4b) харин 23 судалгаа эдгээр нөлөөллийг бууруулах арга хэмжээний талаар судалсан. Авто замын нөлөөллүүдээс жижиг хэмжээний (E1) авто замын шууд нөлөөллийн талаар хамгийн их судлагдсан (81 судалгаа, 57 хувь), түүний дараа том хэмжээтэй, шууд ба шууд бус нөлөөлөл (E3, 68 судалгаа, 48 хувь), түүний дараа жижиг хэмжээтэй шууд бус нөлөөлөл (E2, 33 судалгаа, 23 хувь) судлагдсан. Зэрлэг ан амьтдыг замаас тусгаарлах арга хэмжээний талаарх судалгаа (M3) нь хамгийн их судлагдсан төрөл юм (17 баримт бичиг, 74 хувь), дараа нь хүний зан төлөвт нөлөөлөх зорилготой арга хэмжээ (M2; 8 баримт бичиг, 35 хувь), амьтдын зан төлөвт нөлөөлөх (M1; 2 баримт бичиг, 9 хувь). Таксономийн хувьд (Зураг4с) хувьд хөхтөн амьтдыг авто замын судалгаа, баримт материалуудад хамгийн их судлагдсан (111 баримт бичиг, 69 хувь), дараа нь мөлхөгчид (43 баримт, 27 хувь), шувууд (33 цаас, 20 хувь), хоёр нутагтан амьтад (31 баримт бичиг, 19 хувь). Сээр нуруугүй амьтад авто замын зүгээс үзүүлэх нөлөөллийн талаар ердөө гурван баримт бичиг олдсон.



Зураг4. Азид 2000-2020 оны хооронд шугаман дэд бүтцийн гурван үндсэн төрөлтэй (А) холбоотой судалгаануудын тоо, шугаман дэд бүтцэд нөлөөллийн арга хэмжээний гурван үндсэн төрөлтэй холбоотой судалгааны тоо (В), сээр нуруугүйтэн, хоёр нутагтан, мөлхөгчид, шувуу, хөхтөн амьтдын талаар хийсэн судалгааны тоо (С).

Төмөр замын хувьд 46 судалгаа шугаман дэд бүтцийн зүгээс зэрлэг ан амьтанд үзүүлэх нөлөөллийг (Зураг4а), 12 судалгаа эдгээр нөлөөллийг хөнгөвчлөх бууруулах арга хэмжээг (Зураг4b) судалсан. Өргөн хүрээтэй шууд ба шууд бус нөлөөллийн судалгаа (Е3) бол хамгийн их судлагдсан нөлөөлөл (30 судалгаа, 65 хувь) байсан, түүний дараагаар төмөр замын жижиг хэмжээтэй шууд нөлөөлөл (Е1; 19 судалгаа, 41 хувь), түүний дараагаар төмөр замын жижиг хэмжээтэй шууд бус нөлөөлөл (Е2; 8 судалгаа, 17 хувь) байлаа. Зэрлэг ан амьтныг төмөр замаас тусгаарлах (М3) (8 судалгаа, 67 хувь) хөнгөвчлөх арга хэмжээний судалгаа нь хөнгөвчлөх арга хэмжээний судалгааны хамгийн түгээмэл төрөл байсан. Түүний дараагаар хүний зан төлөвт нөлөөлөх арга хэмжээ (М2, 5 судалгаа, 42 хувь), түүний дараагаар амьтны зан төлөвт нөлөөлөх судалгаа (М1, 1 судалгаа, 8 хувь) эзэлж байлаа. Төрөл зүйлийн хувьд (Зураг4с) хөхтөн амьтдыг хамгийн хол судалсан (39 баримт, 80 хувь), дараа нь мөлхөгчид (8 баримт, 16 хувь), шувууд (6 баримт, 12 хувь), хоёр нутагтан амьтад (1 баримт, 2 хувь) байлаа.

Цахилгаан дамжуулах шугамын хувьд 71 баримт бичиг нь шугаман дэд бүтцийн зэрлэг амьтдад үзүүлэх нөлөөг судалсан (Зураг4а), 14 нь эдгээр нөлөөллийг бууруулах талаар судалсан (Зураг4b). Цахилгаан дамжуулах шугамын жижиг хэмжээтэй шууд нөлөөлөл (Е1) бол нөлөөллүүдийн дотроос хамгийн их судлагдсан (64 баримт бичиг, 90 хувь), түүний дараагаар цахилгаан дамжуулах шугамын жижиг хэмжээтэй шууд бус нөлөөлөл (Е2, 10 баримт бичиг, 14 хувь), түүний дараагаар цахилгаан дамжуулах шугамын том хэмжээтэй шууд ба шууд бус нөлөөлөл (Е3, 8 баримт бичиг, 11 хувь) байлаа. Зэрлэг ан амьтныг цахилгаан дамжуулах шугамаас тусгаарлах хөнгөвчлөх арга хэмжээний судалгаа (М3) нь хөнгөвчлөх арга хэмжээний судалгааны хамгийн түгээмэл төрөл байсан (11 баримт бичиг, 79 хувь), түүний дараагаар амьтны зан төлөвийг өөрчлөх арга хэмжээ (М1, 4 баримт бичиг, 29 хувь) эзэлж байлаа. Цахилгаан дамжуулах шугамын судалгаануудад М2 ангиллын арга хэмжээ (хүний зан төлөвийг өөрчлөх арга хэмжээ) судлагдаагүй. Төрөл зүйлийн хувьд (Зураг4с), Шувууд хамгийн их судлагдсан байв (41 баримт, 53 хувь), дараа нь хөхтөн амьтад (31 баримт, 40 хувь) байлаа. Мөлхөгчид зөвхөн нэг баримт бичигд тэмдэглэгдсэн.

ШУГАМАН ДЭД БҮТЦИЙН ТӨРӨЛ ТУС БҮРЭЭР ҮР ДҮНГ ХАРУУЛАВ: АВТО ЗАМ

ЗЭРЛЭГ АН АМЬТАНД АВТО ЗАМЫН НӨЛӨӨЛӨЛ

ЕI: АВТО ЗАМЫН ШУУД НӨЛӨӨЛӨЛ

Авто замын нөлөөлөл нь зэрлэг ан амьтныг машинаар мөргөх (AVCs) гэсэн хэлбэрээр шууд байдлаар нөлөөлж, гэмтэх, хорогдох шалтгаан болдог. Хорогдол нь авто замтай шууд холбоотой дэд бүтцээс шалтгаалж болно. Амьтан машинд мөргүүлэх нөлөөллийг Азид хамгийн багаар 611 төрөл зүйлд судлагдсан, тэмдэглэгдсэн (Хүснэгт2; Хавсралт А). Азид машинд мөргүүлсэн төрөл зүйлүүдэд Малайзад, Азийн заан (*Elephas maximus*; цаашид "заан") (Wadey et al., 2018) Энэтхэгт (Srivastava et al., 2017a) бар, Японд Амами модны тоншуул (*Scolopax mira*), (Mizuta, 2014) Тайландад хаан кобра (*Ophiophagus Hannah*) зэрэг төрөл зүйлүүд байна (Marshall et al., 2018). Ус зайлуулах суваг гэх мэт замтай холбоотой дэд бүтэц нь хоёр нутагтан гэх мэт жижиг амьтдыг урхихдах, үхэлд хүргэж болзошгүй юм (Z. Zhang et al., 2010). Хэдийгээр амьтанд авто замын улмаас үхэх, хорогдох талаар өргөн хэмжээний баримт, судалгаанууд байгаа боловч ямар төрөл зүйл илүү өртөмхий байгаа талаар тодорхойгүй байна. Янз бүрийн орнуудад судалгаанд хамгийн их хэмжээгээр Herpetofauna нөлөөлж байна (e.g., India, Baskaran & Boominathan, 2010; Sri Lanka, Karunarathna et al., 2017; China, Wang et al., 2013). Гэхдээ, Silva et al., (2020) Тайландад тусгай хамгаалалттай газар нутагт нугалмайтан болох сарьсан багваатай хамгийн их тархалттай байсан бол Энэтхэгт тусгай хамгаалалттай газар нутагт шувууд хамгийн их байлаа (Menon et al., 2015). Авто замын улмаас үхэж хорогдсон амьтны сэг зэмээр хооллодог тас, хэрээ гэх мэт амьтад өөрөө машинд дайруулах, мөргүүлэхэд илүү өртөмхий байна (Chhangani, 2004b). Машинд мөргүүлэх нь сээр нуруугүйтэнд илүү давамгай байна. жишээ нь Энэтхэгийн нэгэн судалгаанд авто замын улмаас үхэж хорогдсон амьтанд хэд хэдэн зүйлийн эрвээхий, соно зэрэг төрөл зүйлүүд бичигдсэн байв (Rao & Girish, 2007). Ерөнхийдөө манай судалгааны хайлт нь тээврийн хэрэгсэлд мөргүүлсэн амьтдыг төрөл зүйл талаас нь давамгай авч үзсэн, ямар төрөл зүйл илүү өртөмхий байгааг тодорхойлсон.

Хүснэгт2: Тээврийн хэрэгсэлд мөргүүлэх шууд нөлөөлөлд өртсөн төрөл зүйлсийн тоо

ХҮСНЭГТ 2: ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛТЭЙ МӨРГӨЛДӨХ ШУУД НӨЛӨӨЛӨЛ, МӨН ЗАМЫН ДАГАЛДАХ ДЭД БҮТЦИЙН УЛМААС НӨЛӨӨЛӨЛД ӨРТСӨН ТӨРӨЛ ЗҮЙЛИЙН ТООГ ТӨРӨЛ ЗҮЙЛЭЭР, IUCN-ИЙН АЮУЛД ӨРТСӨН ТӨРӨЛ ЗҮЙЛИЙН УЛААН ЖАГСААЛТЫН ХАМГААЛАЛТЫН СТАТУСААР АВЧ ҮЗЭВ (IUCN, 2020B).

IUCN-ийн Улаан жагсаалтын статус	Сээр нуруугүйтэн	Хоёр нутагтан	Хэвлийгээр явагч хоёр нутагтан	Шувуу	Хөхтөн амьтан	Нийт
Маш ховордсон	-	2	-	2	1	5
Ховордсон	-	13	1	1	20	35
Маш ховордсон	-	2	9	3	24	38
Аюулд ойрхон төрөл зүйл	-	7	4	3	8	22
Хамгийн бага анхаарал татсан	2	41	108	120	95	366

Мэдээлэл хомсдолтой	-	1	10	-	-	11
Үнэлэн дүгнээгүй	23	3	108	-	-	134
Нийт	25	69	240	129	148	611

Амьтан тээврийн хэрэгсэлд мөргүүлэх эрсдэл нь тодорхой нутаг дэвсгэрт болон төрөл зүйлүүдэд илүү түгээмэл хандлагатай байгаа боловч нутаг дэвсгэрийн ашиглалт болон амьтны зан төлөв илүү чухал үүрэг гүйцэтгэдэг. Авто зам тодорхой нэг төрөл зүйлийн илүү зорчин явдаг нутаг дэвсгэрээр дайран өнгөрөх тохиолдолд нутаг дэвсгэрийн ашиглалт, амьтны нягтрал зэргээс шалтгаалан амьтан замын нөлөөллөөс үхэж хорогдох давтамж илүү өндөр байна. Энэхүү дүр Зураг нь ирвэс мүүр (*Prionailurus bengalensis*; Kim et al., 2019) гэх мэт хөхтөн амьтдад; тэгш өндөрлөгийн бор мэлхий (*Rana kukunori*; Gu et al., 2011) зэрэг хоёр нутагтан амьтад; Азийн усны монитор (*Varanus salvator*; Healey et al., 2020) –уудад ажиглагдаж байна. Авто зам нь амьтдын орших нутаг дэвсгэрүүдийн хооронд нүүдлийн замыг дайран гарсан тохиолдолд амьтдын үхэл хорогдол хамгийн их байна (Kang et al., 2016). Түр зуурын, улирлын шинжтэй энэ дүр зураг нь тодорхой хугацаанд үргэлжилж, эрсдэл дагуулдаг. Жишээ нь бороотой өдөр (Gu et al., 2011), бороотой улирал (Jeganathan, Mudappa, Kumar, et al., 2018), шөнө (Zhang et al., 2018), усны ойролцоо (Seo et al., 2015) зэрэг газруудад хоёр нутагтан илүү өртөгддөг. Нүүдэл, орооны үе, сүрэг тарах, сүрэг нийлэх зэрэг үеүд нь ирвэс мүүрнүүд (Nakanishi et al., 2010), Амами тоншуул (Mizuta, 2014), могой, (Lee et al., 2018) хоёр нутагтан (Z.-C. Wang et al., 2015) зэрэг төрөл зүйлүүд замын нөлөөллөөс болж алагдах магадлалыг нэмэгдүүлдэг. Амьдралын түүхийн талаас авч үзвэл махчин амьтдын зан байдал нь замаас болж нас барах магадлалд нөлөөлдөг. Жишээ нь Өмнөд Солонгост могойг нэрлэж болох бөгөөд хууль бүс ан агнуур нь тээврийн хэрэгсэлд дайруулахаас илүү аюултай нөлөө үзүүлдэг (Park et al., 2017). Иймээс амьтны үйл хөдлөл ихтэй газрууд, улирлуудад амьтан тээврийн хэрэгсэлд мөргүүлэх эрсдэл өндөр байдаг ч энэ нь тухайн амьтны зан төлөв, нутаг дэвсгэртэй холбоотой юм.

Авто замын физик үзүүлэлтүүд нь амьтдын унаган нутаг, зан төлөвт нөлөөлж болно. Замын хөдөлгөөн эрчимтэй байх нь хөхтөн амьтан (Piao et al., 2012), шувуу (Piao et al., 2016), могой (Pragatheesh & Rajvanshi, 2013), хоёр нутагтан (Seshadri & Ganesh, 2011), эрвээхий (Rao & Girish, 2007) зэрэг амьтдын мөргөлдөх эрсдэлийг нэмэгдүүлдэг. Гэхдээ замын хөдөлгөөн тодорхой төвшнөөс эрчимжих үед амьтад замаас дайжих, зайлсхийх учраас замын хөдөлгөөний эрчим нь амьтны мөргөлдөх, осолдоход заавал шууд нөлөөлөхгүй (Saeki & Macdonald, 2004). Дөрвөн эгнээтэй зам нь хоёр эгнээтэй зам, зургаан эгнээтэй замыг (Kim et al., 2019) бодвол амьтныг мөргөж устгах тохиолдол ихтэй байдаг нь дөрвөн эгнээтэй зам нь хоёр эгнээтэй замтай харьцуулахад амьтад нэвтрэх орох талбай, зай ихтэй байдаг. Биологийн бүх төрөл зүйлд Seshadri & Ganesh (2011) босгоос хамааралтай замаас зайлсхийхгүй байж болно. Нугалмайтан, хоёр нутагтны хувьд ийм дүр зураг тохиолдоогүй. Машины хөдөлгөөний хурд нь амьтны хорогдолд шууд нөлөөлдөг. Жишээ нь Окинавагийн төмөр замд (*Gallirallus okinawae*) шулуун хэсэгт төмөр замын хурд нэмэгддэг (Kotaka & Sawashi, 2004) учраас амьтны осол илүү их тохиолддог, өмнөд Солонгост жижиг болон дунд хэмжээтэй хөхтнүүдийн осолдох эрсдэл тээврийн хэрэгслийн хурд буурдаг налуу замуудад багасдаг (Kang et al., 2016). Шороон замд машины хурд, эрчим буурдаг учраас амьтны осолдох, дайруулах эрсдэл багасдаг (Жишээ нь Пакистаны Потвар өндөрлөг Akrim et al., 2019). Өглөө үүрээр эсвэл шөнө машины их гэрлийг асаах нь олон төрөл зүйлүүдийн мөргөлдөх эрсдэлийг нэмэгдүүлдэг (Piao et al., 2012; Jeganathan, Mudappa, Kumar, et al., 2018). Иймээс авто

замын бодит, физик үзүүлэлтүүд, мөн машины үзүүлэлтүүд нь амьтан машинд дайруулахад гол хүчин зүйл болдог.

Ерөнхийдөө Азид авто замын шууд нөлөөлөл, тус тивийн хэмжээнд амьтан машинд дайруулах эрсдэл талаарх баримт, судалгаанууд маш их байдаг. Гэхдээ судалгааны ихэнх хэсэг нь үндсэн баримт бичигт чиглэсэн. Учир нь тухайн мэдээллийг олон оронд зэрлэг ан амьтны удирдлага, зохион байгуулалтын байгууллагууд системтэйгээр цуглуулдаг. Амьтны мөргүүлэх эрсдэлийг урьдчилан тодорхойлох, хөнгөвчлөх арга хэмжээг хөгжүүлэхийн тулд хорогдлыг түүний унаган нутаг, физик болон зан төлөвийн онцлогтой уялдуулах хэрэгцээ шаардлага тулгарч байна(Saxena et al., 2019).

Е2: ЗАМЫН ШУУД БУС НӨЛӨӨЛӨЛ

Мөргүүлсний улмаас зэрлэг ан амьтанд шууд нөлөөлөхөөс гадна авто зам нь харьцангуй бага төвшинд шууд бус олон нөлөөллүүд үзүүлж болно. Эдгээрт амьтан эзэмшил нутгаа алдах, орчны доройтол(Bennett, 2017), хүний үйл ажиллагаа хурдсах, эзэмшил нутгийн ашиглалт өөрчлөгдөх, амьтны нүүдэлд(e.g., Bischof et al., 2017) хориг саад тулгарах зэрэг багтана. Бид биологийн 34 төрөл зүйлд авто замын шууд бус нөлөөллийг хамруулан эмпирик судалгаануудыг (Хүснэгт3В хавсралтад дэлгэрэнгүйг үзнэ үү) тодорхойлсон .Тэдгээр нь бүгдээрээ хөхтөн болон шувуунууд байсан. Хятадад шууд бус нөлөөллийг хамгийн их судалсан (12 судалгаанаас 16 төрөл зүйл) .Үүний дараагаар энэтхэг (6 судалгааны 10 төрөл зүйл), Бангладеш (нэг судалгааны таван төрөл зүйл) удаалсан.

Хүснэгт3: Шууд бус нөлөөллийн судалгаанд судлагдсан төрөл зүйлүүдийн тоо

ХҮСНЭГТ 3: ЗАМЫН ЖИЖИГ ХЭМЖЭЭТЭЙ ШУУД БУС НӨЛӨӨЛЛИЙН ЭМПИРИК СУДАЛГААНД СУДЛАГДСАН БИОЛОГИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛҮҮДИЙН ТОО, ЭДГЭЭРИЙГ БИОЛОГИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛЭЭР МӨН IUCN-ИЙН АЮУЛД ӨРТСӨН ТӨРӨЛ ЗҮЙЛҮҮДИЙН УЛААН ЖАГСААЛТ ДАХЬ ХАМГААЛЛЫН СТАТУСААР АНГИЛАВ

IUCN-ийн Улаан жагсаалтын статус	Шувуу	Хөхтөн амьтан	Нийт
Ховордсон	-	6	6
Маш ховордсон	1	7	8
Аюулд ойрхон төрөл зүйл	1	3	4
Хамгийн бага анхаарал татсан	7	9	16
Нийт	9	25	34

Авто зам нь замын дагуух орчны доройтол үүсгэх, хор хохирол учруулахад хүргэдэг (замын үйлчлэлийн бус гэж нэрлэгддэгForman et al., 2003). Жишээ нь Энэтхэгт өндөр эрчимтэй зам дагуух хүний үйл ажиллагааны өндөр идэвх, газар нутгийн ашиглалтын өөрчлөлт нь заан, гаур (*Bos gaurus*)(хэдийгээр өргөн уудам нутаг дэвсгэрт тархан амьдардаг боловч) зэргийг эзэмшил нутгаас гаргасан(Gangadharan et al., 2017). Орон нутгийн замаас 1500 метр зайд, томоохон гол замуудаас 5000 метрт зайд аварга биетэй Панда (*Ailuropoda melanoleuca*)-ийн нутаг дэвсгэрийн ашиглалт буурсан(He et al., 2019). Авто зам нь замын дагуух шугаман дэд бүтцийн бусад төрлүүдийг байгуулахад тусламж, дэмжлэг болж болно. Бангладешийн тусгай хамгаалалттай нутагт хоёр

газарт одоогийн авто замтай зэрэгцэн орших цахилгаан дамжуулах шинэ шугам нь сармагчны төрөл зүйлүүдэд (Phayre's leaf monkey (*Trachypithecus phayrei*), capped langur (*Trachypithecus pileatus*), Northern pig-tailed macaques (*Macaca leonine*), Bengal slow loris (*Nycticebus bengalensis*) модны эзэмшил нутгаа алдах, улмаас машинд мөргүүлэх, цахилгаан тасалдах эрсдэлийг нэмэгдүүлсэн (Al-Razi et al., 2019). Зүүн Өмнөд Азид хулгайн анчдын нэвтрэх боломжийг хөнгөвчлөх зорилгоор авто замуудыг судалсан (жишээ нь Малайзад Hearn et al., 2019)). Иймээс эдгээр замууд нь замын дагуух жижиг хэмжээтэй орчны доройтол, антропогенийн дарамт шахалтыг эрчимжүүлж, тухайн бүс нутгийн амьтад замын нөлөөллийн бүсээс зугтахад хүргэдэг.

Хэдийгээр энэхүү шилжилт, оргон зайлах тохиолдлууд байгаа боловч авто зам, түүнтэй холбоотой антропогенийн өөрчлөлтүүд зарим төрөл зүйлийг өөртөө татах шалтгаан болж болно. Хоол хүнс бол амьтныг татах гол хүчин зүйл юм. Энэтхэгт машинаас унасан үр тарианд *mynas* шувуу (*Acridotheres tristis*) татагдан ирдэг. (Siva & Neelananarayanan, 2020) Хятадад (Wang et al., 2013) Сибирийн жирх (*Tamias sibiricus*) замын дагуух хог хаягдалд, Энэтхэгт саарал лангур (*Semnopithecus entellus*) Зам дагуу хаясан хоол хүнсэнд татагдан ирдэг (Chhangani, 2004a). Японд Азийн хар баавгай (*Ursus thibetanus*) хэдийгээр хүнтэй тулгарах, таарах эрсдэл их боловч мод бэлтгэлийн зам дагуу ургасан шинэ моднуудад татагдан мод бэлтгэлийн замыг илүүд үздэг (Takahata et al., 2013). Тухайн зан төлөвийн өөрчлөлт нь экологийн хүчин зүйлс, хоол тэжээлийн хэрэгцээ шаардлагаас шалтгаалж харилцан адилгүй байдаг. Халуун орны ойн заан Малайзын гол замуудын (Yamamoto-Ebina et al., 2016) дагуух хоёрдогч ургамлуудад татагддаг ч Непалын задгай ойн заанууд замаас зайлсхийдэг (Sharma et al., 2020). Авто зам ба түүний зэргэлдээх замуудыг ашиглах шаардлагатай амьтад хүний үйл ажиллагаанаас үүссэн эрсдэлийг хөнгөвчлөх зорилгоор өөрийн зан төлөвийг өөрчилж болно, жишээ нь хүмүүстэй хамт тусгаарлагдах, сонор сэрэмжээ нэмэгдүүлэх гэх мэт. Хятадад гол зам дагуу Прежевалскийн зээр (*Procapra przewalskii*) замын хөдөлгөөний эрчим ихтэй цагаас зайлсхийх зорилгоор бэлчээрлэх оргил цагийг үдээс хойш хугацаанаас өглөө эрт эсвэл орой болгон өөрчилсөн (C. Li et al., 2009). Горал (*Naemorhedus goral*) болон бүдүүн буга (*Elaphodus cephalophus*) өдрийн үед гол замаас зайлсхийж, шөнөд илүү ойр цуглардаг (Jia et al., 2015). Хятадад Төвдийн гөрөөс (*Pantholops hodgsoni*) Чинхай-Төвдийн гол замд ойртохын өмнө сонор сэрэмжээ нэмэгдүүлж ихээхэн цагийг өнгөрөөдөг (Бао-фа et al., 2007). Гэхдээ замын дагуух хүний нөлөөлөлд дасан зохицож, сонор сэрэмжтэй байдлаа бууруулдаг. Шинжааны газрын шаазгай (*Podoces biddulphi*) зам руу ойртохдоо хүмүүсийг ойртох, дөхөх боломжийг олгодог (Xu et al., 2013). Замын ойролцоох нутаг дэвсгэрийн давуу талыг ашиглах амьтны чадвар нь антропогенийн эрсдэлийг бууруулахын зэрэгцээ хүний нөлөөгөөр өөрчлөгдөн хувирсан нутаг дэвсгэрт тэсвэртэй амьдрах чадварт гол хүчин зүйл болдог.

Авто зам нь амьтны чөлөөт хөдөлгөөнд сөргөөр нөлөөлж болно. Энэхүү нөлөөллийн цар хүрээ нь замын физик үзүүлэлтүүд, замын хөдөлгөөний үзүүлэлтүүд, хүний нөлөөллийн хоорондын харилцан үйлчлэлээс хамаарна. Малайзад хоёр эгнээтэй гол замыг дайран гарах зааны хөдөлгөөн гол замын (Wadey et al., 2018) дагуух саад, шуудууны улмаас 80 хувиар багассан, Хятад бол өндөр эрчимтэй замын хөдөлгөөний улмаас багассан (Huang et al., 2020). Замын хөдөлгөөний эрчмээс үл хамааран зам гарахдаа өндөрт нисэж зам гардаг цагаан дэглий (*Egretta garzetta*) зэрэг шувуудын хөдөлгөөнд саад болоогүй (Stanton & Klick, 2018). Амьдралын түүхээс үүдэлтэй зан төлөвийн онцлог шинж чанарууд нь амьтдын замаар гарах үйлдэлд нөлөөлж болно. Вьетнамд дунд давхаргын ойн шувуудын төрөл зүйлс доод давхаргын шувуудтай харьцуулахад хатуу хүчилттай 8 метр өргөн замаар илүү түгээмэл гарч байсан, яагаад гэвэл газраас дээш илүү өндөрт модны навчин бүрхүүл илүү их байдаг (Thin et al., 2012). Хятадад гол замыг хөндлөн гарч, нутаг

сэлгэсэн Сибирийн алагдаахай (*Allactaga sibirica*) нь үлийн цагаан оготныг (*Rhombomys opimus*) бодвол буцаж өмнөх нутаг руугаа шилжих магадлал ихтэй байсан. Энэхүү ялгаа нь овор хэмжээ их байх, хөдөлгөөнт чанар их, махчин амьтны эсрэг хариу үйлдэл зэргээс хамаарч байлаа(Ji et al., 2017). Гэхдээ хатуу хучилтгүй замд(Ji et al., 2017) хоёр төрөл зүйлийн хооронд тийм ялгаа байхгүй байсан нь асфальтан замын физик бүтэц өөрөө зарим төрөл зүйлийн хөдөлгөөнийг саатуулдаг болохыг харуулж байна. Амьтан хөдөлгөөний эрчим ихтэй замыг хөндлөн гарах амьтны чадвар нь машины жолоочийн зан төлөвөөс хамаарч болно. Энэтхэгт машинд хүмүүс чанга чанга ярилцах, машинаасаа буух зэрэг нь зааны зам хөндлөн гарах оролдлогод сөргөөр нөлөөлдөг(Vidya & Thuppal, 2010). Хэдийгээр зам хөндлөн гарах хөдөлгөөн нугалмайтны олон төрөл зүйлийн бодит чадварын дотор илүү сайн байж болно, энэ нь зарим нэг амьтны бүлэгт зан төлөвийн онцлогоос хамаарч хумигдаж болно.

Замын шууд бус нөлөөллийн талаарх Азийн судалгаа, баримтуудад амьтны эзэмшил нутаг хумигдах, орчны доройтол, хүний үйл ажиллагаа зэрэг гол чухал нөлөөллүүдийг хамруулсан ч энэ нь үндсэндээ хөхтнүүдэд чиглэсэн. Шүхэр болон далбаа төрөл зүйлсийг онцлох байгаль хамгааллын арга хэмжээний тусгал байж болно, тэдгээрийн олонх нь том хөхтнүүд байсан. Гэхдээ эдгээр шууд бус нөлөөллийн өргөн хэмжээний өөрчлөлтөөс харахад эдгээр төрөл зүйлст зориулан хөгжүүлсэн байгаль хамгааллын нөлөөллийн арга хэмжээ нь бусад төрөл зүйлд хамаарахгүй байж болно. Жижиг хөхтөн болон шувууг судлах үед анхаарал татаж байгаа нэг нөлөөлөл бол нүүдэл, шилжилт юм. Энэ нь томоохон хөхтнүүдтэй харьцуулахад туршилтын судалгааны харьцангуй хялбар байдалд нөлөөлж болно (нутаг сэлгэх гэх мэт).

ЕЗ: АВТО ЗАМЫН ПОПУЛЯЦЫН ТӨВШНИЙ ШУУД БА ШУУД БУС НӨЛӨӨЛӨЛ

Авто замын зүгээс зарим нэг амьтанд үзүүлэх шууд ба шууд бус нөлөөлөл илүү өргөн хүрээнд хуримтлагдаж, – популяцын оршин тогтнох чадварт нөлөөлж болно. Манай судалгаанд 41 төрөл зүйлийн хувьд популяцын төвшний нөлөөллийг хамруулан эмпирик судалгаа хийсэн (

Хүснэгт 4 Хавсралт С)-д дэлгэрэнгүй танилцуулсан ч тэдгээрийн олонх нь хөхтнүүд байсан. Популяцын төвшин дахь замын нөлөөллийг Энэтхэгт хамгийн их судалсан (9 судалгаанаас 11 төрөл зүйл), түүний дараа Малайз (2 судалгаанаас 10 төрөл зүйл), Хятад (6 судалгаанаас 6 төрөл зүйл) удаалсан.

**ХҮСНЭГТ 4: ПОПУЛЯЦЫН ТӨВШНИЙ НӨЛӨӨЛЛИЙН СУДАЛГААНД СУДЛАГДСАН ТӨРӨЛ ЗҮЙЛСИЙН ТООГ
БИОЛОГИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛ БОЛОН IUCN-ИЙН НЭН ХОВОРДСОН ТӨРӨЛ ЗҮЙЛСИЙН УЛААН ЖАГСААЛТААР
АНГИЛСАН**

IUCN-ийн Улаан жагсаалтын статус	Сээр нуруугүйтэн	Хоёр нутагтан	Хэвлийгээр явагч хоёр нутагтан	Шувуу	Хөхтөн амьтан	Нийт
Маш ховордсон	-	-	-	-	1	1
Ховордсон	-	-	-	1	4	5
Маш ховордсон	-	-	2	-	10	12
Аюулд ойрхон төрөл зүйл	-	-	-	-	1	1
Хамгийн бага анхаарал татсан	1	1	-	2	15	19
Үнэлэн дүгнээгүй	2	-	-	1	-	3
Нийт	3	1	2	4	31	41

Амьтан тээврийн хэрэгсэлд мөргүүлэх шүүд бус нөлөөлөл нь популяцын төвшинд хэрхэн нөлөөлдөг болохыг ойлгохын тулд цуглуулсан тоон мэдээллийг ашиглан тээврийн хэрэгсэлд мөргүүлсний улмаас хорогдсон амьтны популяцын төвшний тооцоонд тооцоо судалгаа хийх хэрэгтэй. Энэхүү тооцоо судалгааны нэг хүндрэлтэй асуудал бол зам дээр хаягдсан амьтны сэг зэм зам дээр удаан байдаггүй, махчин амьтан, махчин шувуу, хүний нөлөөгөөр замаас зайлуулагддаг учраас энэхүү судалгааны үр дүн бол бүх тохиолдлыг бүрэн илэрхийлж чадахгүй. Индонезид амьтны сэг зэм зам дээр хэр удаан хадгалагдах тухай судалгаа ховор байдаг боловч зарим цөөн судалгаанаас харахад хөхтөн, хэвлийгээр явагч, хоёр нутагтан, шувуу зэрэг амьтдын хувьд энэ хугацаа 45-61 цагийн хооронд байсан(Healey et al., 2020). Энэтхэгийн нэгэн ижил төстэй судалгаанаас харахад том хөхтөн амьтны сэг зэмийг зэм богино хугацаанд (12 цагаас бага) зайлуулагддаг, харин том шувуу, хэвлийгээр явагчийн сэг зэм зам дээр илүү удаан хугацаанд (72 цагаас дээш) орхигддог(Habib, Saxena, Bhanupriya, et al., 2020). Амьтны сэг зэм зам дээр хэр удаан орхигддог тухай статистикийн тодорхойгүй байдлаас гадна мэдээллийг нэг байрлал, цаг хугацаанаас авто замын иж бүрэн сүлжээ рүү шилжүүлэхэд үүсэж байгаа хүндрэл (муж, улсын гэх мэт). Гэхдээ тухайн залруулга хийгдсэн үед гарах үр дүнгийн тоонууд харьцангуй их болдог. Жишээ нь Тайландад зөвхөн нэг тусгай хамгаалалттай нутаг дэвсгэрт нугалмайтан амьтад зам дээр дайруулах тохиолдол 9,688 байлаа(Silva et al., 2020). Хамгийн багадаа Өмнөд Солонгост нэг илд авто зам дээр 60,000 орчим усны буга (*Hydropotes inermis*) дайруулж үхдэг, Японд зөвхөн нэг жилд (Choi, 2016) 110,00-370,00 илбэнх (*Nyctereutes procyonoides*) машинд дайруулж үхдэг (Saeki & Macdonald, 2004). Одоогоор популяцын хорогдлын тухайн тоонууд тодорхой бус байна, үүний учир нь тухайн төрөл зүйлд нийт популяцын хэмжээний утгаар эдгээр тоон мэдээллийг ховорхон байрлуулдаг. Амьтан машинд мөргүүлэх нийт тохиолдлын пропорцыг тооцооноор амьтан машинд дайруулж үхэхтэй холбоотой байгаль хамгааллын ач холбогдлын үзүүлэлт урган гарна. Амьтан машинд мөргүүлэх тохиолдол 1998-2003 оны хооронд (Kotaka & Sawashi, 2004) Окинавагийн төмөр замд бүртгэгдсэн нийт үхэл, хорогдлын 73 хувийг эзэлж байгаа бөгөөд үүнээс харвал энэхүү төрөл зүйлд маш хүчтэй аюул заналхийллийг харуулж байна. Бусад төрөл

зүйлүүд популяцын төвшинд нөлөөлөлд харьцангуй бага өртөж болно; Тайландад хаан кобрагийн хорогдлын 16 хувь нь авто замтай холбоотой байлаа(Marshall et al., 2018). Бидний олж мэдсэнээр эдгээр тоо хэмжээний мэдээллийг цөөн судалгаануудад танилцуулсан бөгөөд зэрлэг ан амьтны шууд хорогдлын популяцын төвшний нөлөөллийг ойлгоход хүндрэлтэй юм.

Популяцын тоо толгойд амьтан машинд мөргүүлэх нөлөөллийн өөр нэг гол тодорхойлогч бол тухайн төрөл зүйл өөр бусад шалтгааны улмаас үхэж хорогдсон эсэх, эсвэл замын шалтгаантай үхэл хорогдол эдгээр шалтгаанд нэмэлтээр нөлөөлсөн эсэхийг тогтоох явдал юм(Lebreton, 2005). Хэрвээ замын нөлөөгөөр үхэж хорогдох тохиолдол ирээдүйн өөрчлөлтөд бага нөлөөлөх тухайн төрөл зүйлийн категори, ангилалд сонгомол бол популяцын динамик үзүүлэлтэд авто замын улмаас хорогдох нөлөөллийг өөрчилж болно. Авто замын нөлөөгөөр хорогдох тохиолдол ихэвчлэн төрөл зүйлсийн эрэгчинд илүү тохиолддог (жишээ нь Хойд тэгш талархаг нутагт саарал лангүрChhangani, 2004, зэрлэг үхэр *Bubalus arnee*, Heinen & Kandel, 2006; могойн 10 зүйлPark et al., 2017, эрвээхийн 3 зүйл, Rao & Girish, 2007). Гэхдээ авто зам болон төмөр замд амьтан мөргүүлэх ослын түүн бүртгэлдGubbi et al. (2014) эрэгчин болон эмэгчин ирвэс (*Panthera pardus*) тэнцүү хэмжээгээр судлагдсан бол Vyas & Vasava (2019) намгийн матрын хувьд (*Crocodylus palustris*) эмэгчин нь илүү олон тоотой байгаа нь тогтоогдсон. Эдгээр цөөн судалгаанууд нь орон нутгийн популяцад эрэгчин ба эмэгчин амьтны тооны зөрүүг тэгшитгэсэн. маш цөөхөн судалгаанд эрэгчин макаке сармагчин (*Macaca mulatta*; Pragatheesh, 2011) илүү их буюу 46 хувиар хорогдолд өртсөн. Насны бүлгийн хувьд Солонгост авто замын нөлөөгөөр хорогдсон ирвэсний хорогдолд нэг наст ирвэс давамгай (64 хувьKim et al., 2019)), Японд 70 хувь Nakanishi et al., 2010) байсан. Энэтхэгт тусгай хамгаалалтай нутаг дэвсгэрт хоёр хүчин зүйлээр залуу насны намгийн матрын хорогдол нь насанд хүрсэн матрын хорогдлоос илүү байлаа(Vyas & Vasava, 2019). Харьцуулбал Солонгост (Park et al., 2017) насанд хүрсэн 10 төрөл зүйлийн могой 21 гэсэн коэффициентоор залуу могойгоос илүү тоотой байсан. Харин насанд хүрсэн резус макакегийн авто замын улмаас хорогдсон тоо нь залуу макакегийн тооноос 1.4 дахин илүү байлаа(Pragatheesh, 2011). Эдгээр судалгаануудын нэгэн жигд байдал дутагдалтай, мөн харьцангуй цөөн тоотой зэргээс шалтгаалж ерөнхийд нь дүгнэх боломжгүй. гэхдээ олон төрөл зүйлд авто замын улмаас үхэж хорогдох эрсдэлд эрэгчин ямар нэгэн хамааралтай гэж шууд дүгнэх боломжгүй.

баримтжуулсан болно(Menon et al., 2015). Чинхай-Түвдийн төмөр замYin et al., (2006b) дээр ихэнх гүүр, хоолойг (галт тэрэгний шаардлагатай зэрэглэлийг хадгалах зорилгоор барьсан) том хөхтөн амьтад хөндлөн гарахад ашигладаггүй болох нь харагдсан. Долоон жилийн дарааWang et al. (2018) баримтжуулсан 13 хөхтөн амьтан эдгээр хэд хэдэн гүүр, хоолойг ашиглаж байжээ, том туурайтан амьтад (жишээлбэл, зэрлэг сарлаг, *Bos mutus*; кианг, *Equus kiang*; Төвдийн гөрөөс, Төвдийн зээр, *Procapra picticaudata*) жижиг махчин амьтдын гүүрийн доогуур гарахыг илүүд үздэг байв (жишээлбэл уулын үен, *Mustela altaica* Азийн дорго, *Mustela leucurus* гэх мэт). Гэхдээ нэг төмөр замын хоёр талд байгаа тахьны зээр дэх генетикийн огцом өөрчлөлт, ялгарлаас харахад тэд эдгээр ижил байгууламжийг замаар дайран гарахад ашиглаагүй байж магадгүй юм(Yu et al., 2017). Өөрөөр хэлбэл Хүн, малын гарцаар тусгайлан барьсан гарц байгууламжаас ихэвчлэн цагаан зээр(Ito et al., 2013), Монгол дахь Азийн зэрлэг илжигнүүд (Хулан(Kaczensky et al., 2011)) зайлсхийж байсны үр дүнд эдгээр амьтад төмөр замаар аюулгүй нэвтэрч чадахгүй болсон. Тодорхой зорилтот зүйлүүдэд зориулсан гарцын байгууламжийн байршил, дизайныг өөрчлөх нь Азид харьцангуй шинэ зүйл бөгөөд үүнд цаашид байгаль хамгаалагчид болон инженерүүдийн хамтын ажиллагаа шаардлагатай. Ийм нэг жишээг одоогоор Бангладешт хэрэгжүүлж байна. Энд шинэ төмөр замыг дайран өнгөрөх байгууламжуудын зураг төсөл, байршлыг зааны хөдөлгөөний талаарх хээрийн мэдээлэлд үндэслэн өөрчилж байна (Bangladesh Railway, 2018).

ДҮГНЭЛТ: ТӨМӨР ЗАМ

Төмөр замын зэрлэг амьтдад үзүүлэх нөлөөллийн судалгаа нь дэлхийн замын нөлөөллийн судалгаанаас хоцорч байгаа бөгөөд Азид мөн адил дүр зураг харагдаж байна. Төмөр замын экологийн судалгааг авто замтай харьцуулахад гуравны нэгээс бага хувьтай байгааг олж мэдсэн. Гэхдээ бид энэхүү судалгааны хүрээнд тодорхой өргөн хүрээний сэдвүүдийг олж чадсан юм. Шууд нөлөөлөл нь ихэвчлэн заан гэх мэт том биетэй амьтдад чиглэгддэг, орон зайн жижиг хэмжигдэхүүн дэх шууд бус нөлөөлөлд туурайтан амьтад, шувууд багтсан болно. Замын экологийн баримт бичгийн нэгэн адил хүн амын хэмжээнд зэрлэг амьтдад үзүүлэх шууд болон шууд бус нөлөөллийг сайн судлаагүй бөгөөд энэ нь төмөр замын зүгээс популяцын тогтвортой байдалд үзүүлэх нөлөөллийн талаар байгаль хамгааллын талаар хүчтэй мэдэгдэл гаргахад хүндрэлтэй болгодог. Замаас ялгаатай нь хүн, амьтны зан төлөвийн өөрчлөлттэй холбоотой хөнгөвчлөх, бууруулах арга хэмжээг илүү сайн судалсан болно (голдуу зааны хувьд ч гэсэн), эдгээр арга хэмжээг хэрэгжүүлэхэд зарим хүндрэл тулгардаг. Гарцын байгууламжийг ашиглах нь ялангуяа хөхтөн амьтдын хувьд илүү их байгаа нь харагдсан.

ҮР ДҮНГ ХЭЛБЭРЭЭР: ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ШУГАМ

ЦАХИЛГААНЫ ШУГАМЫН АН АМЬТДАД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

EI: ЦАХИЛГААНЫ ШУГАМЫН ШУУД НӨЛӨӨ

Цахилгаанд цохиулах, мөргөлдөх зэргээр цахилгаан шугам нь зэрлэг амьтдад шууд нөлөөлж, хорогдол, бэртэл гэмтэлд хүргэдэг. Цахилгаан дамжуулах шугамаас үүдэлтэй осол, хорогдлыг дор хаяж 113 зүйлд бүртгэсэн (Хүснэгт8), тэдгээрээс 92 нь шувуу, 20 нь хөхтөн, 1 нь мөлхөгч байлаа.

Хүснэгт8: Цахилгаан шугамд өртсөн зүйлийн тоо

ХҮСНЭГТ 8: ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ШУГАМТАЙ МӨРГӨЛДӨХ, ЦАХИЛГААНД ЦОХИУЛАХ ЗЭРГЭЭР ШУУД НӨЛӨӨЛӨЛД АВТСАН ТӨРӨЛ ЗҮЙЛҮҮД, IUCN -ийн АЮУЛ ЗАНАЛХИЙЛСЭН УЛААН ДАНСАНД ЗААСАН ХАМГААЛАЛТЫН СТАТУСААР НЭГТГЭН ХАРУУЛАВ (IUCN, 2020B)				
IUCN-ийн Улаан жагсаалтын статус	Шувуу	Хөхтөн амьтан	Хэвлийгээр явагч хоёр нутагтан	Нийт
Маш ховордсон	2	2	-	4
Ховордсон	5	9	-	14
Маш ховордсон	7	4	-	11
Аюулд ойрхон төрөл зүйл	7	-	-	7
Хамгийн бага анхаарал татсан	71	5	1	76
Нийт	92	20	1	113

Бутан, Казахстан, Хятад, Энэтхэг, Шри Ланка, Монгол гэсэн зургаан оронд шувуу цахилгаанд цохиулж үхсэн тохиолдол 92 төрөл зүйлд бүртгэгдсэн байна. Махчин шувууд ялангуяа цахилгаанд цохиулах нь өртөмтгий байдаг бөгөөд шувуу цахилгаанд цохиулсан тоо хэмжээ хамгийн их хувийг эзэлдэг. Тухайлбал Казахстанд(Lasch et al., 2010) 44 хувь, Монгол(Amartuvshin & Gombobaatar, 2012) 60 хувьд хүрчээ. Хятадын баруун хэсэгт махчин шувуудын 20 хувь (11 зүйл) цахилгаанд цохиулах аюулд өртжээ(Mei et al., 2008). Идлэг шонхор (*Falco cherrug*), том толботой бүргэд (*Aquila clanga*), Талын бүргэд (*Aquila nipalensis*) зэрэг амьтдын цахилгаанд цохиулж хорогдох тохиолдол олон улс орноос бүртгэгдсэн нь энэхүү аюул заналхийлэл нь тэдний мэдэгдэж буй ихэнх хэсэгт өргөн тархсан байгааг харуулдаг. Монголд махчин шувуудын зүй бүс хорогдол үндсэндээ цахилгааны шон дээр цахилгаанд цохиулснаас үүдэлтэй байсан нь шонхор шувуу зөвхөн махчин шувуудын хорогдлын талаас илүү хувийг эзэлж байлаа(Lasch et al., 2010).

Цахилгаан цохилтоор хорогдох тохиолдол орон зай, цаг хугацаанаас хамаардаг, улирлын байдлаас хамаарч өөр өөр байдаг, мөн гадаад орчноос мөн хамаардаг (Lasch et al 2010). Жишээлбэл, махчин шувууны идэш тэжээл нь цахилгаан цохилтын тоо хэмжээний өөрчлөлтөд нэлээд хувийг эзэлсэн(Dixon et al., 2017). Мөн түүнчлэн хөхтөн амьтдын нягтшил өндөр байдал 15 кВ -ын цахилгаан дамжуулах шугамын хослол идлэг шонхрыг цахилгаанд цохиулах гол цэг болгосон(Dixon, 2016). Цахилгаан дамжуулах шугамын хүчдэл нь Монголд цахилгаанд цохиулах осолд хүчтэй нөлөө үзүүлсэн 15 кВ-ын цахилгаан дамжуулах шугам нь цахилгаанд цохиулж үхэх

ослын 80 гаруй хувийг эзэлдэг(Amartuvshin & Gombobaatar, 2012). Гэхдээ цахилгаан шонгийн бүтэц, тохиргоо нь Энэтхэгт цахилгаанд цохиулах ослын тодорхойлох хамгийн чухал хүчин зүйл байв(Harness et al., 2013).

Үүрээ засах, суух, дээгүүр нь эргэлдэх зэрэг байдал нь зарим амьтдыг цахилгаанд цохиулах шалтгаан болдог. Жишээ нь Идлэг шонхор шувууны цахилгаан дамжуулах шугам дээр үүрлэх нь цахилгаанд цохиулах эрсдэлийг нэмэгдүүлдэг(Ellis, 2010). Цахилгааны шон, хөндлөвчний орой дээр өндөр Шилийн сар шувуу (*Buteo hemilasius*) үүрээ засдаг бол Идлэг шонхор, lesser kestrels (*Falco naumanni*) шон болон хөндлөвч дээр үүрлэж, суух нь элбэг (Амартүвшин & Гомбобаатар, 2012). Цахилгаан дамжуулах шугамын доор үхсэн шувууд нь хэрээ зэрэг шувуудыг татаж тэднийг үхэлд хүргэдэг (Lasch et al., 2010). Цахилгаан дамжуулах шугамын улмаас цахилгаанд цохиулж үхэх ослын гуравны нэгээс илүү хувь нь хэрээний төрөл зүйл юм. Тухайлбал Энэтхэгт 37 хувь, Монголд 34 хувь нь хэрээний төрөл зүйл байлаа(Amartuvshin & Gombobaatar, 2012; Harness et al., 2013).

Шувууд цахилгаан дамжуулах шугамтай мөргөлдсөни(Burnside et al., 2018; Takase et al., 2020; Tere & Parasharya, 2011)й улмаас үхэл, хорогдол, бэртэж гэмтэх шалтгаан болдо(Cheng et al., 2019; F. Li et al., 2011)г. Цахилгаан дамжуулах шугамтай мөргөлдсөний улмаас шувууд үхэж хорогдох тохиолдол Узбекистан, Япон, Хятад, Энэтхэг, Монгол улсад 35 зүйлд бүртгэгдсэн байна. 35 зүйлийн дотроос IUCN -ийн Улаан жагсаалтад орсон зүйлийн 29 хувьд аюул нөлөө үзүүлж байна. Усны шувууд, дэглий, Columbids (тагтаа, sandgrouse), Пассеринууд (цагираг, тоншуул болон бусад) нь мөргөлдөөний улмаас үхэх нь нийтлэг байв (Lasch et al., 2010). Хорогдлын тоо улирлын хувьд харилцан адилгүй, жишээ нь Жороо тоодог (*Chlamydotis macqueenii*) зүйлийн ослын 80 хувь нь өвлийн улиралд тохиолддог(Burnside et al., 2018). Цахилгаан дамжуулах шугамаас болж нүүдлийн шувууд олонтоо үхэж, бэртэж гэмтдэг(Dixon et al., 2013). Судалт толгойтой галуу (*Anser indicus*) гэх мэт улирлын чанартай нүүдлийн шувууд Төв Азийн нислэгийн замд байрлах цахилгаан дамжуулах шугамтай олонтоо мөргөлддөг (Шугаман дэд бүтэц ба бусад, 2011). Үүний адилаар Хятадад Зүүн Ази/Австралиас нүүдэллэн ирж буй улаан титэмтэй тогоруу (*Grus japonensis*) цахилгаан дамжуулах шугамтай холбоотой осол, гэмтэлд өртсөн болохыг судалгаанд тэмдэглэжээ(Cheng et al., 2019; Luo et al., 2014; Su & Zou, 2012).

Шувуудын эрчимтэй ашигладаг газар нутгаар дайран өнгөрч буй цахилгаан дамжуулах шугамын нөлөөлөлд шувууд илүүтэй өртдөг. Жишээ нь үржлийн амьдрах орчин(Sundar & Choudhury, 2005), тэжээлийн орчин(Tere & Parasharya, 2011), байгалийн амьдрах орчин(Kurhade, 2017) нь цахилгаан шугамтай мөргөлдөөний улмаас үхэх өндөр эрсдэлийг бий болгодог. Цахилгаан дамжуулах шугамын хүчдэлээс шалтгаалан шугамтай мөргүүлэх үед үхэх тохиолдол эрс ялгаатай байна. Жишээ нь Монголд хийсэн урт хугацааны судалгаанаас харахад шувуу цахилгаан шугамыг мөргөсний улмаас үхэх тохиолдлын 90 хувь нь зөвхөн хоёр төрлийн цахилгаан дамжуулах шугам дээр илүү тохиолдсон. Үүнд: ослын 50 хувь нь 110 kV-ийн шугам дээр, 40 хувь нь 15kV-ийн шугам дээр тус тус тохиолдсон (Амартүвшин ба Гомбобаатар, 2012). Харьцуулан авч үзвэл Узбекистанд хийсэн богино хугацааны судалгаанаас харахад жороо тоодог шувуу нь өндөр ба нам хүчдэлийн шугамтай мөргөлдөх магадлал ижил байв(Burnside et al., 2018). Хэдийгээр нэг газарт байсан ч гэсэн хоорондоо нягт холбоотой төрөл зүйлүүд нь цахилгаан дамжуулах шугамтай мөргөлдөх нь илүү өндөр магадлалтай байв. Том фламинго (*Phoeniconaias roseus*) цахилгаан дамжуулах шугамтай мөргөлдөх магадлал өндөр байсан бол бага фламинго (*Phoeniconaias minor*) нь түгээх шугамтай мөргөлдөх магадлал өндөр байв(Tere & Parasharya, 2011). Монгол улсад мөргөлдөөний улмаас

үхсэн тохиолдлуудын ихэнх нь шугамын дунд хэсэгт(Amartuvshin & Gombobaatar, 2012) тохиолдсон нь бууруулах арга хэмжээний гол голомт бүсийг илтгэж байна.

Цахилгаан дамжуулах шугам дээр цахилгаанд цохиулах нь хөхтөн амьтдын(Molur et al., 2007) үхэл, хорогдолд хүчтэй нөлөөлдөг нь сармагчны төрөл илүү өндөр эрсдэлтэй. Жишээ нь цахилгаанд цохиулах осол нь Бутан дахь алтан лангур, Энэтхэгийн хойд тал дахь саарал лангуруудын гол аюул юм(Ma et al., 2015; Thinley et al., 2020). Ази тивд цахилгаан дамжуулах шугам дээр цахилгаанд цохиулах ослын улмаас устаж үгүй болох аюулд орсон 14 төрлийн амьтдын үхэл хорогдол бүртгэгдсэн байна. Тухайлбал хоёр нь нэн ховордсон, найм нь ховордсон, дөрөв нь эмзэг бүлгийн амьтад юм. Алтан лангур, Бенгалийн удаан лорис, малгайт лангур зэрэг гурван зүйлийн хувьд цахилгаан дамжуулах шугамын ослын тархалтын талаар олон улс орноос мэдээлэгдсэн. Приматууд аюулгүй байдлын үүднээс цахилгаан дамжуулах шугам ашиглан дамжих, замыг давах эсвэл хүн, нохой зэргээс зугтааж цахилгаан дамжуулах шугамын шон дээр авирах үед гардаг сармагчинууд цахилгаанд цохиулах нь элбэг(Al-Razi et al., 2019; Dittus, 2020). Сармагчнуудын осол нь цахилгаан дамжуулах шугамын хүчдэлээс хамаарч өөр өөр байдаг; жишээ нь резус макаке сармагчнуудын 71 хувь нь бага хүчдэлтэй цахилгаан дамжуулах шугамд цохиулж осолддог(Kumar & Kumar, 2015). Цахилгаан дамжуулах шугам дээр цахилгаанд цохиулах нь олон төрөл зүйлүүдэд ослын шалтгаан болдог. Жишээ нь Энэтхэгийн нисдэг үнэг (*Pteropus giganteus*), том хамартай жимсний сарьсан багваахай (*Cynopterus sphinx*), Ратанаворабханы жимсний сарьсан багваахай (*Megaerops niphanae*), Рюкю нисдэг үнэг (*Pteropus dasymallus*) гэх мэт(Vincenot et al., 2015). Энэтхэгийн(Molur et al., 2007; Rajeshkumar et al., 2013; Senacha, 2009) нисдэг үнэг цахилгаанд цохиулах осол нь цахилгаан дамжуулах шугамд хэт ойртсоноос (ойролцоох жимсний мод руу авирах) болдог. Шри Ланкад утаснууд босоо чиглэлд байх нь цахилгаан дамжуулах шугамд цохиулах эрсдэлийг илүү нэмэгдүүлдэг(Tella et al., 2020). Азийн заан гэх мэт том биетэй төрөл зүйлүүд нь Шри Ланка, Энэтхэгт цахилгаан дамжуулах шугамаас унжсан утсанд цохиулдаг (Vijeyamohan et al., 2006; Palei et al., 2014).

E2: ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ШУГАМЫН ШУУД БУС НӨЛӨӨ

Цахилгаан дамжуулах шугам нь амьдрах орчны алдагдал, хуваагдал, өөрчлөлтөөс болж таксономийн төрөл зүйлд ихээхэн шууд бус нөлөө үзүүлж болзошгүй юм. Цахилгаан дамжуулах шугамын доорх ургамлуудыг тачирлах, цэвэрлэх нь байгалийн амьдрах орчин алдагдаж, хуваагдах шалтгаан болдог. Жишээ нь өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугамын улмаас Хятадад Энэтхэг –Хятадын саарал лангур (*Trachypithecus crepusculus*) амьдрах орчин алдагдсан,(Ma et al., 2015) мөн Бутанд устах аюулд өртөж буй улаан панданы (*Ailurus fulgens*) амьдрах орчин нь цахилгаан дамжуулах шугамаас болж хуваагджээ(Dendup et al., 2020). Энэтхэгт 32 жилийн хугацаанд 8,171 га ойн талбайг цахилгаан дамжуулах шугамын зориулалтаар өөрчилсөн байна.

E3: ПОПУЛЯЦЫН ТӨВШНИЙ ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ШУГАМЫН ШУУД БА ШУУД БУС НӨЛӨӨЛӨЛ

Цөөн хэдэн судалгаанд цахилгаан дамжуулах шугамын популяцад үзүүлэх шууд ба шууд бус нөлөөг судалсан. Үүнээс гадна осол хорогдлын талаарх тоог сэг идэшт шувуу зэрэгт нийцүүлэн тохируулга хийх хэрэгтэй. Энэ тооцоог хийхгүй тохиолдолд үхэл, хорогдлын тоог дутуу үнэлэх болно. Энэтхэгт нэгэн судалгаанаас харахад амьтны сэг зэмийн хадгалах, үлдэх магадлал цаг хугацааны явцад буурч байгаа, энэ нь биеийн жингээс хамааралтай байдаг. Том шувууны сэг зэм нь жижиг шувууны сэг зэмээс илүү удаан хадгалагдах, орхигдох магадлал өндөр байв(Uddin, 2017). Энэтхэгт хийсэн олон жилийн үнэлгээнд тооцооноор цахилгаан дамжуулах шугамтай

мөргөлдсөнөөр орон нутгийн сарус тогорууны (*Grus antigone*) популяцын бараг нэг хувь нь үхэж хорогдсон гэсэн тооцоо гарчээ(Sundar & Choudhury, 2005). Илүү түршлагатай нисдэг, орон нутгийн амьдрах орчноо сайн мэддэг насанд хүрсэн болон суурин шувуудтай харьцуулахад залуу, үржлийн бус, сарнин нисэж байгаа сарус тогоруу шувуу цахилгааны шугамтай мөргөлдөх эрсдэл өндөртэй(Sundar & Choudhury, 2005). Диксон (2016) Монголд идлэг шонхор шувууны цахилгаанд цохиулах тохиолдлыг нэг жилээр тооцсон. Энэ тоо 4 116 (90 хувь CI = 713-7951) байлаа. Таамагласны дагуу жилийн доторх үхэл хорогдлын төвшин маш их ялгаатай байсан, тухайлбал нүүдлийн өмнөх болон дараах үед үхэл хорогдлын мэдэгдэхүйц өндөр оргил үеүд таарсан(Dixon et al., 2020). Начин шонхрын (*Falco tinnunculus*) үхлийн ихэнх хувийг эмэгчин, бие гүйцээгүй шувуу эзэлж байсан бол (Ласч нар, 2010), идлэг шонхор шувууны үхэл хорогдлын 88 хувь нь бие гүйцээгүй залуу шувууд (Диксон нар, 2020) байлаа. Үүний адилаар залуу резус макакүүд цахилгаанд цохиулах гэмтлийн хувь хамгийн өндөр байсан. Эрэгчин нь ч гэсэн эмэгчнээс илүү цахилгаанд цохиулах магадлал өндөр, мөн борооны улиралд цахилгаанд цохиулах нь хамгийн их байсан (Kumar & Kumar 2015). Хойд тал нутгийн саарал лангурын хувьд цахилгаан дамжуулах шугамын ослоор орон нутгийн популяцын 2.8 хувь нь нэг газарт үхэж хорогджээ(Ma et al., 2015).

ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ШУГАМЫН ЗҮГЭЭС АН АМЬТДАД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ

М1: АМЬТНЫ ДАДАЛ, ЗАН ТӨЛӨВИЙГ ӨӨРЧЛӨХ ЗАМААР ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ШУГАМЫН НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ

Утасны тэмдэглэгээ нь шувуу цахилгаан дамжуулах шугамыг тод харах чадварыг сайжруулдаг. Үүнд: дугуй сараалж, спираль болон бусад төхөөрөмжийг суурилуулснаар шувууны мөргөлдөх ослыг 50 хувиар бууруулж чадна(Bernardino et al., 2019). Ази тивд утсанд тоноглол дүүжлэх практик эхний шатандаа явж байна. Энэтхэгт нэн ховордсон Энэтхэгийн тоодог шувуу цахилгаан дамжуулах шугамтай мөргөлдөхөөс урьдчилан сэргийлэхийн тулд шувуу үргээгчийг цахилгаан дамжуулах шугамд зүүсэн боловч түүний үр дүн одоогоорDashnyam et al., (2016) тодорхой бус,тэдгээр тоноглолын (ороомог, дугуй сараалж, тавганцар гэх мэт) механик хөдөлгөөнт чанарыг шалгасан. Эдгээр тоноглолыг суулгаснаас хойш 9 сарын дараа спиралийн эвдрэлийн хувь 0 хувь байсан бол сараалжин хийсэгчийн эвдрэл 21 хувьтай байв. Илүү том загвартай харьцуулахад жижиг хэмжээтэй хийсэх хэрэгслийн эвдрэлийн төвшин өндөр байв(Dashnyam et al., 2016). Зарим тохиолдолд утсанд хийсэгч бэхлэх нь хангалтгүй байж болох бөгөөд үүнтэй зэрэгцэн хөнгөвчлөх, бууруулах бусад арга хэмжээг авах шаардлагатай болдог. Жишээ нь Японд утсанд хийсэгч тоноглол зүүх, утсыг хэсэгчлэн салгах, шилжүүлэх холимог арга хэрэглэснээр 1970-74 онд улаан титэмтэй тогорууны мөргөлдөөний улмаас нас баралтын 71 хувь цахилгаанд цохиулах осол эзэлж байсан бол 1985-86 онд үхэл хорогдлын ердөө найман хувь болж буурсан байна(Masatomi, 1991). Шувуудын цахилгаан дамжуулах шугамыг мөргөх ослыг бууруулахын тулд нисгэгчгүй дрон, нисэх төхөөрөмж ашиглах гэх мэт технологийн дэвшил нь хийсэгч тоноглол суурилуулах зардлыг бууруулж болох юм(Lobermeier et al., 2015).

М2: ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ШУГАМААС АМЬТДЫГ ТУСГААРЛАХ ЗОРИЛГОТОЙ ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ШУГАМЫН НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

Шувууны цахилгаанд цохиулах эрсдэлийг бууруулахын тулд хэд хэдэн төхөөрөмж, тоноглолуудыг түршиж үзсэн. Энэ нь юуны түрүүнд Монголд махчин шувууд цахилгаанд цохиулах ослыг багасгахад чиглэсэн болно. Эдгээр төхөөрөмжүүд нь ихэвчлэн чимэглэлийн чанартай бөгөөд хоёр

том ангилалд багтаасан. Үүнд: нэгдүгээрт шувууг утсан дээр суухаас сэргийлдэг төхөөрөмжүүд, хоёрдугаарт хүчдэлтэй утастай хүрэлцэж барихаас сэргийлдэг төхөөрөмжүүд(Dixon et al., 2019). Цахилгаантай утастай шүргэлцэхээс урьдчилан сэргийлэхийн тулд хоёр арга хэмжээг үнэлсэн. Үүнд: 1) тусгаарлагчийн тагийг байрлуулах, 2) утсыг дахин тохируулах. Шон ба хөндлөвч дээр тусгаарлагч бүрхүүл, таг байрлуулснаар цахилгаанд цохиулах ослыг 59 хувь (шон дээр), 66 хувиар (хөндлөвч дээр) бууруулжээ. Эргэдэг толь, хөндийрүүлэгчтэй зүүнүүд хадааснууд, тусгаарлагч, сойзон үргээгч, хадаас гэх мэт шон дээр суухыг хориглох, саатуулах төхөөрөмжүүдийн дотроос хөндлөвч дээр суурилуулсан эргэдэг толь цахилгаанд цохиулах ослыг 91 хувиар бууруулсан боловч хэсэг хугацааны дараа ихэнх нь эвдрэлд орсон байлаа. Хөндийрүүлэгчтэй хадааснууд энэ ослыг 85 хувиар бууруулсан(Dixon et al., 2018).

Сармагчинууд цахилгаанд цохиулах ослоос урьдчилан сэргийлэхийн тулд Шри Ланкад токак макака (*Macaca sinica*) дээр хийсэн урт хугацааны судалгаа нь өвөрмөц бууруулах арга хэмжээг бий болгох, хөгжүүлэх, суурилуулах, турших боломжийг олгосон юм. Цахилгаан дамжуулах шугамын шон дээр төмөр тусгаарлагч бамбай, хаалт суурилуулснаар үхэл хорогдол 100 хувь буурсан нь амьтдыг шонгийн оройд хүрч, цахилгаан дамжуулах шугамтай контактлахаас сэргийлсэн(Dittus, 2020). Ойт нутаг дэвсгэрт цахилгаан дамжуулах шугам болон бусад шугаман дэд бүтцийн нөлөөллийг бууруулахын тулд агаарын дүүжин гүүр байгуулах нь маш чухал юм. Энэ нь сармагчны шилжилт, хөдөлгөөний явцад хамгаалах үүрэг гүйцэтгэнэ. Цахилгаан дамжуулах шугамд цохиулах ослыг бууруулах агаарын гүүрний талаарх баримт бичиг Азид дутагдаж байна. Сармагчнууд агаарын гүүр ашигласан байдлыг хянах нь чухал ач холбогдолтой мэдээллийг өгнө. Жишээлбэл, Баруун Жава мужид Жаван лориз (*Nycticebus javanicus*) нь гүүрийг суулгаснаас хойш 3-30 хоногийн дараа гүүрийг ашиглаж эхлэв(Birot et al., 2020). Энэтхэгт хоолок гиббон сармагчин агаарын гүүрийг хоёр сарын хугацаанд 31 удаа ашигласан байна(Das et al., 2009). Дасан зохицох хугацааны дараагаар Хайнан гиббон сармагчин (*Nomascus hainanus*) агаарын гүүр ашиглах нь цаг хугацааны явцад нэмэгдсэн(Chan et al., 2020). Заан цахилгаан дамжуулах агаарын шугамд цохиулах ослоос урьдчилан сэргийлэхэд Энэтхэгийн Засгийн газрын Байгаль орчин, ой, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас гаргасан удирдамжийн төслийг зөвлөмжөөр 20 ба 20 градусаас дээш налуутай газрын гадаргын хувьд цахилгаан дамжуулах шугамын хамгийн доод цэг нь 20 фут (зургаан метр), 30 фут (есөн метр) байх ёстой.

Дүгнэлт: ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ШУГАМ

Цахилгаан дамжуулах шугамын судалгааны ихэнх хэсэг нь зэрлэг ан амьтдад үзүүлэх шууд үзүүлэх нөлөөлөлд чиглэсэн бол зөвхөн хоёр судалгаагаар шууд бус нөлөөллийг тайлбарласан болно. Зарим судалгаанд зөвхөн цахилгаан дамжуулах шугамд цохиулах осол болон мөргөлдөөний талаарх ажиглалтыг бүртгэн тэмдэглэсэн байдаг бол бусад судалгаанд шууд нөлөөллийг илүү нарийвчлан тайлбарлаж, үхэл хорогдлын шалтгаан болох тодорхой хүчин зүйлсийг судалсан болно. Авто зам, төмөр замын нэгэн адил популяцын төвшинд цахилгаан дамжуулах шугамын нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ дутмаг байна. Судалгааг голчлон шувуу, дараа нь хөхтөн амьтад дээр (ихэвчлэн примат, сарьсан багваахай) хийсэн. Азийн бусад хэсэгт цахилгаан дамжуулах шугамын нөлөөллийг бууруулахад одоогийн нөлөөллийг бууруулах баримт бичиг, судалгаанууд нь үндсэндээ Төв Азид анхаарлаа хандуулж, хүчин чармайлт гаргаж байгаа бөгөөд зөвхөн эхлэл шатандаа байна. Амьтдын зан байдлыг өөрчлөх арга хэмжээтэй харьцуулахад цахилгаан дамжуулах шугамаас төрөл зүйлийг тусгаарлах, салгах арга хэмжээ илүү

түгээмэл байдаг. Хөнгөвчлөх арга хэмжээний үр дүнгийн талаар системчилсэн баримт бичиг байхгүй тул үүнийг хийх шаардлагатай байна.

АНХААРАЛ ТАТСАН ТӨРӨЛ ЗҮЙЛ БА ТАКСОНОМИЙН АНГИЛАЛ ЗҮЙ

АЗИЙН ЗААН

Азийн заанууд дэлхий даяар ховордсон(Williams et al., 2019) амьтдын ангилалд багтдаг бөгөөд 13 орны бүх улс орнуудад байгаль хамгаалах арга хэмжээний гол цөмд багтсан. (Sukumar et al., 2003)-аар хянан шалгасан) Улмаар тэд Азийн судалгааны баримт бичигт шугаман дэд бүтцийн талаарх судалгаанд гол анхаарлаа хандуулсан бөгөөд 29 судалгаатай байв. Гэхдээ эдгээр судалгаануудын ихэнх нь Энэтхэгт (17), дараа нь Хятад улсад (4) хийгдсэн байна. Популяцын төвшний нөлөөллийн судалгааг (E3) хамгийн ихээр 15 судалгаанд судлагдсан, дараа нь жижиг хэмжээний шүүд нөлөөллийг (E1; 14 судалгаа), үүний дараа жижиг хэмжээтэй шүүд бус нөлөөллийг (E2; есөн судалгаа) судалсан.

Заанууд галт тэрэгтэй мөргөлдөх, машинтай мөргөлдөх, цахилгаан дамжуулах шугамд цохиулах зэргээр үхэж хорогдох боломжтой. Тэдгээрээс галт тэрэгтэй мөргөлдөх осол судалгаанд хамгийн сайн судлагдсан зүйл юм. Баримт бичигт тэмдэглэсэн галт тэрэгтэй мөргөлдсөн ослуудын бүгд Энэтхэгт хамааралтай учраас (Roy et al., 2009) жишээлбэл Энэтхэг нь Азийн зааны популяцын(Menon & Tiwari, 2019) талаас илүү хувийг эзэлдэг бөгөөд дэлхийн хамгийн урт гуравдахь төмөр замын сүлжээ энд байрладаг (World Bank, 2020). Гэхдээ өндөр хурдны төмөр замын сүлжээ хөгжиж буй Шри Ланка зэрэг бусад орнуудад заанууд галт тэрэгтэй мөргөлдөх нь өртөмхий болж байна(Williams et al., 2019). Зам дээр машинтай мөргөлдөх нь илүү ховор тохиолддог боловч эдгээр осол Малайз(Wadey et al., 2018), Хятад(Pan et al., 2009) зэрэг орнуудад бүртгэгдсэн байдаг. Санамсаргүйгээр цахилгаанд цохиулсны улмаас үхэж хорогдох эрсдэл ихэвчлэн Энэтхэгт бүртгэгдсэн бөгөөд энэ нь заан унжсан утас эсвэл тасарсан цахилгаан дамжуулах шугамтай холбоо контактлахад тохиолддог (жишээлбэлPalei et al., 2014). Заан галт тэрэгтэй мөргөлдөх эрсдэлт хүчин зүйлүүдэд шөнийн цаг(S. Mitra, 2017), зам дагуух(Singh et al., 2001) хүний үйлдлээс үүссэн гаралтай хог хаягдал, замын огцом муруй(Dasgupta & Ghosh, 2015), галт тэрэгний тоо, хурд(Roy et al., 2009), заан хурдан зугтахад(Singh et al., 2001) саад болдог зам дагуух эгц далан, мөн зааны сүргийн нэг гишүүн нь төмөр замын ойролцоо гацсан үед сүргийн бусад гишүүд түүнийг сахиж удаан хугацаанд хүлээх зэрэг олон хүчин зүйл нөлөөлнө(Joshi & Puri, 2019). Цаашлаад заанууд хуучны хөдөлгөөний дадал болсон замаараа гол замыг хөндлөн гарах үед заанууд машинтай мөргөлдөх хандлагатай(Pan et al., 2009).

Шугаман дэд бүтцийн улмаас зааны үхлийн популяцын төвшний үр дагаврыг ойлгохын тулд популяцын тоо (зохих хэмжээнд) болон хорогдлын нийт тооцоог гаргах шаардлагатай. Мөн популяцын тодорхой бүлэг осолд өртөж байгаа бол нас, хүйс гэх мэт ангиллаар нарийвчлан судлах, харьцуулах нь зүйтэй. Ийм шинж чанарыг шинжлэх ухааны судалгаанд сайн анализ хийдэггүй боловч батлагдаагүй баримт судалгаанаас харахад эдгээр нь тодорхой цэг, газарт илүү хүчтэй үйлчлэл нөлөөлөл үзүүлдэг байж болох юм. Жишээ нь галт тэрэгтэй мөргөлдсөний улмаас үхэж хорогдох осол Энэтхэгийн Ражажин үндэсний цэцэрлэгт хүрээлэнд тохиолдсон үхэл хорогдлын 45 хувийг эзэлж байна (Singh et al., 2001). Хэд хэдэн судалгаанаас харахад эмэгчин эрэгчнээсээ илүү галт тэрэгний осолд үхэж үрэгддэг (жишээлбэлSingh et al., 2001; Palei et al., 2013; Joshi & Puri, 2019)), гэхдээ эмэгчин нь ерөнхийдөө зааны популяцын илүү хувийг эзэлдэг. Популяцын хэмжээг тооцон залруулга хийхэд Roy & Sukumar (2017) бие гүйцсэн эрэгчин заанууд Энэтхэгийн Хойд Бенгал мужид эмэгчнийг бодвол галт тэрэгний ослоор илүү үхэж үрэгдэх магадлал 2.5 дахин их байжээ. Түүнчлэн Энэтхэгийн нэгэн талбайд илүү олон эрэгчин заанууд

цахилгаанд цохиулсан (санаатай болон санамсаргүй байдлаар) тогтоогдсон(Palei et al., 2014). Бие гүйцсэн эрэгчин зааны соёлоос шалтгаалж хулгайн ан хийх, тариан талбайгаа хамгаалах зорилгоор зааныг хороодог учраас шугаман дэд бүтцийн улмаас зааны үхэл хорогдол(Menon & Tiwari, 2019) эрэгчин зааны популяцад ихээхэн нөлөөлж болзошгүй юм. Цахилгаанд цохиулах (санаатай эсвэл санамсаргүй байдлаар) болон галт тэрэгтэй мөргөлдсөний үр дагавраар 2015-2018 онд Энэтхэгт гарсан хүний хүчин зүйлийн улмаас 373 зааны хорогдлын 77 хувийг эзэлж байна(Ganesh, 2019). Автомашинтай мөргөлдсөний улмаас популяцын төвшинд үзүүлэх нөлөөллийг сайн тогтоогоогүй боловч Зүүн Өмнөд Ази, Хятадаас хийсэн судалгаанаас харахад Өмнөд Ази дахь цахилгаанд цохиулах, галт тэрэгтэй мөргөлдөх ослуудтай харьцуулахад,эдгээр нь харьцангуй түгээмэл биш.

Шугаман дэд бүтэц нь амьдрах орчин, хүний үйл ажиллагааны өөрчлөлтөөр заануудад жижиг, том хэмжээгээр шууд бусаар нөлөөлж болзошгүй юм. Замын зарим хэсэгт хулгайн ан хийх, хүний нөлөөлөл өндөр байх магадлал их байдаг(Wadey et al., 2018). Заримдаа заантай зөрчилдсөний улмаас зааныг хорооход цахилгаан дамжуулах хоёрдогч шугамын цахилгааныг хууль бусаар ашигладаг(Rangarajan et al., 2010). Зам дагуух суурин газруудын хурдацтай өсөлт нь зааныг суурин газрууд руу ойртоход саад болж болзошгүй юм(Gangadharan et al., 2017). Тиймээс амьтад эдгээр замын нөлөөллийн бүсээс зайлсхийж, энэ нь илүү өргөн цар хүрээнд зааны тархалтыг хумьдаг (өөрөөр хэлбэл, замын ойролцооSharma et al., 2020) газарт амьдрах орчны хэрэглээ багатай, түүнчлэн популяцуудын хоорондын холбоонд нөлөөлдөг. Сүүлийн үед шугаман дэд бүтцийн гурван төрөл ой мод руу өргөжин тэлж байгаа нь экологийн зарим хүнд нөхцөлд байгаа зааныг татах нөхцөл болсон. Жишээ нь томоохон хурдны зам барих нь Малайзын ширэнгэн ойд том “бүсийг” бий болгож, заануудыг ойр орчимд нь хооллоход хүргэсний(Yamamoto-Ebina et al., 2016) Menon et al. (2015)үр дүнд хортой хогийн ургамал их байгаа хэдий ч цахилгаан дамжуулах шугамын доогуур заанууд ихээр бэлчих, идээшлэх болсон. Заанууд цахилгаан дамжуулах шугамын доогуурх цэвэрлэсэн талбайг нүүдэл, хөдөлгөөн хийхэд илүүтэй ашигладагтай энэ нь холбоотой байж болно. Гэхдээ зааны тархалт, хөдөлгөөнийг тодорхойлоход цахилгаан дамжуулах шугамын нөлөөллийг сайн судлаагүй байна.

Амьтны хөдөлгөөн бол шугаман дэд бүтцийн нөлөөнд автдаг экологийн гол үйл явц юм. Хурдны зам нь замын ачаалал(Huang et al., 2020), үс зайлуулах суваг зэрэг холбогдох дэд бүтцийн улмаас зааны хөдөлгөөнийг 80 хүртэл хувиар бууруулсан(Wadey et al., 2018). Гэсэн хэдий ч заанууд саадгүй бага хурдтай замаар байнга шилжин явдаг (жишээ ньPan et al., 2009). Замын хөдөлгөөний ачаалал, хөдөлгөөний хурд, физик саад нөлөөллөөс гадна тээврийн хэрэгслээр зорчиж байгаа хүмүүсийн зан байдал нь зааны зам хөндлөн гарах хөдөлгөөнд тодорхой нөлөө үзүүлдэг гол хүчин зүйл юм. Жишээ нь хүмүүс зогсох, чимээ гаргах, эсвэл зааны зүг алхах үед заанууд замаар гарах оролдлогоо орхих, зугтахад хүрдэг(Vidya & Thuppil, 2010). Ялангуяа заанууд замын хоёр талын бэлчээр, нөөцөд хүрэхийн тулд төмөр замаар дайран гарах зааны хөдөлгөөн ихэвчлэн тохиолддог(Sarma et al., 2008). Цахилгаан дамжуулах шугамын зүгээс зааны хөдөлгөөнд үзүүлэх нөлөө тодорхойгүй байгаа ч энэ нь хөдөлгөөнийг хөнгөвчлөх магадлалтай(Menon et al., 2015). Хэдийгээр шугаман дэд бүтцүүдэд зааны хөдөлгөөний талаар олон судалгаа хийгдсэн боловч хөдөлгөөний бууралт нь зааны популяцын оршин тогтнол эсвэл генетикийн бүтцэд хэрхэн нөлөөлдөг талаар бараг тодорхойгүй. Популяцын төвшний эдгээр нөлөөлөл нь шугаман дэд бүтэц зааны популяцад хэрхэн нөлөөлж байгааг ойлгохын тулд илүү их анхаарал шаарддаг.

Авто зам, төмөр замд үзүүлэх шууд нөлөөллийг бууруулахын тулд хүмүүс болон амьтдын зан байдлыг өөрчлөх арга хэмжээг ихэвчлэн хэрэгжүүлдэг. Эдгээрт замын эргэлт, муруй(Palei et al., 2013) дагуух ургамлыг цэвэрлэх замаар зааны харагдах байдлыг сайжруулах, авто зам эсвэл төмөр замын(Panda et al., 2020) мэдэгдэж буй гарцын цэгүүдийн дагуу тэмдэглэгээ хийх, галт тэрэгний операторт эрт сэрэмжлүүлэх зорилгоор зам дагуу эргүүл хийх зэрэг олон арга хэмжээ багтана(Joshi & Puri, 2019). Өндөр эрсдэлтэй хэсгүүдэд галт тэрэгнүүдэд хурдны хязгаарлалт тогтоож болно (жишээ ньMinistry of Environment & Forest, 2015). Зам дагуух хүний шалтгаантай хоол хүнсний хаягдлыг цэвэрлэх, түүнчлэн амьтдыг татах хүчин зүйлсийг цэвэрлэх, (усны нүх гэх мэт) замаас холдуулах зэрэг арга нь хэмжээ нь Энэтхэгт тодорхой нэг цэгт үхэл хорогдлыг эрс бууруулахад хувь нэмрээ өгсөн(WTI, 2016). Далангийн налууг аажим өнцөгтэй болгосноор заанууд ирж буй галт тэрэгнээс илүү сайн зугтах боломжтой(Singh et al., 2001). Шууд бүс нөлөөллийг бууруулах арга хэмжээнд хулгайн анчдын(Clements et al., 2014) нэвтрэх боломжийг багасгахын тулд зам дагуу эргүүл хийх, пост шалгах, цахилгаан эрчим хүчийг хууль бусаар ашиглахаас сэргийлэхийн тулд цахилгаан дамжуулах шугамын хяналтыг сайжруулах гэх мэт арга хэмжээ багтана(Rangarajan et al., 2010). Гэхдээ эдгээр арга хэмжээг хэрэгжүүлэхэд эдгээр аргуудын ихэнх нь өндөр санаачилгатай байдал, хяналт шаарддаг. Жишээ нь галт тэрэгний оператор хурдны хязгаарыг хэтрүүлж магадгүй. Үүнд операторын хянамгай байдал дутагдана. (жишээлбэл, Singh et al., 2001)шөнийн цагаар төмөр замын дэргэд эргүүл хийх нь хэцүү, эрсдэлтэй байна, үүнд зориг тэвчээр шаардана). Иймээс эрт анхааруулга, сэрэмжлүүлэг өгөх технологийг илүүтэй сонирхож байна (жишээ ньRoy & Sukumar, 2017). Цаашлаад эдгээр аргуудыг бат бөх байдлаар үнэлэх нь ховор байдаг (жишээлбэл, хяналтын өмнө үзүүлэх нөлөөллийн хүрээ), энэ нь тэдний үр нөлөөг үнэлэхэд хэцүү болгодог.

Заануудыг цахилгаан дамжуулах шугамаас тусгаарлах арга хэмжээнд тогтмол хугацаанд засвар үйлчилгээ хийх хэрэгтэй. Үүний үр дүнд цахилгаан шугамаас хүчдэлтэй утас унжихаас сэргийлнэ. Авто зам, төмөр замын хувьд зааныг хашаа барих замаар замын хөдөлгөөнөөс холдуулж болно. Зааныг тусгаарлах зориулалттай хашааны ихэнх төрлүүд нь зааны эсрэг хязгаарлагдмал үр дүнтэй байдаг (жишээ нь; Lenin & Sukumar, 2011)хуучин төмөр замаас хийсэн хашаа нь үр дүнтэй болох нь батлагдсан боловч хэрэгжүүлэхэд өндөр үнэтэй байдаг(Saklani et al., 2018). Заан зам хөндлөн гарах нөхцөлийг бүрдүүлэхийн тулд гарцын байгууламжийг төмөр зам, замын дээгүүр эсвэл доор байрлуулж болно. Заанууд өөрсдийн дуртай маршрутын ойролцоо байрладаг гарцын байгууламжийг ашиглахыг илүүд үздэг. Хэрвээ эдгээр байрлал, зам дагуу гарц байхгүй бол заан хашааг шууд эвдлэхийг оролддог(Pan et al., 2009). Иймээс гарцын байгууламжийн талаарх эмпирик ажиглалт, эсвэл загварчилсан маршрут дээр үндэслэн гарцын байршлыг тодорхойлох ёстой (жишээлбэл, зам барихад хамгийн хямд төсөр аргыг судлах гэх мэтGangadharan et al., 2017). Заан заримдаа зэрлэг ан амьтдад зориулагдаагүй инженерийн зориулалтаар барьсан гарцын байгууламжийг заримдаа ашигладаг. Жишээ нь Хятадад заанууд инженерийн зориулалтаар барьсан урт гүүрэн доогуур замыг гардаг (Pan et al., 2009); Энэтхэгт заан амьтдад зориулагдаагүй төмөр замын урт гүүрэн доогуур зам хөндлөн гарч байгаа нь ажиглагдсан (Menon et al., 2015). Кени улсаас хийсэн сүүлийн үеийн судалгаанаас харахад Африкийн заанууд (*Loxodonta africana*) том гүүр, жижиг гүүрэн гарцыг ашиглан хурдны төмөр замын доогуур гарч байлаа (Okita-Ouma et al., 2021). Иймээс гарцын байгууламж нь автомашин эсвэл галт тэрэгтэй мөргөлдөхөөс сэргийлэх, бууруулах, мөн заануудын хоорондын чөлөөт байдал, экологийн уялдаа холбоог хангахад үр дүнтэй (хөрөнгө оруулалт ихтэй) арга болно.

ФЭЛИДУУД

Ази дахь *Felidae*-д шугаман дэд бүтцийн үзүүлэх нөлөөлөлтэй холбоотой 46 судалгааг бид олж мэдсэн. Энэтхэг эдгээр судалгаанд 20 хувь нэмэр оруулсан бол үүний дараа Хятад, Индонез, Малайз (тус бүр дөрвөн) орсон байна. Жижиг хэмжээтэй (E1) шууд нөлөөллийн талаар 21 судалгаанд дурдагдсан. Дараа нь популяцын хэмжээнд шууд ба шууд бус нөлөө (E3; 20 баримт бичиг), жижиг хэмжээтэй шууд бус нөлөө (E2; долоон баримт бичиг) эзэлж байна.

Шугаман дэд бүтцийн фелидэд үзүүлэх шууд нөлөөлөлтэй холбоотой ихэнх судалгаанууд нь авто болон төмөр замын ослын талаар авч үзсэн. Ийм мөргөлдөх осолд дор хаяж 11 төрлийн фелид бүртгэгдсэн байна. Тухайлбал Азийн арслан, бар, ирвэс, Евразийн шилүүс (*Lynx lynx*), ирвэс муур, зэвэрсэн толботой муур (Хавсралт А). Ираны нэгэн газарт тусгаарлагдаагүй цахилгаан кабелийн улмаас Евразийн шилүүс санамсаргүй байдлаар цахилгаанд цохиулж ослын талаар баримтжуулсан (Kolnegari et al., 2018). Эдгээр цөөн тооны судалгаагаар үхэл хорогдолтой холбоотой физикийн, ландшафтын, зан төлөвийн онцлог шинж чанарыг судалж үздэг. Гэхдээ галт тэрэгний зам, төмөр замын шалтгаант осол, хорогдлын холбоотой ерөнхий тайлбаруудад авто замын сүлжээг (Gubbi et al., 2014) нэмэгдүүлэх, галт тэргээр хэт хурд хэтрүүлэх зэрэг орно (Joshi, 2010). Зам хөндлөн гарах үед фелидүүд ихэвчлэн ашигладаг газруудад мөргөлдөөний гол цэг болдог (Kang et al., 2016). Өмнөд Солонгосын хурдны зам дээрх ирвэс муурын ослын нарийвчилсан судалгаанаас харахад замын өргөн, жолоочийн зан байдал, амьтны хөдөлгөөний улирлын шинж чанар нь ослын тоонд нөлөөлсөн (Kim et al., 2019). Шугаман дэд бүтцээс үүдэлтэй фелидийн хорогдлын холбоотой ийм хувьсагчдыг тодорхойлоход илүү их анхаарал хандуулах нь эдгээр хорогдлыг бууруулахад тусална.

Азид судалгааны материалуудад фелидийн хувьд жижиг хэмжээний шугаман дэд бүтцийн шууд бус нөлөөллийг судлаагүй байна. Зам нь шороон замгүй, хүмүүс тэр бүр ашигладаггүй бол бар, ирвэс гэх мэт том фелидүүд тухайн замыг илүүтэй ашигладаг. Иймээс ийм зам нь амьтад зам хөндлөн гарахад саад болдоггүй (жишээ нь Ngopraserit et al., 2007). Мөн түүнчлэн Gubbi et al., (2012) өдрийн түрш нээлттэй байсан зам мөн бүрэн хаагдсан хурдны зам дагуу бар, ирвэсийн тааралдах магадлалын тоонд ямар нэгэн онц ялгаа ажиглагдсангүй. Зам хөндлөн гарах үед хүний хөдөлгөөн их байдаг газруудад зарим барууд хүний нөлөөлөл давамгайлсан орчинд амьдрах чадвартай байдаг (Athreya et al., 2014). Ирвэс муур гэх мэт бусад зүйлүүд замын ойролцоогоос зайлсхийх хандлагатай боловч хэт хол биш, хэт ойр биш завсрын бэлчээрлэдэг (Mohd-Azlan et al., 2018). Зам нь хулгайн ан хийхэд нөлөөлдөг учраас (жишээ нь Hearn et al., 2019) бар зэрэг амьтдыг хамгаалах засмал болон шороон зам дээрх хүний үйл ажиллагааг хянах нь маш чухал юм (Clements et al., 2014). Өөр өөр төрлийн шугаман дэд бүтцэд үзүүлэх нарийн төвшний хариу үйлдлийн талаарх тодорхой нэг амьтанд суурилсан судалгаа нь жижиг хэмжээний замүүдэн зүгээс фелидэд үзүүлэх шууд бус нөлөөллийг цаашид ойлгоход тусална.

Шугаман дэд бүтцээс үүдэлтэй үхэл хорогдлын популяцын төвшний үр дагавар нь төрөл зүйл, экологийн орчны хувьд харилцан адилгүй байж болно. Солонгос болон Японд замаас үүдэлтэй ирвэс муурын үхэж хорогдох тохиолдол нь ихэвчлэн төрөх үед шилрэх тэр цаг үед таардаг (Японд 70 хувь; Kim et al., 2019) Солонгост 64 хувь Nakanishi et al., 2010)). Амьтны энэ цаг үе нь шугаман дэд бүтцээс үл хамааран өндөр эрсдэлийг учруулдаг. Гэхдээ бие гүйцсэн эрэгчин ба эмэгчиний тоогоор Малайз дахь ирвэс муурын зам дээр үхэж хорогдох тоо тус бүр 92 хувь (эрэгчин), 67 хувийг (эмэгчин) эзэлж байна (Laton et al., 2017). Иран дахь нэн ховордсон Азийн үчимбэрийн хувьд (*Acinonyx jubatus venaticus*), Замын шалтгаанд хорогдол нь (эрэгчин, эмэгчин аль алинд нь)

хорогдлын(Farhadinia et al., 2017) хоёр дахь том шалтгаан болжээ. Хүмүүс давамгайлсан газар нутагт ихэвчлэн тохиолддог ирвэс зэрэг зүйлүүд замын шалтгаантай үхэж хорогдоход өртөмтгий байдаг(Gubbi et al., 2014) боловч замын ослын зүгээс популяцын оршин тогтнох чадварт үзүүлэх нөлөөлөл, үр дагавар тодорхойгүй байна. Амур барын хувьд (*Panthera tigris altaica*) оршин тогтнох чадвар, амьд үлдэх чадвар нь замын шалтгаантай үхэл, хорогдлыг (нас баралтын хоёр дахь том шалтгаан;Goodrich et al., 2008), хянах, мөн хулгайн анчдын нэвтрэхэд саад учруулах зэргээс хамаарна (Kerley et al., 2002). Бусад фелидүүдийн (e.g., Florida panther (*Puma concolor coryi*) талаарх судалгаануудаас харахад авто замын нөлөөлөл нь замын нягтрал өндөртэй бүс нутгийн жижиг популяцын амьдрах чадварт ихээхэн нөлөөлдөг (Schwab & Zandbergen, 2011).

Шугаман дэд бүтэц нь газрын ашиглалтын томоохон өөрчлөлтийг өдөөж, амьдрах орчны алдагдал, хүний хүртээмжийг нэмэгдүүлж, улмаар фелидийн элбэг дэлбэг байдал, тархалтад нөлөөлдөг. Мьянмарт Янгон-Миткина чиглэлийн төмөр замыг барьснаар хүн амын суурьших, ашиглах өргөн боломжийг нээсэн бөгөөд энэ нь хулгайн анг гааруулж, барыг орон нутгаас түрэх, шахах, устгахад нөлөөлж болзошгүй (Aung et al., 2004). Хүний үйл ажиллагаа, газар ашиглалтын ийм өөрчлөлтүүд нь Гималайн бүс нутагт цоохор ирвэс, мануул зэрэг фелидүүдэд аюул заналхийлж байна (Dhendup et al., 2019; Farrington & Tsering, 2020). Борнео дахь замын нягтралаас шалтгаалан Сунда толбот ирвэсний(Brodie et al., 2015) тархац байдал буурсан ч ойн замын ойролцоо газар нутгийн ашиглалтын улмаас илрүүлэх магадлал илүү өндөр байсан боловч(Linkie et al., 2008), баруудын тархалт Индонезийн зам, Хятадад хатуу хүчилттай замаас алс хол байлаа(T. Wang et al., 2018). Барын тархалтын орон зайн өргөн хүрээний загвараас харахад нийт амьдрах орчны 43 хүртэлх хувь нь замын нөлөөллийн бүсэд багтсан, энэ нь барын тархцыг 20 орчим хувиар бууруулсан (Carter et al., 2020). Зарим төрөл зүйлийн популяцын хэмжээ нь амьдрах орчны доройтуулах хэмжээнээс илүү өндөр байсан, Жишээ нь Малайзад Сунда толбот ирвэсийн хувьд ирээдүйд мөхөж сүйрэх өндөр магадлалтай болохыг тэмдэглэсэн(Kaszta et al., 2019).

Шугаман дэд бүтцийн зүгээс төрөл зүйлийн хөдөлгөөн, чөлөөт байдалд нөлөөлсний улмаас Фелидийн элбэг байдал, тархалт өөрчлөгдөж болно. Бага нягтралтай тохиолддог фелид төрөл зүйлийн популяцын оршин тогтнох чадварын гол үзүүлэлт бол дэд популяц хоорондын уялдаа холбоо, чөлөөт байдал юм Linkie et al., 2008; Thatte et al., 2018). Олон судалгаануудад гол цөмүүдийн хоорондын уялдаа холбоонд чухал ач холбогдолтой газруудыг тодорхойлоход орон зайн загварчлалын техникийг ашигладаг. Эдгээр судалгаануудын зарим нь нөхөн сэргээх талбайг тодорхойлох (жишээ ньDutta et al., 2018)) зорилгоор уялдаа холбоо, чөлөөт байдлын өнөөгийн дүр төрхийг загварчилсан бол бусад судалгаанд бусад нь BRI гэх мэт төлөвлөсөн дэд бүтцийн төслүүдийн боломжит хуримтлагдах нөлөөллийг загварчилсан. (жишээ ньKaszta et al., 2020). Амьдрах орчны хуваагдмал байдлын ижил төстэй том загварууд нь цоохор ирвэсийг Хятадын эрчимтэй хөгжиж байгаа авто замын сүлжээнд өртөмхий байдалтай байгааг харуулсан(L. Zhang et al., 2015). Гэхдээ зарим судалгаанаас харахад шугаман дэд бүтцийн зүгээс генийн солилцоо, урсгалд үзүүлэх нөлөө нь газар ашиглалт гэх мэт бусад хүний үйлдлээс үүссэн шинж чанаруудаас бага байв. Жишээ нь хөдөлгөөний нягтрал ихтэй замаас бусад тохиолдолд авто замын нөлөө хүчтэй биш байлаа(Thatte et al., 2018). Замын хөдөлгөөний эрчим нь ирвэсийн генийн урсгалыг хэсэгчлэн тайлбарласан боловч газар ашиглалтын төрлөөс хамаагүй бага. Жишээлбэл авто зам нь ширэнгэн ой дахь муурын генийн урсгалд бага нөлөө үзүүлсэн (*Felis chaus*; Thatte et al., 2019). Эдгээр дүгнэлтээс үзэхэд шугаман саадыг давах эсвэл генетикийн маркераар дамжих бодит

хөдөлгөөн хэлбэрээр фелидүүдийн чөлөөт байдал, уялдаа холбооны загварчлалыг амьтдын хөдөлгөөний эмпирик ажиглалтаар нэмж баяжуулах нь чухал юм

Дэд бүтцийн шугаман нөлөөллийг бууруулах арга хэмжээ нь амьтан, хүний зан байдлыг өөрчилсөн арга хэмжээ хамарч болох ч эдгээрийг сайн баримтжуулаагүй эсвэл үнэлэн дүгнээгүй байна. Замын хөдөлгөөний ачаалалтай холбоотойгоор зам хөндлөн гарах цагийг загварчлах замаар хөнгөвчлөх, бууруулахын тулд хамгийн чухал замын хэсгийг сонгох зорилгоор замын шалтгаант үхэл хорогдлыг магадлалыг тооцох боломжтой(Habib et al., 2015). Замын хөдөлгөөнийг тогтмол эсвэл түр хугацаанд (жишээлбэл, шөнийн цагаар) хаах замаар замын хөдөлгөөнийг зохицуулах нь хэд хэдэн зүйл амьтдыг замын шалтгаант үхэл хорогдлоос хамгаалах, бууруулах ач холбогдолтой. Гэхдээ дээр дурдсаны дагуу байнгын хаалттай байдаг замтай харьцуулахад шөнийн цагаар хаалттай байдаг замын хэсэгт бар, ирвэсийн тохиолдоход онц зөрүү байгаагүй(Gubbi et al., 2012). Шөнийн биш өдрийн цагт нээлттэй байдаг замын хэсэгт түүрайтан амьтдын тохиолдоц их байгаа нь шөнийн цагт тулгардаг махчин амьтдаас зайлсхийхтэй холбоотой (Habib, Saxena, Mahima, et al., 2020). Энэ зам хаалттай байгаа үед бар гэх мэт том махчин амьтдын хөдөлгөөн нэмэгддэг учраас түүнийг зайлсхийх зорилгоор түрүүтэн амьтдын хөдөлгөөн буурдаг. Гол бүсийн галт тэрэгнүүдэд хурдны хязгаарлалт тогтоож болно (жишээлбэл, Азийн арслангийн сүүлчийн амьд үлдсэн популяцын байршилд; Rajvanshi et al., 2001). Ийм арга хэмжээг олон нийтийн мэдээлэл авах байрлалуудад судалгааны баримтуудад үндэслэн хөдөлшгүй баримтаар үнэлсэн нь ховор.

Хүн, амьтны зан төлөвийг өөрчлөх нарийн төвөгтэй байдаг ч Зэрлэг ан амьтдыг шугаман дэд бүтцээс (голчлон замаас) тусгаарладаг боловч гүүрэн гарцаар дамжин өнгөрөх боломжийг олгодог арга хэмжээ улам бүр түгээмэл болж байна. Ийм арга хэмжээг ихэвчлэн бар гэх мэт том биетэй, устгах аюулд орсон төрөл зүйлийг хамгаалах хэрэгцээ шаардлагатай холбоотой боловч бусад олон төрлийн амьтдад зориулсан дамжин өнгөрөх төлөвлөгөөг боловсруулахад чухал дэм, хөшүүрэг болно. Жишээлбэл, Энэтхэгийн нэгэн газарт баруудад зориулан барьсан гарцын байгууламжууд нь бусад 17 зүйл амьтдын хэрэгцээг хангаж байв (Habib et al., 2015). Баруудад зориулсан гарцын байгууламж нь ихэвчлэн хэдэн зуун метрийн хэмжээтэй өндөр замыг (ихэвчлэн гүүрэн гарц, зам хөндий гэж нэрлэдэг) хамардаг, барууд ийм байгууламжийг тогтмол дайран гардаг болохыг баримтжуулсан болно. Ирвэсийн нэгэн адил ширэнгийн муур, толбот муур мөн адил эрчимтэй ашиглаж байлаа(Habib, Saxena, Jhala, et al., 2020). Гэхдээ Фелидүүд нь бусад зориулалтаар баригдсан байгууламжийн замын доогуурх байгууламжуудаар (үс зайлуулах хоолой, гүүр гэх мэт) зам хөндлөн гарч байсан. Жишээ нь Энэтхэгт ирвэс үс зайлуулах сүвгийг ашиглан зам(Menon et al., 2015) хөндлөн гарч байгаа тухай судалгаанд тэмдэглэгдсэн. Зэрлэг муур (*Felis sylvestris*) ба мануул Хятадад үс зайлуулах хоолой ашиглан хурдны замыг хөндлөн гарч (хэдийгээр тэд илүү нээлттэй гүүрийг илүүд үздэг боловчLi et al., 2019) Евразийн шилүүс төмөр замын доорх суваг, гүүрийг хоёуланг нь ашигладаг байв (Y. Wang et al., 2018). Автомашин, төмөр замын олон зүйлийн дамжин өнгөрөх төлөвлөгөө боловсруулахад байгаль хамгааллын тэргүүлэх ач холбогдол бүхий томоохон фелидүүдийн ач холбогдол чухал байж болох юм.

ПРИМАТ БУЮУ САРМАГЧИНУУД

Ази дахь приматуудад шугаман дэд бүтцийн нөлөөлөлтэй холбоотой 48 судалгааг бид олж мэдсэн. Энэтхэг эдгээр судалгаанд 21 хувьд нэмэр оруулсан бол Индонез (долоон), Малайз (дөрөв) тус тус удаалжээ. Жижиг хэмжээтэй (EI) шууд нөлөөллийн судалгааг хамгийн ихдээ 32

баримт бичигт тэмдэглэсэн байдаг. үүний дараагаар хүн амын хэмжээнд шууд ба шууд бус нөлөө (E3; 14 баримт бичиг) ба жижиг хэмжигдэхүүн дэх шууд бус нөлөөлөл (E2; найман баримт бичиг) удаалсан.

Приматууд авто зам, төмөр зам, цахилгаан дамжуулах шугамаас шалтгаалсан хорогдолд өртөмтгий байдаг. Эдгээр шууд нөлөөлөлд дор хаяж 32 төрөл зүйлийг баримтжуулсан болно (Хавсралт А), Жишээ нь зам дээрх(Thinley et al., 2020) алтан лангур, төмөр зам дээрх малгайт лангур, цахилгаан дамжуулах шугам дээр(Raman, 2011) Баруун хоолок гиббон сармагчин гэх мэт (Sati, 2009). Эдгээр судалгааны ихэнх нь амьдрах орчин, түүнтэй холбоотой зан байдал, дадал, байдал, бие бялдрын онцлог шинж чанарыг сайтар судлахгүйгээр эдгээр үхэл хорогдлыг баримтжуулсан. Гэхдээ модны навчин бүрхүүлийн тасралтгүй байдал, хүний шалтгаант хоол хүнс зэрэг нь гол эрсдэлийн хүчин зүйлс болно. Зам, төмөр замын хувьд модны навчин бүрхүүлийн тасралтгүй байдал алдагдсантай холбоотойгоор сармагчинууд газраар зам хөндлөн гарч, энэ явцдаа машин, галт тэрэгтэй мөргөлдөхөд эмзэг болж болно (Umapathy et al., 2011). Газар дээр буух дургүй төрөл зүйлүүд (жишээлбэл, Өмнөдийн ягаан нүүртэй лангур, *Semnopithecus vetulus*; гэх мэт) Parker et al., 2008)цахилгаан дамжуулах шугамыг ашиглахыг илүүд үздэг. Үүнээс шалтгаалан цахилгаанд цохиулах нь элбэг (Roscoe et al., 2013). Зам, төмөр замын хувьд хүний шалтгаант хоол хүнс (хог, санаатайгаар амьтдад хаясан хоол хүнсний үлдэгдэл) нь зарим зүйлийн үхлийн гол шалтгаан болдог (жишээлбэл, хойд талын саарал лангур; Chhangani, 2004a). Бусад шугаман дэд бүтцийн хуримтлагдсан нөлөө нь үхэл хорогдлыг нэмэгдүүлж болзошгүй юм, тухайлбал цахилгаан дамжуулах шугамыг ихэвчлэн одоо байгаа зам дагуу байрлуулдаг бөгөөд энэ нь цахилгаанд цохиулах болон мөргөлдөх шалтгаан болдог (Al-Razi et al., 2019).

Шугаман дэд бүтцийн зүгээс сармагчнуудад үзүүлэх шууд бус нөлөөлөл нь орон нутгийн амьдрах орчны шинж чанар, зан төлөвийн өөрчлөлт, хөдөлгөөнд саад учруулах зэрэг орно. Шугаман дэд бүтцийн бүтээн байгуулалт нь сармагчнуудын амьдрах орчныг алдахад хүргэж болзошгүй юм (жишээлбэл, цахилгаан дамжуулах шугам; Ma et al., 2015). Замын хажуугийн амьдрах орчин нь зарим төрлийн хүний үйлдлээс үүссэн хоол хүнсийг хэрэглэх боломжийг олгодог (жишээ ньSrivastava et al., 2017b). Гэсэн хэдий ч эдгээр замуудын нэвтрэх боломж нь хүмүүсийг татдаг бөгөөд үүнээс гадна илүү их барилга байгууламж бий болоход хүргэдэг тул эдгээр амьтдыг (bonnet macaques гэх мэт) хүртэл нүүлгэн шилжүүлж магадгүй юм (Erinjery et al., 2017). Ийм дадал зуршил нь хүн-анхан шатны зөрчилдөөнд (хоол хүнс хайж байшин руу орох гэх мэт) томоохон асуудал үүсгэдэг гэж үздэг. Арслан сүүлт макака гэх мэт харьцангуй зожиг төрөл зүйлд ч мөн адил(Jeganathan, Mudappa, Raman, et al., 2018). Эцэст нь хэлэхэд хүмүүс нохой тэжээдэг бөгөөд энэ нь зам дагуу сармагчин барих нь бий (жишээлбэл, алтан лангур; Thinley et al., 2020). Ийм махчин амьтдаас зайлсхийх нь приматуудыг зам гэх мэт шугаман дэд бүтцээр үүсгэсэн модны навчин бүрхүүлээс зайлсхийж, улмаар амьдрах талбайн хоорондох хөдөлгөөнд саад учруулж болзошгүй юм (Y. Zhang et al., 2018).

Жижиг хэмжээний шугаман дэд бүтцийн шууд ба шууд бус нөлөөлөл нь популяцын төвшинд үр дагаварт хүргэж болзошгүй юм. Тээврийн хэрэгсэлтэй мөргөлдөх, галт тэрэгтэй мөргөлдөх, цахилгаан гүйдэлд өртөх зэрэг зэрлэг амьтдын шууд эндэгдэл нь тухайн нутгийн зүйлийн популяцын амьдрах чадварт нөлөөлж болзошгүй юм. Жишээлбэл, Шри Ланкад ойролцоогоор 195 Өмнөдийн ягаан нүүртэй лангуртай популяцад цахилгаанд цохиулах ослын улмаас 49 гэмтэл, 33 үхэл хорогдол бүртгэгдсэн (Roscoe et al., 2013). Зарим судалгаанаас харахад орон нутгийн төрөл зүйлийн боломжит байдалд залруулга хийхэд зам дээр эрэгчин нь илүү өртөх эрсдэлтэй болох нь

харагдсан (жишээ нь хойд талын саарал лангурын Chhangani, 2004 хувьд замын шалтгаант хорогдлын 60 хувьд, резус макаке сармагчинд хорогдлын эрсдэл 46 хувиар өндөр, Pragatheesh, 2011). Ойн аж ахуй, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийн худалдаа, аж үйлдвэрийн хөгжил зэргээс шалтгаалан шугам сүлжээний дэд бүтцийг (Estrada et al., 2019) өргөтгөх замаар ой модыг устгах гэх мэт шууд бус нөлөөллүүд гарч болзошгүй (Alamgir et al., 2019). Гэсэн хэдий ч шугаман дэд бүтэц нь приматуудад дандаа аюул учруулдаггүйг анхаарах нь чухал юм. Жишээлбэл, Явагийн хойрго Лорисийн хорогдлыг шугаман дэд бүтэц гэхээсээ илүү ойн шинж чанартай холбон авч үздэг (Sodik et al., 2020). Борнеогийн 88,000 км² талбайд Өмнөдийн гахай сүүлтэй макаки (*Macaca nemestrina*) нутгийн элбэг байдал болон замын сүлжээний нягтрал хоёрын хооронд ямар ч хамаарал байгаагүй (Brodie et al., 2015). Судалгааны цар хүрээ, дэд бүтцийн шугаман бүтэц, зохион байгуулалт нь саад тотгорыг арилгахад нөлөөлж болно. Жишээ нь хурдны зам нь хар цагаан шантгар хоншоортой сармагчны төрөл зүйлийн популяцын хоорондох сарнилтад чиглэсэн чөлөөт байдлыг хязгаарладаг гэж үздэг (Clauzel et al., 2015). Ерөнхийдөө шугаман дэд бүтцийн зүгээс приматад үзүүлэх популяцын төвшний нөлөөллийг цаашид судлах нь нөлөөллийг бууруулах арга хэмжээний байрлал, үйл ажиллагааг тодорхойлоход нэн чухал юм.

Шугаман дэд бүтцийн зүгээс приматад үзүүлэх шууд болон шууд бус нөлөөллийг бууруулах арга хэмжээнд дараах зүйлийг багтаж болно. Үүнд: амьтдын зан байдлыг өөрчлөх арга хэмжээ, хүний зан төлөвийг өөрчлөх арга хэмжээ, амьтдыг дэд бүтцээс тусгаарлах арга хэмжээ гэх мэт. Хүний зан төлөвийг өөрчлөх арга хэмжээнд зам дагуух үхэл хорогдлын өндөр цэгүүдэд хурдны хязгаарлалтыг бууруулах зэрэг орно (Healey et al., 2020). Бусад стратегиудын үр нөлөөг сайн мэдэхгүй ч гэсэн жолооч нарт сармагчинг тэжээхээс зайлсхийхийг анхааруулж болно (Pragatheesh, 2011).

Хүрээлэн буй модноос илүү өндөрт байрлуулах эсвэл газар доор булах замаар сармагчнуудыг цахилгаан дамжуулах шугамаас тусгаарлаж болно (Sati, 2009). Мөн авто зам, төмөр зам, цахилгаан дамжуулах шугамаар дамжин өнгөрөх хөдөлгөөнийг хөнгөвчлөх зорилгоор гарцын байгууламжийг ихэвчлэн байгуулдаг. Жишээлбэл ийм бүтэц нь арслан сүүлт макакуудад зориулж навчин бүрхүүлийн хоёр талын модон дээр бэхлэгдсэн резинэн зам бүхий нарийн туузаас бүрдэж болно (Jeganathan, Mudappa, Raman, et al., 2018). Модны навчин бүрхүүлтийн зориулалтаар бусад олон загварыг янз бүрийн сармагчинуудад зүйлд түршиж үзсэн (жишээ нь Birot et al., 2020)) нь модны бусад төрөл зүйлүүдэд мөн чухал ач холбогдолтой (Das et al., 2009). Ийм модны навчин бүрхүүлийн талаар цуглуулсан мэдээллээс (хэдийгээр шугаман дэд бүтцийн хүрээнд биш) харахад насны хүйсийн ангиллаар ийм агаарын байгууламжийг ашиглахад ялгаатай байлаа. Жишээ нь эмэгчин болон залуу насны Хайнан гиббонууд мод дамжихын тулд бие гүйцсэн эрэгчнүүдээс илүүтэйгээр агаарын дүүжинг ашигласан (Chan et al., 2020). Засвар үйлчилгээнд орон нутгийн дэмжлэгийг тусгах аргаар модны навчин бүрхүүлийг ашиглаж болно. Жишээ нь Индонезид ойн жижиг хэсгүүдийн хооронд хүний нөлөөлөл давамгайлсан газар нутгуудад өрхийн цэцэрлэгт усжуулалтын зорилгоор ашиглах агаарын усны хоолойг Явагийн хойрго Лорисын дамжих, дамжин явахад ашиглаж болно (Birot et al., 2020). Дүүжин замаас гадна Баруун хоолок гиббон сармагчин зам хөндлөн гарахад зориулж дор хаяж нэг том төмөр гүүрийг барьсан (Wildlife Institute of India, 2016) ч бүрэн баталгаажгаагүй мэдээллээс харахад энэхүү байгууламжийг тухайн төрөл зүйл ашиглаагүй байна (N. Mitra, 2019). Bonnet macaques гэх мэт илүү хуурай газрын төрөл зүйлийн амьтад инженерийн зориулалтаар барьсан гүүрэн гарц ашиглан зам хөндлөн гарч байгаа тухай судалгаанд бичигджээ (Menon et al., 2015). Хиймэл гарцын байгууламжийн талаарх олон

талт судалгаанаас харахад энэ бол амьдрах орчны хуваагдмал орчинд приматуудыг хамгаалах зорилгод илүү их анхаарлаа хандуулж байгаа талбар юм.

ТУУРАЙТНУУД

Ази дахь туруутан амьтдад шугаман дэд бүтцийн нөлөөлөлтэй холбоотой 49 судалгааг бид олж мэдсэн. Хятад, Энэтхэг эдгээр судалгаануудын 12-т хувь нэмэр оруулсан, үүний дараагаар Монгол (ес), Япон (дөрөв) удааллаа. Жижиг хэмжээтэй (Е1) шууд нөлөөллийн талаарх судалгааг 24 судалгаанд хамгийн их хамруулсан болно. Үүний дараагаар зүйлийн популяцын масштаб дахь шууд ба шууд бус нөлөөгөөр (Е3; 20 баримт бичиг), жижиг хэмжээтэй шууд бус нөлөөллөөр (Е2; 13 баримт бичиг) удаалсан.

Авто болон төмөр замын туруутан амьтдад үзүүлэх шууд нөлөөлөл нь Ази даяар өргөн тархсан бөгөөд сайн баримтжуулсан бөгөөд дор хаяж 17 зүйл багтдаг (Хавсралт А). Тэдгээрт Хятадад Wang et al., 2013) Сибирийн бор гөрөөс (тээврийн хэрэгсэлтэй мөргөлдөх, Японд Ando, 2003) сика буга (галт тэрэгтэй мөргөлдөх, Энэтхэгт Singh et al., 2001) горал (галт тэрэгтэй мөргөлдөх) зэрэг болно. Мөн үхэл хорогдол нь авто зам, төмөр замтай холбоотой дэд бүтцээс үүдэлтэй байж болно. Жишээ нь Монголын цагаан зээр төмөр замын дагуух торонд тээглэх нь бий (Ito et al., 2008). Хөхтөн амьтдын талаар хийсэн томоохон судалгааны бүрэлдэхүүнд туурайтан амьтдын үхэл, хорогдолтой холбоотой эрсдэлт хүчин зүйлсийг ихэвчлэн судалдаг (жишээ нь Seo et al., 2015) орон нутгийн амьд байгаль, орчин, төмөр зам, авто замын шинж чанар, үзүүлэлтүүд, амьтны зан төлөвийг судлах гэх мэт). Төмөр зам амралтын газрыг тэжээх газрыг салгах үед амьдрах орчны тохируулга нь мөргөлдөх эрсдэлтэй учраас гатлагын давтамжийг тодорхойлоход чухал үүрэг гүйцэтгэнэ (Ando, 2003). Үзэгдэх орчин муу байх (шөнийн цагаар эсвэл өвөлд гэх мэт) амьтдын үйл хөдлөлийн онцлогт нөлөөлж, сика буга гэх мэт мөргөлдөх эрсдэлийг нэмэгдүүлдэг (Soga et al., 2015). Жижиг туурайтан амьтадтай харьцуулахад гаур гэх мэт том туурайтны хувьд хурдны замыг хөндлөн гарахад зарцуулах цаг хугацаанаас хамаарч машинтай мөргөлдөх эрсдэлийг нэмэгдүүлдэг (Habib et al., 2015). Эцэст нь хэлэхэд авто зам эсвэл төмөр замын бүтэц нь (жишээлбэл, өвс тэжээл гэх мэт) туруутан амьтдыг татаж, тэдгээр амьтдыг гацах, тээглэх аюулд оруулдаг (Ito et al., 2008).

Зүйлийн популяцын төвшинд шууд нөлөөлөх үр дагаврыг Азийн ихэнх туурайтан амьтдын хувьд сайн судлаагүй болно. Өмнөд Солонгост (Choi, 2016) жил бүр 60,000 хүртэл усны буга үхэж үрэгддэг нь популяцын оршин тогтнох байдалд ноцтой аюул занал болно (Harris & Duckworth, 2014). Шугаман дэд бүтэцтэй холбоотой үхэл хорогдол нь популяцын зарим бүлэгт нөлөөлдөг (жишээлбэл, Ази тивийн эрэгчин үхэр гэх мэт Heinen & Kandel, 2006). Нийт үхэл хорогдолд шугаман дэд бүтцийн нөлөөлөл харилцан адилгүй, хувьсах шинж чанартай. Жишээ нь nilgai (*Boselaphus tragocamelus*)-ийн хүний шалтгаанд үхэл хорогдлын 15 хувьд машинтай мөргөлдөх шалтгаант ослууд нөлөөлнө (Bajwa & Chauhan, 2019). Шугаман дэд бүтцээс шалтгаалсан үхлийн тоо толгойн төвшний үр дүн нь Азид цаашид шинжлэн судлахад чухал бүс болно.

Авто зам, төмөр зам нь хүний үйл ажиллагааг өдөөж, амьтдын амьдрах орчныг ашиглахад нөлөөлж, хөдөлгөөнд саад учруулах зэргээр жижиг хэмжээтэйгээр туурайтан амьтдад шууд бусаар нөлөөлдөг. Авто зам нь туруутан амьтдыг агнаж устахад хүчтэй нөлөөлдөг (Clements et al., 2014). Цаашлаад хүний үйл ажиллагаа өсөлт, хөгжилт, зам дагуух суурьшил нь туурайтан амьтад дүрвэх, зайлсхийх шалтгаан болдог (Gangadharan et al., 2017). Хүний нөлөөлөл нь зэрлэг нохойн популяцыг нэмэгдүүлж болно. Жишээ нь туурайн амьтдыг агнах зэргээр нөлөөлнө. Зам дагуух

хашаа, хашлага амьтдын зугтахад нөлөөлснөөр үхэл хорогдлыг нэмэгдүүлдэг(Bajwa & Chauhan, 2019). Ийм замын нөлөөлөл нь замын ойролцоо орчны ашиглалт, хэрэглээг бууруулахад хүргэдэг (жишээлбэл, Азийн хулан; Bao-fa et al., 2007). Гэхдээ хэрэв хатуу хучилттай замаас махчин амьтад зайлсхийдэг бол хүний үйл ажиллагаа бага үед эдгээр махчин амьтадгүй газарт читал буга илүүтэй цугладаг. (тухайлбал шөнийн цагт)Habib, Saxena, Mahima, et al., 2020). Зам орчмын орон зайг ашиглахдаа ийм түр зуурын тусгаарлалт тахь, зээр, гөрөөс, горал зэрэг амьтдад ажиглагдсан (эдгээр нь бүгд өдрийн биш шөнийн цагт замд ойрхон тохиолддог) боловч гахай, сика буга гэх мэт хүний нөлөөлөлд дассан төрөл зүйлүүдэд ийм байдал ажиглагдаагүй (C. Li et al., 2009; Jia et al., 2015). Туруутан амьтад зам руу ойртоход тэд ихэнх цагаа сонор сэрэмжтэй өнгөрүүлж, өвс тэжээлээ идэх тэдний зарим үйл ажиллагаанд нөлөөлдөг(Bao-fa et al., 2007). Туурайтан амьтдын хөдөлгөөнд зам, төмөр зам (хашаатай үед) нөлөөлдөг. Жишээ нь төмөр зам дагуух хашаа нь Монголын цагаан зээр, Азийн зэрлэг илжиг буюу хулангийн хөдөлгөөнийг их хэмжээгээр бууруулсан(Ito et al., 2013). Тийм хашаа байхгүй газруудад замын гарц түгээмэл байдаг. Тиймээс сика буга мөргөлдөх эрсдэл багатай газарт төмөр замыг дайран гарч сурсан(Soga et al., 2015).

Шууд бус нөлөөллийн өргөн цар хүрээтэй үр дагаврын талаар зарим төрөл зүйлүүдэд илүүтэй судалсан ба эдгээр нөлөөлөл нь экологийн талаасаа харилцан адилгүй. Шугаман дэд бүтцийн нягтрал өндөр байх нь тал нутагт цагаан зээрийн элбэг байдалтай холбоотой байсан ч(Nandintsetseg et al., 2019) самбарын элбэг байдал нь ан агнуурын хяналт ихтэй ойн орчинд замын нягтралыг дагаж нэмэгдсэн(Brodie et al., 2015). Хашаатай төмөр замын саад нь Азийн хулангийн 17,000 км² амьдрах орчны хүртээмжийг хувааж, тасалдуулж(Kaczensky et al., 2011), улмаар тэдний амьдрах орчныг бууруулсан гэж үздэг. Монголын цагаан зээр гэх мэт нүүдлийн төрөл зүйлд нүүдэл хийхэд том талбай хэрэгтэй байгаа нь нөөц, өвс тэжээлийн боломжит байдлаас шалтгаалдаг ч тэдгээрийн хөдөлгөөнд төмөр замын дагуу хашаа нөлөөлдөг(Ito et al., 2013; Olson et al., 2009). Ерөнхийдөө шугаман дэд бүтцийн нягтрал нь гаур, самбар зэрэг зүйлийн популяцын хоорондын холбоог бууруулдаг гэж үздэг(Jayadevan et al., 2020). Шугаман дэд бүтцээс үүдэлтэй холболтын саад бэрхшээлийг өмнө нь холбогдсон зүйлийн популяцын генетикийн дэд бүтэц хэлбэрээр илэрхийлж болно. Хятадад хашаатай төмөр замын нөлөөлөл нь барилгын ажил эхэлснээс хойш хэдхэн жилийн дотор аль аль талд нь байгаа зээрийн зүйлийн популяцын хоорондох генетикийн зөрчлөөс тод харагдаж байв(Yu et al., 2017). Японы нэгэн газар зэрлэг гахайн зүйлийн популяцын генетикийн бүтэц нь төмөр замын саад бэрхшээлтэй уялдаатай байв(Tadano et al., 2016). Гэхдээ Монгол дахь төмөр замын хашлагаас үүдэлтэй хөдөлгөөнд ихээхэн саад тотгор учруулж (дээр дурдсан) байгаа боловч Цагаан зээрийн генетикийн дэд бүтэц хараахан тодорхой өөрчлөлт ороогүй байна(Okada et al., 2012). Энэхүү нөлөөллийн хүрээ нь жижиг хэмжээтэй шууд бус нөлөөллийг илүү сайн холбох, том зүйлийн популяцын шинж чанарт нөлөөлөх шаардлагатай байгааг онцлон тэмдэглэв.

Туруутан амьтдын зан авирт нөлөөлөх зорилготой тусгай арга хэмжээг цөөн хэдэн жишээг бид олж мэдсэн. Хүмүүсийн зан байдлыг өөрчлөхийг зорьж буй хөнгөвчлөх, бууруулах арга хэмжээ илүү давамгай байдаг. Үүнд зам дээрх хурд сааруулагч нь хөхтөн амьтдын үхэж хорогдох эрсдэлийг бууруулдаг(Menon et al., 2015). Зам хаагдах нь (тодорхой хугацаанд эсвэл бүрмөсөн) зарим зүйлийн амьтдын гадаад орчныг илүү их ашиглахад хүргэж болох боловч бусад зүйлд хүчтэй нөлөөлдөггүй. Жишээ нь өдрийн турш нээлттэй байсан хэсгүүдтэй харьцуулахад читал болон гаурыг тохиолдох тоо хэмжээ нь бүрмөсөн хаагдсан хурдны замын хэсгүүдэд илүү өндөр байв(Gubbi et al., 2012). Авто болон төмөр замд гарцын байгууламжийг байгуулсан тохиолдол нь туурайтан амьтдад илүү их судлагдсан. Хамгийн багаар 12 төрөл зүйл ийм байгууламжийг

ашигладаг болохыг баримтжуулсан. (Хавсралт C & D) Туруутан амьтдад амьтдын гарцад зориулагдаагүй барилга байгууламж (гүүр, явган хүний гарц гэх мэт) ашиглан замыг дайран гарч байгааг баримтжуулсан. Эдгээрт Сибирийн бор гөрөөс(Y. Wang et al., 2017), сика буга(Asari et al., 2020), хулгана буга (*Moschiola indica*; Menon et al., 2015)зэрэг багтана. Гэхдээ зөвхөн тодорхой газруудаар дайран гарах, өнгөрөх талаар баттай баталгаа тухайн ажиглалтаар илрээгүй. Нүүдэллэж буй Төвдийн цагаан зээр нь Чинхай-Түвдийн төмөр замаар аюулгүй зорчих боломжийг олгох хөндлөн огтлолын байгууламжид хүрэхийн тулд хамгийн оновчтой замаасаа 86 км зайтай байх ёстой гэж мэргэжилтнүүд дүгнэсэн(W. Xu et al., 2019). Иймээс гарцын байгууламжийн байршил, загвар нь шугаман дэд бүтцийн зүгээс туурайтан амьтдад үзүүлэх нөлөөллийг багасгахад чухал ач холбогдолтой юм.

ХЭВЛИЙГЭЭР ЯВАГЧ ХОЁР НУТАГТНУУД

Азийн хэвлийгээр явагч хоёр нутагтнуудад шугаман дэд бүтцийн нөлөөлөлтэй холбоотой 46 судалгааг бид олж тогтоосон. Эдгээр судалгаанд Энэтхэг 23 хувь нэмэр оруулсан бөгөөд дараа нь Шри Ланка (дөрөв), Хятад (гурван) орсон байна. Жижиг хэмжээтэй (E1) шууд нөлөөллийн судалгааг ихэнхдээ 41 баримт бичгээр, дараа нь зүйлийн популяцын хэмжээнд шууд ба шууд бус нөлөө (E3; таван баримт бичиг), жижиг хэмжигдэхүүн дэх шууд бус нөлөөллийг (E2; хоёр баримт бичиг) тусгасан болно.

Дор хаяж 240 мөлхөгч амьтдыг шугаман дэд бүтцийн шалтгаант (ялангуяа замаас) үхэл хорогдолд тохиолдлуудад баримтжуулсан бөгөөд үүнд могой, гүрвэл, яст мэлхий, матрын төлөөлөгчид багтдаг. Үүнд нэн ховордсон хоёр, эмзэг бүлгийн 9 зүйл багтсан болно (Хавсралт А). Шугаман дэд бүтцийн улмаас мөлхөгч амьтдын үхэл хорогдолтой холбоотой ихэнх баримт бичигт эдгээр үхэл хорогдлын талаар тэмдэглэсэн боловч зарим судалгаагаар мөргөлдөх эрсдэлийг нэмэгдүүлдэг хувьсагчдыг судалдаг. Устай ойрхон байх, мөн борооны улирал зэрэг нь Энэтхэгийн нэг газарт авто зам, төмөр замд намаг матрын үхэл хорогдох эрсдэлийг нэмэгдүүлдэг гэж үздэг(Vyas & Vasava, 2019). Устай ойрхон байх нь Филиппинд Зүүн Өмнөд Азийн хайрцаг яст мэлхий (*Cuora amboinensis*), Азийн навчит яст мэлхий (*Cyclemys dentata*) зэрэг амьтдын үхэж хорогдох тохиолдол ихэссэнтэй холбоотой байв(Bernardo, 2019). *Uropeltidae* гэх мэт зарим төрлүүд борооны дараа илүү идэвхтэй болдог (иймээс машины нөлөөлөлд илүү өртөмхий болдог)(Vijayakumar et al., 2001). Нэлээд ерөнхийд нь хэлбэл илүү олон мөлхөгчид илүү их амьдардаг орчинд үхэж хорогдож болзошгүй (жишээлбэл, цай тариалдагтай харьцуулахад ой модJeganathan, Mudappa, Kumar, et al., 2018). Зарим жолооч санаатайгаар зам дээр могойг онилж устгах тохиолдол бий(Marshall et al., 2018). Хэвлийгээр явагчийн зан төлөвт шууд үхэл хорогдлын эрсдэл нөлөөлдөг. Дулааны нөлөөллийн улмаас зорилгоор могой замд татагдах нь машинд дайруулах гол шалтгаан болдог(Pragatheesh & Rajvanshi, 2013). Идэш тэжээлийн эрэлд идэвхтэй явж байгаа могой нь үүрэндээ байгаа төрөл зүйлтэй харьцуулахад илүү өндөр эрсдэлийг бий болгодог (учир нь тэд зам дээр илүү их тааралддаг(Park et al., 2017). Хөхтнүүдийн адилаар мөлхөгчид нь замын хөдөлгөөний эрчимтэй хамаарал багатай учраас энэ нь машины хөдөлгөөн, эрчим ихтэй үед илүү их үхэж хорогдоход хүргэдэг(Seshadri & Ganesh, 2015). Гэхдээ хэвлийгээр явагч хоёр нутагтнуудын үхэл хорогдол нь замын эрчимтэй(Y. Wang et al., 2016) шууд холбоогүй байдаг нь талбайгаас хамааралтай онцлог юм. Замууд нь хүмүүсийн нэвтрэх боломжийг хөнгөвчилдөг бөгөөд тэд замдаа тааралдсан могойг алж, устгаж болзошгүй юм(Marshall et al., 2018). Гэхдээ жижиг төвшинд хэвлийгээр явагч хоёр нутагтнуудад авто замын шууд бус нөлөөллийн судалгаа харьцангуй бага.

Мөлхөгч амьтдын шугаман дэд бүтцийн зүйлийн популяцын төвшинд үзүүлэх нөлөө нь мөн шууд үхэл хорогдолд чиглэгддэг. Нэг судалгаанаас харахад зам дээр үхэж үрэгдсэн янз бүрийн мөлхөгч амьтдын тоо толгой болон ойролцоо амьдрах орчинд(Bhupathy et al., 2009) олдсон тоотой хамаарал байхгүй байсан нь замтай холбоотойгоор үхэл хорогдол нь зарим төрөл зүйлд илүү өндөр байж болно. Нийт үхэл хорогдолд замын шалтгаанд үхэл хорогдлын нөлөөллийг судалж үзээгүй ч хаан кобрагийн радио долгионоор шинжилсэн түүврийн 16 хувь нь Тайландад замын шалтгаант үхэл хорогдлын гол хохирол болсон(Marshall et al., 2018). Зарим популяцын бүлгүүд зам, галт тэрэг мөргөлдөхөд бусдаас илүү судлагдсан. Өмнөд Солонгосын зүүн хойд хэсэгт зам дээр үхэж үрэгдсэн 10 зүйлийн могойн 95 хувь нь бие гүйцсэн, 70 хувь нь эрэгчид байжээ(Park et al., 2017). Энэтхэгийн нэгэн газарт машин, галт тэрэгний улмаас үхэж үрэгдсэн намгийн матрын 67 хувь нь бие гүйцээгүй буюу залуу насны байжээ(Vyas & Vasava, 2019). Эдгээр судалгаанууд нь зүйлийн популяцад тодорхой бүлгийн тус бүр байгаа эсэхийг баталгаажуулаагүй тул төрөл зүйлийн популяцын оршин тогтнолын талаарх таамаглал тодорхой бус. Бах толгойтой гүрвэлийн зүйлийн популяцын генетикийн талаарх нэг судалгаанаас харахад Хятад дахь Чинхай-Түвдийн төмөр зам нь генийн урсгал, чөлөөт байдалд нөлөөлөл учруулаагүй байсан. Төмөр замын орчин тойрны зүйлс нь гүрвэлийг татаж, улмаар төрөл зүйлийн популяцыг дэмжсэн(D. Hu et al., 2012). Илүү өргөн цар хүрээнд дэд бүтцийн томоохон төслүүдээс амьдрах орчноо алдагдал нь мөлхөгч амьтдын амьдрах орчныг алдагдуулах, доройтолд оруулж хүргэж болзошгүй юм(Hughes, 2019).

Шугаман дэд бүтцийн зүгээс мөлхөгч амьтдад үзүүлэх нөлөөллийг бууруулахын тулд амьтдын зан төлөвийг өөрчлөх, хүний зан төлөвийг өөрчлөх, амьтдыг дэд бүтцээс бие даан тусгаарлах арга хэмжээ багтана. Мөлхөгчид замд татагдах байдлыг багасгах нэг арга бол дулааны зохицуулах материалаар хийсэн хиймэл гадаргууг ойролцоох замын дэргэд байрлуулах явдал юм(Pragatheesh & Rajvanshi, 2013). Гэхдээ бид ийм хөндлөнгийн оролцооны хэрэгжилтийг олж хараагүй байна. Тээврийн хэрэгслийн жолооч нарын зан байдлыг хурдны хязгаарлалтын арга замаар зохицуулж болно (жишээлбэл, зам дээр ойр ойрхон хурдны сааруулагч тавих гэх мэт). Энэ нь мөлхөгчид, түүний дотор хэд хэдэн зүйлийн үхэл хорогдлыг бууруулж болзошгүй юм(Menon et al., 2015). Замыг хаах (ялангуяа шөнийн цагаар), замын хөдөлгөөний эрчмийг зохицуулах зэрэг нь мөлхөгч амьтдын үхэл хорогдлыг бууруулахад тусалдаг(Seshadri & Ganesh, 2011). Мөлхөгчдийг замаас тусгаарлахтай холбоотой хөнгөвчлөх, бууруулах арга хэмжээ нь гарцын байгууламжтай хослуулсан физик хаалт (хашаа эсвэл хана)-ыг хамардаг. Могой хашлага дээгүүр авирахаас сэргийлж, тэднийг гарам руу чиглүүлэхийн тулд хашааны дээд хэсэг, хана нь тусгай нүхтэй байх хэрэгтэй(Pragatheesh & Rajvanshi, 2013). Том амьтдад (ялангуяа хөхтөн амьтдад) зориулж байгуулсан гарцын байгууламжууд нь замын өргөн хэсгийг хамарч байгаа бол мөлхөгчдөд ашиг тустай (жишээлбэл, хэрвээ тэд өргөгдсөн замын том хэсгийг хамарч байгаа болHabib, Saxena, Jhala, et al., 2020)) зарим тохиолдолд мөлхөгч амьтдад тусдаа бүтэц шаардлагатай байж болно. Хэдийгээр замыг хөнгөвчлөх, бууруулах арга хэмжээнд эдгээр нь шаардлагатай ч мөлхөгчийн хэрэгцээ шаардлагыг заавал биелүүлэх шаардлагагүй(Donggul et al., 2018).

ХОЁР НУТАГТАН

Бид Азид хоёр нутагтан амьтдад шугаман дэд бүтцийн нөлөөлөлтэй холбоотой 32 судалгааг олж тогтоосон ч эдгээрийн 31 судалгаа нь замын сэдвүүд, нэг нь төмөр замын сэдвүүд байв. Энэтхэг эдгээр судалгаанд 14 хувь нэмэр оруулсан бол Хятад (тав), Өмнөд Солонгос, Шри Ланка (тус бүр гурав) тус тус хамрагдсан байна. Жижиг хэмжээний (EI) шууд нөлөөллийн талаарх судалгаа нь эдгээр судалгааны дийлэнх хэсгийг (25) бүрдүүлсэн; зүйлийн популяцын хэмжээнд шууд ба шууд

бус нөлөөллийн талаар таван судалгаа хийсэн (E3), жижиг хэмжээний шууд бус нөлөөллийн талаар ганцхан судалгаа хийсэн (E2).

Мөргөлдөөнтэй холбоотой үхэл хорогдлыг Ази даяар хамгийн багадаа хоёр нутагтан амьтдын 69 зүйлийн хувьд баримтжуулсан болно. Үүнд устгах аюулд орсон 2 төрөл зүйл, эмзэг бүлгийн 13 төрөл зүйл байлаа (Хавсралт А). Хоёр нутагтан амьтдын автомашинтай мөргөлдөхөд хэд хэдэн эрсдэлт хүчин зүйл нөлөөлдөг гэж үздэг. Тээврийн хэрэгсэл амьдрах таатай орчноор (уст цэг гэх мэт) дамжин өнгөрөх үед үхэл хорогдол илүү нэмэгдэх магадлалтай. Ийм уст цэгүүдэд гол(Baskaran & Boominathan, 2010), намгархаг газар(Gu et al., 2011) зэрэг багтана. Илүү ерөнхийд нь хэлбэл газар тариалангийн талбайтай харьцуулахад хоёр нутагтан амьтдын үхэл хорогдлын төвшин нь ой модны орчинд илүү их тохиолддог (жишээ ньVijayakumar et al., 2001). Хоёр нутагтан амьтдын түр зуурын хэв маягийн талаар сайн судлагдсан бөгөөд хоёр нутагтны үйл хөдлөл, үржлийн онцлогтой шууд хамааралтай. Хоёр нутагтан амьтад машинд дайруулах эрсдэл шөнө(W. Zhang et al., 2018), борооны улиралд(Jeganathan, Mudappa, Kumar, et al., 2018), бороотой өдрүүдэд (Gu et al., 2011)өндөр байдагBhupathy et al., (2009). Хоёр нутагтан үржлийн газар нутагт хүрэх гэх мэт экологийн хэрэгцээ шаардлагын улмаас зам хөндлөн гарах үед (жишээ нь: үржүүлгийн амьдрах орчин, хээл хаях) мөргөлдөх эрсдэл, магадлал нэмэгддэг(Seo et al., 2015; Seshadri & Ganesh, 2011). Замын хөдөлгөөний эрчмийн өндөр байдал нь хоёр нутагтан амьтдын шууд үхэл хорогдолтой хамаарал, холбоотой (Z.C. Wang et al., 2015). Цаашлаад зам дээрх хөдөлгөөний хэмжээг нэмэгдсэнээр (хөхтөн амьтаас ялгаатай нь), хоёр нутагтан зайлсхийх, холдоход шууд хүргэдэг гэж үзэж болохгүй боловч хоёр нутагтан амьтад машинд дайруулах нь замын хөдөлгөөний эрчмийг даган нэмэгддэг байж болно(Seshadri & Ganesh, 2011). Тээврийн хэрэгсэлтэй мөргөлдөхөөс шалтгаалан шууд үхэлд хүргэхээс гадна хоёр нутагтан амьтад заримдаа замтай холбоотой дэд бүтцэд (жишээлбэл, ус зайлуулах суваг) гацаж, тэндээ үхэж болно(Z. Zhang et al., 2010).

Хоёр нутагтан амьтад тээврийн хэрэгслийн мөргөлдөөнөөс үүдэлтэй зүйлийн популяцын төвшний үр дагавар (ялангуяа зүйлийн популяцын амьдрах чадвар) сайн судлагдаагүй. Зам дээр үхэж хорогдох ослын талаарх хийсэн олон зүйлийн судалгаагаар хоёр нутагтан нь амьтдын төрөл зүйлийн ихэнх хувийг эзэлдэг (жишээлбэл, ЭнэтхэгийнBaskaran & Boominathan, 2010 нэг газарт 53 хувь, ИндонезийнHealey et al., 2020 64 хувь, Хятадад 86Y. Wang et al., 2013 хувь). Гэхдээ энэ байдал үргэлж үнэн байдаггүй (жишээ нь Seo et al., 2015; Silva et al., 2020). Ийм дүр зураг нь эдгээр газруудын бусад ангилал зүйтэй харьцуулахад хоёр нутагтан амьтдын элбэг байдлын ялгааг тусгаж болно. Зарим судалгаанд бүртгэгдсэн замын шалтгаант үхэл хорогдлын тохиолдлын тоо ба замтай ойролцоо нутагт хоёр нутагтан амьтдын элбэг байдал хоорондын хамаарлыг олж тогтоосон (жишээ нь:Bhupathy et al., 2009). Богино хугацаанд нүүдэллэдэг зүйлийн хувьд Солонгосын хумстай саламандерууд (*Onychodactylus koreanus*) гэх мэт амьтдын хувьд замын шалтгаант үхэл хорогдол нь бүх зүйлийн популяцын оршин тогтноход аюул занал учруулж болзошгүй юм(Shin et al., 2020). Ерөнхийдөө хоёр нутагтан амьтдын замын шалтгаант үхэл хорогдол болон зүйлийн популяцын амьдрах чадварын үр дагаврын хоорондын тоон холбоог сайн судлаагүй байна.

Хоёр нутагтан амьтдын судалгаанд хамрагдсан замуудын (бага цар хүрээнд болон зүйлийн популяцын төвшинд) шууд бус нөлөөлөл нь гол төлөв амьдрах орчны хэрэглээ/чанарын өөрчлөлт, тусгаарлах генетикийн нөлөөллөөс бүрдэнэ. Замын төвшинг өндөрлөх буюу өндөр далантай зам барих нь замын хоёр хажуугаар ус хуримтлуулж, энэ нь хоёр нутагтан цугларах хүчин зүйл

болдог(Healey et al., 2020). Ус зайлуулах сүвгийг мүү төлөвлөж, байгуулсан тохиолдолд амьтдыг татах ийм усан сан нь экологийн урхи болж хувирдаг(Z. Zhang et al., 2010). Зам дагуух гэрэлд шавьж татагдах нь хоёр нутагтан амьтдыг татах шалтгаан болно. Учир нь энэхүү шавьжид хоёр нутагтан амьтад ихээр татагдан(Bhupathy et al., 2009) ирдэг боловч энэ нь замын шалтгаант үхэл хорогдолд өртөмхий байдлыг үүсгэдэг. Илүү том ландшафтын хувьд замаас хол зайд хоёр нутагтан амьтдын баялаг байдал ажиглагдсан (Aryal et al., 2020). Шугаман дэд бүтэцтэй холбоотой амьдрах орчны томоохон доройтол нь хоёр нутагтан амьтдын амьдрах орчныг бууруулж болзошгүй юм (Hughes, 2019). Зам нь замаар амжилттай гарч буй амьтдын тоог бууруулж магадгүй юм (мөргөлдөөний улмаас шууд үхэж хорогдох эсвэл замын бүтцээр дамжин өнгөрөх нь бие махбодын хувьд хүндрэлтэй шалтгаанаас болж). Наад зах нь нэг судалгаагаар зүйлийн популяцын генетикт ийм саад тотгор учруулах үр дагаврыг судалсан болно. Үүнээс харахад авто замтай харьцуулахад Хятадын модны мэлхийн хувьд уулын нуруу нь зүйлийн популяцын генетикт илүү их нөлөө үзүүлсэн (Atlas & Fu, 2019). Өргөн хэмжээгээр жижиг ба том хэмжээний шугаман дэд бүтцийн шууд бус нөлөөллийг хоёр нутагтан амьтдын хувьд сайн судлаагүй болно.

Амьтны зан төлөвийг өөрчлөх замаар шууд ба шууд бус нөлөөллийг бууруулах нь хоёр нутагтан амьтдын хувьд сайн судлагдаагүй. Гэхдээ нэг судалгаагаар замын ойролцоох ач холбогдол багатай намгархаг газрын арилгахыг санал болгосон(Gu et al., 2011). Хүний зан төлөвийг өөрчлөх, үүнд шөнө(Ү. Zhang et al., 2018) зам хаах, мөргөлдөх гол цэг (Healey et al., 2020)дээр тэмдэглэгээг сайжруулах, хурдыг бууруулах гэх мэт арга хэмжээг санал болгосон(Menon et al., 2015). Судалгаанд эдгээр аргуудын үр нөлөөг үнэлсэн хангалттай судалгаа, үнэлгээ цөөхөн байдаг. Тусгаарлах хашаа барихтай хамтатган гарцын байгууламжийг төлөвлөх, байгуулах нь замын шалтгаант үхэл хорогдол, саад бэрхшээлийг багасгах гол арга зам гэж илүүтэй үзэх болсон. Гүүрэн гарц ба нүхэн гарцыг ихэвчлэн том зүйлийн амьтад зориулан бүтээдэг бөгөөд энэхүү загвар нь ихэвчлэн жижиг зүйлийн хэрэгцээ шаардлагыг орхигдуулдаг. Жишээ нь Өмнөд Солонгост түүвэрлэсэн нүхэн гарцуудын 47 хувь нь хоёр нутагтны хөдөлгөөнд зориулсан үзүүлэлт байхгүй(Donggul et al., 2018). Хоёр нутагтан амьтдын хөдөлгөөнийг дэмждэг байгууламжийн онцлогийг туршилтаар тодорхойлох зорилгоор цөөн хэдэн судалгаа хийгдсэн. Эдгээрийн нэг нь нүүдлийн үеэр хятад хүрэн мэлхийнүүд илүүд үздэг хонгилын хэмжээ, хэлбэр, доторх материалын талаар туршин шалгасан(Ү. Wang et al., 2019). Өөрөөр хэлбэл хоёр нутагтан амьтдыг ус зайлуулах хоолойд тээглэх, гацахгүй байх, замын дагуух хашааг давахгүй байх нөхцөлийг хангахын тулд (ердийн бах дээр тодорхойлсонZhang et al., 2010)) дамжуулах сүвгийн хамгийн тохиромжтой хэлбэрийг тодорхойлох туршилт хийх хэрэгтэй(Ү. Wang et al., 2019). Хоёр нутагтан амьтдын хувьд том амьтантай харьцуулахад шилжүүлэлтийн судалгааны харьцангуй хялбар байдал нь хөндлөн огтлолын шинж чанарыг баттай үнэлэх боломжийг олгодог.

ҮНДСЭН ОЛОЛТУУД

АВТО ЗАМ

1. Энэтхэг, Хятад нь 162 баримт бичигт хамгийн их судлагдсан орнууд байсан бөгөөд бидний хайлтын үр дүнгийн 55 хувийг эзэлжээ. Япон, Өмнөд Солонгос, Непал, Малайз зэрэг улсууд нэлээд олон тооны судалгаа хийсэн. Бусад ихэнх орны төлөөлөл харьцангуй бага байсан; Манай 28 зорилтот орны зургаа нь судалгаанд төлөөлөөгүй (тив даяар хийсэн судалгаанаас бусад).
2. Бид хөхтөн амьтдын таксономийн хэвийсэн утгыг олсон баримт бичгийн 69 хувьд төлөөлөлтэй (Зураг4). Гэсэн хэдий ч замын шалтгаанд үхэл хорогдлын тохиолдолд бүртгэгдсэн мөлхөгч амьтдын тоо хөхтөн амьтдын тооноос 62 хувиар их байв (Хүснэгт2). Хэдийгээр мөлхөгчид хөхтөн амьтдаас бараг хоёр дахин илүү өвөрмөц боловч замын зүгээс зэрлэг амьтдад үзүүлэх нөлөөллийг судлахад хөхтөн амьтдын онцлох ач холбогдол нь бусад төрөл зүйлд хамаарах ойлголтыг хязгаарлаж болзошгүй юм.
3. Шууд ба шууд бус нөлөөллийг жижиг хэмжигдэхүүнээр (жишээлбэл, нэг төмөр замын шугам эсвэл тухайн бүс нутгийн цөөн хэдэн тусгай зам гэх мэт) үнэлсэн судалгааг дор хаяж 611 зүйл (Хүснэгт2) ба 34 зүйлийн (Хүснэгт3) хувьд баримтжуулсан болно. Төрөл зүйлийн популяцын төвшний нөлөөллийг дор хаяж 41 зүйлээр тоологдсон болно (Зураг4). Энэхүү судалгаануудыг нэгтгэн үзвэл, Ази даяар олон төрөл зүйлийг төлөөлж замын зүгээс олон төрөл зүйлд үзүүлэх нөлөөллийг онцлон харуулжээ. Гэхдээ олж авсан мэдлэг нь шууд бус нөлөөлөл болон зүйлийн популяцын төвшний нөлөөлөлтэй харьцуулахад маш их гажсан байдаг.
4. Замын шууд нөлөөллийг ихэвчлэн жижиг хэсгүүдэд хэсэгчилсэн байдлаар, тодорхой газар дээр нь судалсан болно. Шууд нөлөөллийн судалгаа нь эдгээр үхэл хорогдлын шалтгааныг олж тогтоох, нотолгоонд суурилсан шийдлүүдийг боловсруулахаас илүүтэйгээр замын нөлөөллийг баримтжуулах (тухайлбал, зам дээр үхэж үрэгдсэн зүйлийн жагсаалтыг гаргах) дээр илүү төвлөрсөн байв. Үүний үр дүнд төрөл зүйлийн популяцын хамгааллын талаарх ерөнхий болон өргөтгөх боломжтой ойлголтыг харьцангуй цөөхөн гаргаж авсан.
5. Шууд бус нөлөөллийн хувьд (Хавсралт В) замын саад бэрхшээлийн нөлөөг харьцангуй сайн судалсан ч ялангуяа амьдрах орчин эсвэл ландшафтын уялдаа холбоог урьдчилан таамаглахад тусалдаг загваруудаар сайн судалсан. Эдгээр саад нөлөөний генетикийн үр дагаврыг, ялангуяа хөхтөн амьтдын хувьд улам бүр анхаарч байна (Хавсралт С). Харьцангуй богино хугацааны улмаас эдгээр үр дагаврын зарим нь хараахан тодорхой болоогүй байж магадгүй, Өндөр хурдны болон өндөр эрчимтэй замууд олон оронд эсвэл Ази тивийн биологийн олон янзын ландшафтад өргөн тархсан байдаг.
6. Төрөл зүйлийн популяцын төвшинд (үржил, нас баралтын төвшин гэх мэт) популяцын үзүүлэлт, төрөл зүйлтэй уялдаа холбоотой авто замын нөлөөллийг (шууд ба шууд бус) бараг судлаагүй болно. Энэ бол өнөөгийн судалгааны гол дутагдал юм.
7. Материалууд нь тэдгээрийн нөлөөг багасгахын тулд бууруулах арга хэмжээний үр ашгийг үнэлэхээс илүү авто замуудын нөлөөг судлахад чиглэгдсэн байдаг (495 хувь илүү судалгаа;

Зураг4). Хөнгөвчлөх арга хэмжээний тухай судалгаанууд нь баталгаа нотолгоотой судалгаатай харьцуулахад илүү давамгайл.

8. Дэлхийн бусад хэсэгт хөнгөвчлөх, бууруулах 30 гаруй арга хэмжээ авсан (Huijser et al., 2008), зөвхөн 10-ыг нь Ази тивд (бага ч гэсэн) авч үзсэн нь тогтоогдсон. Хөнгөвчлөх бусад арга хэмжээг (ялангуяа хүн, амьтны зан байдлыг өөрчлөхтэй холбоотой) хэд хэдэн оронд газар дээр нь хэрэгжүүлсэн (зохиогчдын баталгаа нотолгоогүй ажиглалт дээр үндэслэн). Ийм арга хэмжээний баримт бичиг, үнэлгээ дутмаг байгаа нь замын шууд болон шууд бус нөлөөллийг бууруулах, шилдэг туршлагыг хөгжүүлэхэд тэдний үр нөлөөг ойлгоход хүндрэлтэй байдал үүсгэдэг.
9. Зэрлэг ан амьтдыг замаас тусгаарладаг боловч хөндлөн огтлолын байгууламжаар дамжин өнгөрөх боломжийг олгодог хөнгөвчлөх, бууруулах арга хэмжээ (гүүрэн гарц, гүний гарц гэх мэт) Азийн хэд хэдэн оронд нэмэгдэж байна. Доод тал нь 39 зүйл амьтан зам хөндлөн гарахдаа эдгээр байгууламжийг ашиглаж байгааг баримтжуулсан болно (эдгээр нь зэрлэг ан амьтдын зориулалтаар байгуулагдсан эсэх, эсвэл энэ зорилгод нийцсэн эсэх; Хавсралт D). Бүтцийн хувьд тусгаарлах арга хэмжээг бусад бууруулах арга хэмжээнээс (Зураг4) илүү сайн баримтжуулсан байдаг. Ийм олон зуун барилга байгууламж, тэдгээрийн үр нөлөөг үнэлдэг цөөн тооны судалгааны хооронд үл нийцэх байдал ажиглагдаж байна.

ТӨМӨР ЗАМ

1. Төмөр замын 49 судалгааг голчлон Энэтхэг, Хятад, Монгол улсад чиглэгдсэн (мэдээллийн сангийн 63 хувь;Зураг3), мөн эдгээр орнуудын гурван тодорхой бүс нутагт (Энэтхэгт Хойд Бенгал, Хятадад Түвд, Монголын цөл, тал хээрт) төвлөрсөн болно. Судалгаанд Азийн бусад ихэнх орны төлөөлөл харьцангуй бага байсан; Энэхүү судалгаанд 28 орны 14 -ийг огт төлөөлөөгүй болно.
2. Хөхтөн амьтдын бүс төрөл зүйлийг үнэлсэн судалгааны тоо ялангуяа авто замтай харьцуулахад бага байсан (20;Зураг4). Хөхтөн амьтдын дотроос том зүйлд анхаарлаа хандуулдаг байв; Тодруулбал, төмөр замын экологийн судалгааны 61 хувийг заан, туруутан амьтад эзэлдэг. Бусад таксономийг төлөөлж чадаагүй нь хөхтөн амьтдын бүс ангилал зүйд (эсвэл жижиг хөхтөн амьтад) төмөр замын нөлөөлөл бага байна гэсэн үг үү эсвэл эдгээр нөлөөллийг илрүүлээгүй, судлаагүй эсэх нь тодорхойгүй байна. Түүнчлэн эдгээр судалгаануудын үр дүнг бусад амьтад экстраполяц үнэлгээ хийх чадвар багатай болгодог.
3. Ганц нэг амьтны хувьд жижиг цар хүрээтэй шууд ба шууд бус нөлөөллийг дор хаяж 20 зүйл (Хүснэгт 5), найман зүйлийн (Хүснэгт6), мөн зүйлийн популяцын төвшний нөлөөллийг дор хаяж 9 зүйлийн хувьд баримтжуулсан болно (Хүснэгт7). Эдгээр тоонууд нь замын тоймтой холбоотой тооноос хамаагүй бага байна. Харьцангуй цөөн тооны төмөр замын судалгааг авч үзвэл Ази дахь ан амьтад төмөр замын шууд болон шууд бус нөлөөг сайн ойлгох боломжгүй болно.
4. Галт тэрэгтэй мөргөлдсөний шууд нөлөөллийг зааны хувьд хамгийн сайн баримтжуулсан байдаг. Гэсэн хэдий ч галт тэрэгтэй мөргөлдсөний улмаас амь үрэгдсэн амьтдын популяцын мэдээлэл (жишээлбэл, нас, хүйсийн ангилал) энэ тэргүүлэх зүйлийн хувьд ч бага байна. Цаашилбал, эдгээр өгөгдлийг орон нутгийн зүйлийн популяцын хүрээнд танилцуулах нь ховор

байдаг (бид ийм судалгааг ганцхан олсон). Үүний үр дүнд амьтад галт тэрэгтэй мөргөлдөх, тухайн зүйлийн төрөл зүйлийн популяцын тогтвортой байдал хоёрын хооронд бат бөх холбоо байхгүй байна.

5. Шууд бус нөлөөллийн судалгаанууд нь төмөр зам, ялангуяа төмөр замыг хашсан эсвэл хүн суурьшсантай холбоотой саад бэрхшээлийн нөлөөлөлд төвлөрдөг. Эдгээр саад тотгор нөлөө нь нөөцийн хүртээмж өөрчлөгдсөний улмаас зэрлэг ан амьтдын нүүдэллэх чадварыг бууруулах, амьд үлдэх төвшинг бууруулдаг. Мөн тэд амьтдыг амьдрах тохиромжтой орчинд нэвтрэхэд саад болох замаар популяцын талбайг багасгадаг (Хавсралт F). Генийн урсгалд төмөр замаас үүдэлтэй саад бэрхшээлийн үр дагаврыг мөн түлхүү судалж байна (Хавсралт G).
6. Төмөр замд үзүүлэх нөлөөллийн талаарх судалгаа нь түүнийг бууруулах судалгааны ажлаас 283 хувиар илүү тархалттай байдаг (Зураг4). Гэсэн хэдий ч хүн ба амьтны зан төлөвийг (сүүлийнх нь голдуу заан руу чиглэсэн) өөрчлөх зорилготой олон төрлийн бууруулах арга хэмжээг Ази тивийн хэд хэдэн газарт төмөр замд хэрэгжүүлж байна. Эдгээр арга хэмжээг ихэвчлэн саарал баримт бичгүүдэд баримтжуулсан болно. Гэсэн хэдий ч тэдгээрийн үр нөлөөг батлах тоон үзүүлэлт байхгүй байгаа нь тэдгээрийг Ази даяар бусад орон нутагт хуулбарлах, дамжуулан хэрэглэх боломжтой эсэхийг ойлгоход хэцүү болгодог.
7. Төмөр замаар аюулгүй дайран гарах нөхцөлийг бүрдүүлэхийн тулд Ази тивд зориулалтын дагуу баригдсан хөндлөн огтлолын байгууламжийг зэрлэг ан амьтад ашиглах талаар харьцангуй цөөн судалгаа байдаг. Гэсэн хэдий ч дор хаяж 14 зүйл (Хавсралт H) ийм байгууламжийг ашиглан төмөр замын дээгүүр эсвэл доор замаар гарч байгааг баримтжуулсан. Дизайн ба байршил нь үр ашгийг тодорхойлох гол хүчин зүйл юм. Ялангуяа буруу байрлуулсан байгууламжууд нь амьтдын нэвтрэх, хөндлөн гарах замд саад болж, шаардлагатай хүч чадлын зарцуулалтыг нэмэгдүүлж болзошгүй юм.
8. Цөөн тооны судалгаануудаас харахад (голчлон саарал баримт бичгээс) нь инженерийн шалтгаанаар (ялангуяа зэрлэг ан амьтад зориулагдаагүй) баригдсан бүтэц нь зарим зүйлийн төмөр замын дээгүүр нүүдэллэх, дамжин гарах хөдөлгөөнийг хөнгөвчилдөг. Гэсэн хэдий ч бусад судалгаагаар зарим зүйлүүд (Төв Азийн туурайтан амьтад гэх мэт) эдгээр бүтцийг ашиглахаас зайлсхийх хандлагатай байдаг. Амьтад ийм бүтэц ашигладаг эсэх, дизайны онцлог шинж чанаруудыг сайн судлаагүй болно.

ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ШУГАМ

1. Шалгасан 78 баримт бичигт Азийн 11 оронд цахилгаан дамжуулах шугамын нөлөөллийг баримтжуулсан бөгөөд судалгааны 75 хувийг Энэтхэг, Хятад, Монгол, Казахстан гэсэн дөрвөн улсаас авсан байна. Баримт бичгүүдийн тоймд анхаарлаа хандуулж байсан 28 орны 10 -ыг нь баримт бичигт судлаагүй, төлөөлөөгүй болно.
2. Шувуу, хөхтөн амьтад нь цахилгаан дамжуулах шугамын талаарх баримт бичгүүдэд давамгайлж байв. Баримт судалгааны 53 хувийг зөвхөн шувууд эзэлж, 40 хувь нь хөхтөн амьтдын талаар судлагдсан байлаа.
3. Шууд нөлөөллийг дор хаяж 113 зүйлийн хувьд баримтжуулсан болно (Хүснэгт8), үүнд Азид нэн ховордсон дөрөв, нэн ховордсон 14, эмзэг бүлгийн 11, ховордох аюулд орсон долоон

зүйл. Үүний эсрэгээр шууд бус нөлөөлөл ба зүйлийн популяцын төвшний нөлөөллийг зөвхөн хоёр болон дөрвөн зүйлийн хувьд баримтжуулсан болно.

4. Шууд нөлөөллийн судалгаа нь ихэвчлэн цахилгаанд цохиулах болон мөргөлдөөний улмаас үхэж хорогдсон амьтдыг баримтжуулсан ажиглалтууд юм. Мөргөлдөөнөөс илүү цахилгаанд цохиулах нөлөөллийн талаар илүү олон судалгаа байдаг. Зөвхөн цөөн тооны судалгаанууд шууд нөлөөллийг нарийвчлан судалж, ажиглагдсан үхэл хорогдлын шалтгааныг судалсан болно.
5. Баримт судалгаанд зөвхөн шууд бус нөлөөллийн хоёр ажиглалтыг баримтжуулсан болно: Үүнд: амьдрах орчны алдагдал, хуваагдал. Цахилгаан дамжуулах шугамын шууд бус нөлөөлөлд чиглэсэн нарийвчилсан судалгаа, төрөл зүйлийн популяцад цахилгаан дамжуулах шугамын нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ огт хийгдээгүй байна.
6. Зам, төмөр замын баримт судалгааны нэгэн адил судалгааны ихэнх хэсэг нь цахилгаан дамжуулах шугамын нөлөөллийг бууруулахаас илүүтэйгээр баримтжуулахад чиглэсэн болно.
7. Хөнгөвчлөх, бууруулах байгууламжийг суурилуулах, үнэлэх нь ихэвчлэн цахилгаанд цохиулж үхсэн амьтдад чиглэгддэг. Гэсэн хэдий ч мөргөлдөөний холбоотой үхэл хорогдлыг бууруулах зорилготой янз бүрийн бууруулах арга хэмжээний үр дүнгийн талаарх мэдээлэл нь баримт судалгаануудад байдаггүй.

ЗӨВЛӨМЖҮҮД

АЗИ ДАХЬ ШУГАМАН ДЭД БҮТЦИЙН НӨЛӨӨЛЛИЙН ТАЛААРХ ИРЭЭДҮЙН СУДАЛГААНЫ ЗӨВЛӨМЖ

- I. Шугаман дэд бүтцийн гурван горим нь амьтдын шууд хорогдолд оруулсан хувь нөлөөллийг баримтжуулсан хэмжээгээр ялгаатай; Ялангуяа төмөр зам нь эдгээр үндсэн өгөгдлийг илүү их шаарддаг.

Шугаман дэд бүтэцтэй холбоотойгоор шууд үхэл хорогдлын талаарх энгийн баримт бичиг (амьтан ба тээврийн хэрэгслийн мөргөлдөөн, галт тэрэгний мөргөлдөөн, цахилгаан гүйдэлд цохиулах, цахилгааны шонг мөргөх гэх мэт) нь Ази дахь зэрлэг ан амьтдын зүйлийн популяцад шугаман дэд бүтцийн нөлөөллийг ойлгох үйл явцын чухал алхам юм. Ийм судалгаануудын хураангуй статистик нь асуудлын цар хүрээг хурдан бөгөөд өргөнөөр ойлгох боломжийг олгодог. Авто замын зэрлэг амьтдад үзүүлэх нөлөө нь одоогоор 611 зүйлийн амьтныг тээврийн хэрэгсэл-амьтны мөргөлдөөний баримт бичигт баримтжуулан оруулах үе шатанд байна. Асуудал нь сайн тогтоогдсон бөгөөд үүнийг хөнгөвчлөх, бууруулах арга хэмжээний хэрэгцээ шаардлагыг тодорхой харуулж байна. Үүний эсрэгээр Ази нь төмөр зам, цахилгаан дамжуулах шугамын зүгээс эко систем болон төрөл зүйлд үзүүлэх шууд нөлөөлөлд шинжлэх ухаанч хандлагаа нэмэгдүүлэх хэрэгтэй. Төмөр замаас үүдэлтэй зэрлэг ан амьтдын үхэл хорогдлын судалгаанууд нь эхний шатандаа явж байна; Баримтжуулсан зүйлийн тоо цөөн (20) үнэн бодит эсэх, эсвэл энэ тоо нь том хөхтөн амьтдын (заан гэх мэт) судалгааны хэв маягийг харуулсан эсэх нь одоогоор тодорхойгүй байна. Тиймээс зэрлэг ан амьтдын галт тэрэгтэй мөргөлдсөн цар хүрээг тодруулахын тулд галт тэрэгнээс амьтан ба галт тэрэгний мөргөлдөөний ослын үнэлгээг эрчимжүүлэх, нэмэгдүүлэх шаардлагатай байна. Цахилгаан

дамжуулах шугамын зэрлэг амьтдад үзүүлэх нөлөөллийн талаарх мэдлэг нь авто замтай харьцуулахад харьцангуй бага боловч төмөр замаас өндөр байдаг. Цахилгаан дамжуулах шугамын нөлөөллийг 113 зүйлийн хувьд баримтжуулсан боловч цаашид баримтжуулах нь асуудлын цар хүрээг нарийн тогтооход тусална.

2. Шугаман дэд бүтцээс үүдэлтэй зэрлэг амьтдын шууд үхэл хорогдол нь эрсдэлт хүчин зүйлсийг тодорхойлох (улмаар бүүруулах) тайлбарлагч хувьсагчтай илүү сайн хамааруулах шаардлагатай болдог.

Азийн ихэнх судалгаануудад шууд үхэл хорогдлыг баримтжуулах чанар, боловсронгуй байдал дутмаг байгаа нь тэдний олж мэдсэн зүйлийг илүү өргөн хүрээнд хэрэгжүүлэх боломжид сөргөөр нөлөөлдөг. Илүү өргөн хэрэглээнд хүрэхийн тулд нас баралтыг амьдрах орчин, амьтдын зан байдал, хүрээлэн буй орчин, замын физик шинж чанар, дэд бүтцийн загвар, дизайнтай холбоотой орон зайн хувьсагчтай холбох, уялдуулах хэрэгтэй. Тухайлбал Замын нөлөөллийн судалгаа нь гүн гүнзгий биш бөгөөд замын шалтгаант үхэл хорогдлыг энгийн байдлаар тоолоход чиглэгддэг. Судалгааны талбай дотор болон түүнээс гадна байгаль хамгаалах талаар баталгаатай дүгнэлт гаргах боломжийг бүрдүүлэхийн тулд зэрлэг ан амьтдын шууд үхэл хорогдлын талаарх судалгаа нь илүү системтэй, тайлбартай байх ёстой.

3. Зүйлийн популяцын амьдрах чадварт шууд нөлөөлөх үр дагаврыг одоогоор дэд бүтцийн гурван төрөлд сайтар судлаагүй байна.

Үхэл хорогдлыг тоон үзүүлэлтээр тайлбарласан хувьсах хэмжигдэхүүнтэй харьцуулсан ч гэсэн тэдгээр нь тухайн зүйлийн төрөл зүйлийн популяцын амьдрах чадвартай холбогдоогүй байдаг бөгөөд энэ нь ихэвчлэн төрөл зүйлийн хамгааллын гол үр дүн болдог. Ерөнхийдөө энэ нь үхэж буй амьтдын популяцын шинж чанарыг (жишээлбэл, тоо, нас хүйсийн ангилал) тухайн нутгийн зүйлийн популяцын амьтдын ижил шинж чанаруудтай харьцуулахыг шаарддаг. Гурван төрлийн шугаман дэд бүтцэд зүйлийн популяцын төвшний мэдээллийн хувьд ийм төрлийн популяцын шинж чанарыг судлах замаар хангах боломжтой эсэх нь тодорхой байна. Төрөл зүйлийн популяцын амьдрах чадвартай холбоотой өгөгдөл нь байгаль хамгааллын асуудал өндөртэй зүйлийн хувьд ч хязгаарлагдмал байсан. Жишээлбэл, зааны талаар хийсэн ганцхан судалгаанд галт тэрэгний мөргөлдөөнд илэрхийлэгдсэн хүйсийн бүлгийг тухайн нутгийн зүйлийн популяц дахь хүйсийн бүлгийн тархацтай харьцуулсан болно. Шууд үхэл хорогдлын популяцын үзүүлэлтүүдийг нутгийн төрөл зүйлийн популяцынхтай харьцуулах нь шугаман дэд бүтэц нь зүйлийн популяцын төвшинд нөлөөлж байгаа эсэхийг үнэн зөв үнэлэх, хамгаалах арга хэмжээ авах шаардлагатай байгаа төрөл зүйлийн/зүйлийн популяцыг тодорхойлоход тусална.

4. Зам, төмөр замаар гарах амьтдын хөдөлгөөнийг судлах судалгааг популяцыг авран хамгаалах шаардлага, генийн урсгал, чөлөөт байдал, амьдрах орчны хүртээмжтэй уялдуулах хэрэгтэй.

Амьтны хөдөлгөөнийг Ази даяар судалж байгаа бөгөөд ялангуяа орон зайн загварыг ашигласнаар илүү өргөн цар хүрээнд экологийн уялдаа холболтыг (эсвэл тэдгээрийн дутагдлыг) бүрдүүлдэг хэмжигдэхүүнүүдэд улам бүр өргөжиж байна. Гэхдээ авто зам, төмөр замын хувьд саад бэрхшээлийн болзошгүй нөлөөллийг зүйлийн популяцын тогтвортой байдалд үзүүлэх бодит нөлөөлөлтэй илүү сайн уялдуулах хэрэгтэй. Популяцыг авран хамгаалах арга хэмжээ болон генийн урсгалыг ихэвчлэн нэг үеийн үр дүнтэй шилжин бага

нүүдэллэгчдийн тоогоор бүрдүүлэх боломжтой. Ховордсон амьтдын эдгээр гол үндсэн босгыг тодорхойлсноор шууд үхэл хорогдлыг бууруулах, саад тотгор учруулах нөлөөллийн хоорондох зохистой тэнцвэрийг бий болгох (заримдаа зөрчилдөх магадлалтай) боломж бүрдэнэ. Ийм судалгаанууд нь амьтдын тогтвортой байдлыг хангахын тулд байгаль хамгаалах бусад арга хэмжээ (жишээлбэл, амьдрах орчныг сэргээх)-тэй харьцуулахад хөдөлгөөнийг сэргээх эдийн засгийн зардал, ашиг тусыг илүү сайн тооцоолох боломжтой болно.

5. Шугаман дэд бүтцийн шинж чанар өөрчлөгдөхөөс өмнө ба дараа стандарт хувьсагчдыг харьцуулсан судалгаа нь нотлох баримтад суурилсан хамгаалалтын үйл ажиллагаанд шаардлагатай байдаг.

Судалгааны өмнөх ба дараах зураг төсөлд шугаман дэд бүтэц эсвэл бууруулах арга хэмжээний нөлөөг нарийвчлан үнэлсэн цөөн хэдэн судалгааг бид олж мэдсэн. Нөлөөллийн хяналтын өмнө ба дараах (BACI) судалгааны загвар нь нөлөөллийг ойлгох, хөндлөнгийн оролцооны үр нөлөөг үнэлэх бат бөх тогтолцоог бүрдүүлж чадна. Хэдийгээр бууруулах арга хэмжээ нь Ази даяар амьтан, хүний зан байдлыг өөрчлөхөд чиглэсэн боловч тэдний үр нөлөөг мүү үнэлдэг. Илүү нарийвчлалтай үнэлгээ хийхгүй бол түүнийг бууруулах оновчтой арга хэмжээг тодорхойлоход хэцүү байдаг. Азийн олон янзын бүс нутгийн шугаман дэд бүтцийн нөлөөлөлд өртсөн олон төрлийн амьтдын хувьд үр дүнтэй ба үр дүнтэй бус бууруулах арга хэмжээг ялгахын тулд түршилтын ийм загварыг илүү сайн ашиглах нь нотлох баримтын бат бөх суурийг бий болгоход маш чухал юм.

6. Байгаль орчны хамгаалалтын эдийн засгийн үр ашгийг илүү нарийвчлан судлах шаардлагатай байна.

Шугаман дэд бүтцийн бүх гурван төрөлд ашигладаг янз бүрийн хөнгөвчлөх, бууруулах арга хэмжээний зардлын үр ашгийн судалгаа шаардлагатай байна. Энэ нь Азийн зэрлэг ан амьтдын идэвхгүй ашиглалтын талаарх олон цоорхой, дутагдалтай эдийн засгийн үнэлгээнүүдийг илчлэн харуулж байна. Гэсэн хэдий ч шугаман дэд бүтцийн шийдвэр гаргагчид зөвхөн суурилуулах бүтээн байгуулах, арчлан хамгаалах зардлыг бус харин бууруулах арга хэмжээний эдийн засгийн үр өгөөжийг илүү сайн ойлгож, илэрхийлэх нь чухал байдаг. Иймд дэд бүтцийн хөнгөвчлөх, бууруулах арга хэмжээний зардал, үр ашгийн судалгаа одоогоор хийгдээгүй байгаа бөгөөд энэ дутагдлыг яаралтай залруулах ёстой.

7. Авто зам, төмөр зам, цахилгаан дамжуулах шугамын хуримтлагдсан нөлөөллийг шийдвэрлэх нь ховор байдаг тул илүү нарийвчлан судлах шаардлагатай байдаг.

Авто зам, төмөр зам, цахилгаан дамжуулах шугамыг ихэвчлэн хоорондоо ойрхон байгуулдаг; Тиймээс тэдний зэрлэг амьтдад үзүүлэх нөлөө нь хуримтлагдсан эсвэл харилцан нөлөөлсөн байх нь бий. Эдгээр хуримтлагдсан нөлөөллийг бага хэмжээгээр судалсан цөөн хэдэн судалгааг бид олсон. Эдгээр горимуудын нэгээс илүү нөлөөллийг багтаасан судалгаа нь том хэмжээний загварчлалын судалгаа байх хандлагатай (жишээлбэл, амьдрах орчны алдагдал эсвэл уялдаа холболтын талаар), мөн тэдгээрийг нягтралын хувьсагч байдлаар нэгтгэн дүгнэсэн байдаг (жишээлбэл, нэг талбайн замын үрт). Жижиг хэмжээтэй нарийвчилсан судалгаа нь зэрлэг ан амьтдад ойрхон байгаа олон шугаман дэд бүтцийн горимуудын харилцан нөлөөлсөн ба шугаман бус нөлөөг ойлгоход тусална.

8. Тэмдгийн чанартай төрөл зүйлээр хийсэн судалгаа нь уялдаа холбоотой төрөл зүйлийн талаар нэмэлт ойлголт авахад тусална.

Том биетэй төрөл зүйлүүд (ялангуяа том хөхтөн амьтад) нь олон тооны шугаман дэд бүтцийн судалгааны сэдэв бөгөөд эдгээр судалгаануудын дүгнэлт нь бусад таксономийн (ихэвчлэн тэдний үхэл хорогдлыг баримтжуулснаар хязгаарлагддаг) судалгаанаас илүү баялаг (жишээлбэл, зүйлийн популяцын амьдрах чадварын хувьд) гэдгийг бид олж мэдлээ. Том хөхтөн амьтдын нэгэн адил бусад таксономийн судалгаанд илүү их анхаарал хандуулах нь байгаль хамгааллын талаар илүү өргөн ойлголт өгөх болно. Үүний нэгэн адил, тодорхой нэг төрөлд зориулан (жишээлбэл, бар) хэрэгжүүлэх хөнгөвчлөх, бууруулах арга хэмжээ нь бусад зүйлүүдэд үзүүлэх нөлөөллийг бууруулах боломжийг олгодог ч эдгээр нь бусад хөхтнүүдээр хязгаарлагддаг. Тэмдэг төрөл зүйлийн түгээмэл байдал, санхүүжилтийг ашиглах замаар бусад зэрэгцэн оршдог төрөл зүйлийн талаар мэдлэг олж авахын тулд байгаль хамгааллын илүү өргөн хүрээг олж авах боломжтой.

АЗИ ДАХЬ ШУГАМАН ДЭД БҮТЦИЙН НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ САНАЛ БОЛГОЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭ

1. Сэг зэм удаан хадгалагдах байдлыг авч үзэхийн тулд сэг зэмийн тоог тооцох шаардлагатай байна.

Азид шугаман дэд бүтцийн дагуу амьтны сэг зэм удаан хадгалагдах байдлыг судалсан цөөн хэдэн судалгаанаас харахад бүх гол төрөл зүйлийн хувьд сэг зэм хэдэн цаг эсвэл хэдэн өдрийн дотор алга болдог бөгөөд энэ нь зам дээрх амьтдын сэг зэмийн тоог бүрэн тооцох боломжгүй гэдгийг харуулж байна. Энэхүү зөрүүтэй утгыг судалгааны дизайнаар тодорхой хэмжээгээр бууруулах боломжтой боловч ирээдүйн тооцооллыг сайжруулахын тулд залруулах хүчин зүйлсийг боловсруулах нь чухал юм.

2. Хяналтын технологид суурилсан арга хэмжээг илүү нарийвчлан судлах шаардлагатай байна.

Технологид суурилсан бууруулах арга хэмжээг (жишээлбэл, лидар, радар, эсвэл бичил долгионы тусламжтайгаар амьтан илрүүлэх систем) дэлхийн зарим хэсэгт хэрэгжүүлсэн бөгөөд Азид түршин шалгахыг зөвлөж байна. Гэхдээ бид Азид эдгээр арга хэмжээнд ямар нэгэн түршилт шалгалт бараг хийгдээгүй гэдгийг олж мэдлээ. Бодит талбайн нөхцөлд эдгээр хөндлөнгийн оролцоог үнэлэх нь Азийн нөхцөлд тэдний зардал, ашиг тусыг ойлгоход ихээхэн тус болно.

3. Бусад зориулалтаар баригдсан барилга байгууламжийг амьтан зам хөндлөн гарах зорилгоор сэргээн засварлах нь шинжилгээ, судалгааны чухал хэсэг юм.

Зэрлэг амьтдад зориулагдаагүй бүтцийг ашиглан дор хаяж 30 зүйлийн зам, төмөр замын хөндлөн огтлолцлыг баримтжуулсан болно. Энэ нь дор хаяж зарим зүйлийн хувьд одоо байгаа бүтэц нь амьдрах орчны уялдаа холбоог хангах, саад бэрхшээлийг багасгах зорилгыг хангаж байна. Ийм бүтцийг сайжруулах талаар тодорхой дүрэм, протокол боловсруулж, бүтцийг ашигладаг төрөл зүйлийг судалснаар амьтны хөдөлгөөнийг хямд боловч үр дүнтэй байдлаар хөнгөвчилж, барилгын төслийг хүлээхгүйгээр одоо байгаа шугаман дэд бүтцэд ашиглаж, хэрэгжүүлж болно.

4. Шугаман дэд бүтцийн талаарх англиас бусад хэл дээрх нийтлэлүүдийг судлах нь шинэ санаа, мэдлэгийг нээж өгнө.

Бид шугаман дэд бүтцийн талаар англиас бусад хэлээр (ялангуяа хятад, япон, солонгос хэлээр) нэлээд олон тооны хэвлэл, баримт бичигтэй таарсан боловч тэднээс тийм их мэдээлэл олж авч чадаагүй юм. Эдгээр орнуудад одоо байгаа болон төлөвлөж буй томоохон дэд бүтцийг харгалзан үзвэл эдгээр баримт бичгийг судлахад чиглэсэн туслах судалгаа нь Ази дахь англи хэл дээрх сэтгүүлүүдийн мэдлэгийн санд хэрэгтэй нэмэлт болно.

5. Азийн авто зам, төмөр зам, цахилгаан дамжуулах шугамын нөлөөллийг бууруулах арга хэмжээ, стандарт бүхий гарын авлага нь мэргэжилтнүүдэд зориулсан тусгай гарын авлагыг санал болгож болно.

Хэд хэдэн анхан шатны удирдамжийг саяхан боловсруулсан. Жишээлбэл, нэг нь барын ландшафт, нэг нь Ази дахь нэгэн авто замд зориулагдсан. Түүнчлэн, мэргэжилтнүүдэд зориулсан одоо байгаа стандартыг ихэвчлэн Хойд Америкийн агуулгаар боловсруулсан болно. Ази тивд үзүүлэх хор хөнөөлийг бууруулах арга хэмжээг төлөвлөхөд эдгээр удирдамжийг мөн ашигладаг болохыг бид олж мэдсэн. Мэдлэгийн асар их нөөцөөс ашиг тустай, гэхдээ Азийн төрөл зүйл, нөхцөл байдалд тохирсон шийдлүүдийг боловсруулсан удирдамж боловсруулах нь шугаман дэд бүтцийн мэргэжилтнүүдэд баттай зөвлөмж өгөхөд ихээхэн тус болно.

6. Азийн шугаман дэд бүтцийн талаарх судалгааны өгөгдлийг харилцан мэдээлэл солилцох байдлаар хуваалцаж, дүрслэн харуулдаг онлайн платформ нь мэргэжилтнүүдэд хэрэгтэй төлөвлөлтийн хэрэгсэл болж чадна.

Бидний олж мэдсэн шугаман дэд бүтцийн талаарх олон тооны судалгаанууд (хянан шалгасан судалгаа болон баримт нотолгоогүй судалгаа) хоёуланг нь нэг дор цуглуулаагүй болно. Илүү чухал зүйл бол эдгээр судалгааны үндсэн статистикууд (жишээлбэл, өөр өөр зүйлийн мөргөлдөөний төвшин) эдгээр судалгааны дотор ихэвчлэн текст хэлбэрээр үлддэг. Эдгээр статистик мэдээллийг онлайнаар дүрслэх платформ дээр гаргаж, дүрслэн үзүүлж, шинэ судалгаанд нэмж оруулснаар мэргэжилтнүүд шинэ дэд бүтцийн орон зайн төлөвлөлтийн ашигтай хэрэгсэлд хандах боломжтой.

7. Хөндлөнгийн нөлөөллийг бууруулах янз бүрийн арга хэмжээ нь Азийн янз бүрийн оронд өргөн тархсан байдаг бөгөөд энэ нь сургалт, мэдээлэл солилцох боломжийг олгодог.

Өөр өөр орны туршлага, санаа бодлоо хуваалцах албан ёсны эсвэл албан бус боломжийг бий болгосноор хэрэгжүүлэх шилдэг туршлагууд, аргуудыг тодорхойлж, хуулбарлах боломжтой. Жишээлбэл, Энэтхэгт амьтан (голдуу заан) болон хүний зан төлөвийг өөрчлөх арга хэмжээ зонхилж байна. Херпетофаунд зориулсан гарцын байгууламжийн туршилтын үнэлгээг Хятадад түлхүү хийдэг, Өмнөд Солонгос нь гарцын байгууламжийн төлөвлөлтийг онцлон үздэг, Шри Ланка улсад сармагчинууд цахилгаанд цохиулах өвөрмөц шийдлийг боловсруулж байна. Мэргэжил нэгтгүүдийн мэдээлэл солилцооны форум нь мэргэжилтнүүд эдгээр арга хэмжээг өөрийн улс оронд хэрэгжүүлэх, хэрэгжүүлэх боломжтой эсэхийг судлах боломжийг олгодог.

ТАЛАРХАЛ

Зөвлөгөөний экологич Адитья Гангадаран нь авто зам, төмөр замын талаарх баримт судалгааны тойм, сонирхсон төрөл зүйл, таксономын талаарх хэсгийн гол зохиогч байв. Зөвлөх экологич Чайтаня Кришна нь цахилгаан дамжуулах шугамын баримт судалгааны тоймыг тэргүүлэх зохиогч байв. Том хэмжээний ландшафтыг хамгаалах төвийн (CLLC) Мелисса Бүтински уг аргыг боловсруулж, бүх гурван тээврийн хэрэгслийн анхны хянагдсан баримт бичгийн хайлтыг хийсэн бөгөөд хайлт бүрийн статистикийг нэгтгэсэн Грейс Стоунифер (CLLC) -ээр дэмжигдсэн. Эдгээр зохиогчдоос гадна тайланг Тони Клевенгер (Баруун Тээврийн Институт [WTI]), Роб Амент (CLLC/WTI) нар бэлтгэсэн.

ИШЛЭЛ МАТЕРИАЛУУД

- Akrim, F., Mahmood, T., Andleeb, S., Hussain, R., & Collinson, W. J. (2019). Spatiotemporal patterns of wildlife road mortality in the Pothwar Plateau, Pakistan. *Mammalia*, 83(5), 487–495. <https://doi.org/10.1515/mammalia-2017-0101>
